

ОРЧИН 21

МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО



2-9 ЦАГ ҮЙЛ ЯВДАЛ

мэндчилгээ




10-49 МЭДЭЭЛЭЛ

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛӨӨС МЭДЭЭЛЛЭЖ БАЙНА



50-62 ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ

ТАНЫ УНДНЫ УС ТАНЫ ӨВЧЛӨЛД
НӨЛӨӨЛДӨГ БОЛОВ УУ?



63-66 ЯРИЛЦЛАГА

УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖИЙГ
МОНГОЛД АНХ УДАА НЭВТРҮҮЛЛЭЭ



67-68 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

"МОНТС" ХХК



69-78 ХУУЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

УСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВЬ
ХЭМЖЭЭГ ТОГТООХ, ХӨНГӨЛӨХ ТУХАЙ



79-82 ЭРҮҮЛ МЭНД

НАЙМДУГААР БҮЛЭГ

БИЕ МАХБОД УС НЭХЭХ НЬ

ОРЧИН 21

ЭРХЛЭГЧ:

Б.Пүрэвжав

/Монгол улсын аж үйлдвэрийн
гавьяат ажилтан, Техникийн ухааны
мастер, МУ-ын зөвлөх инженер/

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Д.Басандорж /МУШУТИС/

С.Дагвадорж

/Таван Өндөр ХХК-ийн захирал/

МЕНЕЖЕР:

Б.Алтантуул

ДИЗАЙНЕР:

Б.Мөнхцацрал

СЭТГҮҮЛЧ:

Б.Баяртогтох





МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 83 жилийн ой, Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын ажилтан, ажилчдын өдрийг тохиолдуулан салбарын үе үеийн ахмадууд, нийт ажилтан, ажиллагсад, энэ салбартай хамтран үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд Та бүхэнд Нийтийн Аж Ахуй Үйлчилгээний ажилчдын баярын мэндийг хүргэе.

Хот суурин байгуулагдан, хүн ам төвлөрч, орон сууцны хорооллууд баригдаж энэ үйлчилгээний хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэн та бүгдийн үүрэг хариуцлага тэр хирээр өсөн нэмэгдэж, ард иргэдэд ажиллаж амьдрах аятай тухтай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэр үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинг хамгаалах замаар улс орны эдийн засаг, нийгмийг бүхэлд нь хөгжүүлэхэд манай салбар, та бүхэн маань үнэтэй хувь нэмрээ оруулсан бөгөөд оруулсаар ч байна.

Нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн орчинг боловсорнгуй болгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор олон улсын банк санхүүгийн байгууллага, донор орнуудын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн төслүүдийн зээл, зээлийн хүүгийн асуудлыг шийдвэрлэхээр Засгийн газрын 2014 оны 129 дугаар тогтоолыг батлуулан мөрдөн ажиллаж байна.

Улс орныхоо бүтээн байгуулалтын их үйлс, 2014-2015 оны өвлийн их ачааллыг амжилттай даван туулж, инженерийн барилга, байгууламжийн хэвийн үйл ажиллагааг ханган, өөрсдийн мэдлэг чадвар, оюун ухаанаа дайчлан хөдөлмөр бүтээлээ зориулж, иргэд, оршин суугчдын ажиллаж, амьдрах ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх нэр хүндтэй, хариуцлагатай ажилдаа улам их амжилт гарган ажиллахыг та бүгдэд хүсье.

Та бүхэнд салбарын түүхт 83 жилийн ой, Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын ажилчдын баярын мэндийг дахин дэвшүүлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНЫ ТЭРГҮҮН

Жамъянсүрэнгийн БАТСУУРЬ



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 83 жилийн ойг тохиолдуулан салбарын хөгжилд мэдлэг боловсрол, хүч хөдөлмөрөө зориулсан үе үеийн ахмадууд, ажил үйлсийг нь залгамжлан үр бүтээлтэй хөдөлмөрлөж байгаа нийт ажилтан ажиллагсад Та бүхэндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Иргэдийн ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэхэд тус салбарын ажил, үйлчилгээ нэн хариуцлагатай чухал үүргийг гүйцэтгэж ирсэн, одоо ч гүйцэтгэсээр байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Иргэдийг тохилог орон сууцаар хангах, орон сууцны зээлийн тогтолцоог шинэчлэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-д Ипотекийн зээлийн хүү жилийн 8 (±1) хувь, аймаг, орон нутагт баригдсан, дэд бүтцийн шийдэл бүхий амины орон сууцыг худалдан авах болон орон сууц шинээр барьж буй иргэдэд 7(±1) хувийн зээл олгох нэмэлт, өөрчлөлтийг оруулж, 2014 оны 151 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан.

Дээрх арга хэмжээний үр дүнд 2013-2014 онуудад 72,0 мянган иргэн ипотекийн зээлд хамрагдсан. Тухайлбал, 2013 онд нийтдээ 30,0 гаруй мянган иргэнд 1,2 их наяд төгрөгийн ипотекийн зээл олгосон бол 2014 оны эхний 8 сарын байдлаар орон сууц шинээр худалдан авахыг хүссэн 22919 иргэнд 1,3 их наяд төгрөгийн зээл шинээр олгож, 18644 зээлдэгчийн нийт 539,1 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг дахин санхүүжүүлж, 8 хувийн хүүтэй ипотекийн зээл рүү шилжүүлсэн байна.

2012 онд 11453 айлын орон сууц, 2013 онд 20300 айлын орон сууц, 2014 оны эхний хагас жилийн байдлаар 12000 гаруй айлын орон сууц ашиглалтад орсноор нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээний цар хүрээ улам өргөжин тэлж байгааг энд цохон тэмдэглэхийг хүсч байна.

Түүнчлэн Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг иргэдэд урт хугацаат орон сууцны зээл олгоход зориулах, барилгын салбар болон хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор “Нийгмийн даатгалын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, “Орон сууцны тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, “Амины орон сууцны хөтөлбөр” болон “Түрээсийн орон сууцны хөтөлбөр”-үүдийн төслүүдийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд байна.

Хотуудын ус хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийх, дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хот, аймаг, суманд хэрэгжүүлэх зорилгоор аймгийн төвүүдэд баригдах 1000 айлын орон сууцны инженерийн дэд бүтцийн ажлыг Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Булган, Орхон, Төв, Сүхбаатар зэрэг 18 аймгийн төвүүдэд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж, Хан-Уул дүүргийн Нисэх, Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжуудыг өргөтгөн технологийн шинэчлэлтийг хийж заримыг нь ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор олон улсын банк санхүүгийн байгууллага, донор орнуудын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн төслүүдийн зээл, зээлийн хүүгийн асуудлыг шийдвэрлэхээр Засгийн газрын 2014 оны 249 дугаар тогтоолыг батлуулан мөрдөн ажиллаж байна.

“Сумын төвийн шинэчлэл” төслийг Архангай, Булган, Баян-Өлгий, Ховд, Завхан, Увс, Төв, Сэлэнгэ, Хэнтий, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Говь-Алтай, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар аймгуудын 16 суманд, гадаадын хандивлагчдын зээл, тусламжаар 12 аймгийн 20 суманд нийт 36 суманд инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн барилга байгууламжийг шинээр барихын зэрэгцээ, сумдад ажиллах мэргэжилтэн бэлтгэх үе шаттай сургалтыг ШУТИС болон төсөл хэрэгжүүлэх нэгжүүдтэй хамтран зохион байгуулан ажиллаж шинэ залуу боловсон хүчнээр эгнээгээ тэлж байгаадаа баяртай байна.

Хүний төлөө, тэдний сайн сайхан ажиллаж амьдрах ая тухтай ирээдүйг бүтээлцэж байгаа нэр хүндтэй, хариуцлагатай ажил үйлсдээ улам их амжилт гаргана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Сайн үйлс дэлгэрэх болтугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, БАРИЛГА,

ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД

Ц. БАЯРСАЙХАН



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад Нийтийн аж ахуйн салбар үүсч бий болсон цагаас өнөөг хүртэл ард иргэдийнхээ сайн сайхны төлөө хөдөлмөр, сэтгэлээ зориулан тасралтгүй үйл ажиллагаа явуулж, тус салбарыг өргөжин хөгжихөд үнэтэй хувь нэмэр оруулж буй Нийтийн аж ахуйн салбарын үе үеийн ахмадууд, ажил үйлсийг нь залгамжлан үр бүтээлтэй хөдөлмөрлөж байгаа нийт хамт олондоо салбар үүсч, хөгжсөний 83 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын хүн амыг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэр, бохир усны шугам хоолойн шинэчлэл, засвар, үйлчилгээг цаг алдалгүй хийж, түүний бүрэн бүтэн байдлыг хангах, тулгамдсан асуудлуудыг яаралтай шийдвэрлэх зэрэг ард, иргэдийн өмнө хүлээсэн асар өндөр хариуцлагаа бид ухамсарлан ажиллаж байна.

Тус салбарт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий 129-д байгууллага, аж ахуйн нэгж 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа билээ. Усны үйлчилгээний үнэ тарифыг бараа материалын үнийн өсөлт, инфляцтай уялдуулан тухай бүр өөрчилж байгаагүйгээс сүүлийн жилүүдэд салбарын байгууллагуудын эдийн засгийн байдал хүндэрч, зардлаа нөхөх хэмжээнд хүрч чадахгүй болж, алдагдал жилээс жилд өсөн нэмэгдэж, улмаар шугам сүлжээний урсгал засвар үйлчилгээг шаардлагын түвшинд хийж чадахгүй, техник технологийн шинэчлэлт хийх, өр төлбөр барагдуулах хуримтлал бий болоогүйгээс урт хугацааны өр бий болж, үйлчилгээний найдвартай ажиллагаа алдагдахад хүрч байгаа нь бидний өмнө тулгамдаж байгаа нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлын нэг болж байна.

Үүний үндсэн дээр бид 2014 онд хүн ам, аж ахуйн нэгж байгууллагыг цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг зах зээлийн нөхцөлд алдагдалгүй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үйлчилгээний үнэ, тарифыг бодит зардалтай нь уялдуулан, хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг тэнцвэртэйгээр хамгаалах зарчимд үндэслэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор эхний ээлжинд Улаанбаатар хот болон Төв аймгийн усны үнэ, тарифыг шинэчилэн батлаж, мөрдүүлсэн.

Цаашид ирэх 2015 ондоо хот суурин газрын хүн амын амин чухал хэрэгцээ болсон нийтийн аж ахуйн үйлчилгээг орчин үеийн хэрэгцээ шаардлагын түвшинд хөгжүүлэн, үйлчилгээндээ олон улсын стандартыг нэвтрүүлэн ажиллах үндсэн зорилтын дагуу далайцтай ажлуудыг зохион байгуулж, салбарын тулгамдаад буй асуудлуудыг оновчтой шийдвэрлэн, 2014 онд гаргасан ажлын амжилтаа ахиулан ажиллахыг зорих болно.

Иймд салбарын нийт ажилтан, ажиллагсад Та бүхэндээ 2014-2015 оны өвлийн их ачааллыг амжилттай даван туулж, инженерийн барилга, байгууламжийн хэвийн үйл ажиллагаа болон ард иргэдийн ая тухтай байдлыг найдвартай ханган ажиллана гэдэгт бат итгэлтэй байна.

Та бүхэндээ салбарын түүхт ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, аз жаргалын дээдийг хүсэн ерөөж байна.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЭРДЭНЭЧИМЭГ



МЭНДЧИЛГЭЭ

Орон сууц нийтийн аж ахуйн ажилчдын баярын өдрийг тохиолдуулан тус байгуулагад ажиллаж байсан ахмад үеийнхэн болон нийт ажилтнууд та бүхэндээ хувиасаа болон байгууллагынхаа нэрийн эмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Орон сууц нийтийн аж ахуйн байгууллага үүсэн бий болсон цагаасаа эхлэн олон мянган оршин суугчдыг тав тухтай амьдарч, ажиллах нөхцлийг хангах эрхэм үүргээ нэр төртэйгээр биелүүлэхийн төлөө бүх хүч бололцоогоо дайчлан, байнгын бэлэн байдалд тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж ирсэн ба энэхүү түүхэн замналыг хойч үеийнхэн улам баяжуулж, хөгжүүлж байх үүрэгтэй билээ.

Улс орон хөгжихийн хирээр манай иргэдийн амьдралын түвшин дээшилж ахуйн амьдралдаа шинжлэх ухааны ололт амжилтыг тусгасан илүү дэвшилтэт техник технологи, орчин нөхцлийг шаардах болсон юм.

Нийслэл хот өдрөөс өдөрт өнгөжин жавхаажиж орчин үеийн шийдэл бүхий тохилог орон сууц, ахуйн үйлчилгээний барилга байгууламж олноор баригдаж иргэд оршин суугчдын амьдрах нөхцөл бололцоо улам сайжирч байна.

Энэ хүрээнд Шинэчлэлийн Засгийн газар болон Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө нь олон шинэлэг, өргөн цар хүрээ бүхий асуудлуудыг тусгаж, хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бүрэн дүүрэн хангасан ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн Орон сууц нийтийн аж ахуйн салбарын бүтэц зохион байгуулалтанд өөрчлөлт орж, ХҮТ / хэрэглэгчдэд үйлчлэх төв/-ийг шинээр байгуулан ажиллаж эхэллээ.

Энэ их бүтээн байгуулалтанд бүтээлч хөдөлмөр, хичээл зүтгэлээрээ жинтэй хувь нэмэр оруулж ариун үйлсийн тэргүүн эгнээнд хошуучлагч та бүхнээрээ бахархаж байгаагаа энэ ялдамд илэрхийлье

Орон сууц нийтийн аж ахуйн системд ажиллаж байгаа хөдөлмөрийн хамт олон та бүхэнд ажил хөдөлмөрийн өндөр амжилт, эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦ НИЙТИЙН

АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА

Ч.БЯМБАЖАВ



МЭНДЧИЛГЭЭ

Монголын Нийтийн Аж Ахуйн их бүтээн байгуулалт ард иргэдийнхээ ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг хангахын төлөө 83 жил цуцалтгүй хөдөлмөрлөсөн Нийтийн аж ахуйн үйлчилгээний үе үе ажиллагсад, инженер техникийн ажилтан, ахмадууд та бүхэндээ Нийтийн Аж Ахуй үүсэж хөгжсөний 83 жилийн ойн баярын мэнд хүргэе.

Өнгөрсөн жилүүдэд та бүхэн ард иргэдийг чандмань эрдэнэ болсон цэвэр усаар тасралгүй ундаалж, хог хаягдлыг шантралгүй цэвэрлэж, орон сууцны оршин суугчдын дулаан цахилгаанаар хангаж, эх хотоо гэрэлтүүлэн ард иргэдийг ая тухтай амьдрах боломжийг нь бүрэн хангаж, шугам сүлжээний засвар үйлчилгээг шуурхай чанартай хийж гүйцэтгэсээр ирсэнийг ард түмэн онцгойлон үнэлж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Ийнхүү нийгэм, ард иргэдийн сайн сайхны төлөө нигүүлсэнгүй сэтгэл, мятаршгүй хөдөлмөрөө зориулан явсаар 83 дахь намартайгаа золгож буй Монголын Нийтийн Аж Ахуйн үйлчилгээний салбарын нийт ажиллагсадын ариун цагаан хөдөлмөр Монгол улсынхаа хөгжил цэцэглэлтийн түүхийн нэгэн алтан хуудас болон үлдэж байна. Тэрхүү түүх, намтар дүүрэн хуудсыг бичэн мөнхөлж буй та бүхэндээ баяр хөөр дүүрэн мэндчилж байна.

Та бүхний ажил хөдөлмөр эгнэгт амжилт бүтээлээр дүүрэн, амьдрал тань аз жаргалаар бялхам байхын ерөөл дэвшүүлье.

“ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ОНӨХК-ИЙН

ЗАХИРАЛ

Р.ГАНТУЛГА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэлд:

"XIX.4. Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлт, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 43-т тусгагдсан "Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах төсөл"-ийн хэрэгжилтийг зохион байгуулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл нарт тус тус даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 5 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

“Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий
журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

1) “1.3¹. Аймаг, сумын төвийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан, дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга)-ийн шийдэл бүхий амины орон сууцыг худалдан авах иргэд болон хот төлөвлөлт, барилгын норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн өөрийн өмчлөлийн газар дээр амины орон сууц шинээр барьсан иргэдэд энэхүү зээлийг олгоно.” гэсэн заалтыг нэмэх;

2) 2.1 дэх хэсэгт “Зээлээр худалдан авах” гэсний дараа “нийтийн зориулалттай” гэж нэмж, уг заалтаас “... шинэ...” гэснийг хасах;


3) 2.3 дахь хэсгийн “... жилийн 8 (± 1) хувь” гэсний дараа “, аймаг, сумын иргэдийн хувьд 7(± 1) хувь” гэж нэмэх;

4) 2.11 дэх хэсгийн “Банк ” гэсний дараа “амины болон нийтийн зориулалттай орон сууцны” гэж нэмэх;

5) 3.2.1 дэх заалтаас “...зөвхөн...” гэснийг хасаж, “... орон сууц” гэсний дараа “эсхүл аймаг, сумын төвийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан, дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга)-ийн шийдэл бүхий амины орон сууц мөн хот төлөвлөлт, барилгын норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн тухайн иргэний өөрийнх нь өмчийн газар дээр баригдсан, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй, дэд бүтэц (ус, дулаан, цахилгаан, ариутгах татуурга)-ийн шийдэл бүхий амины орон сууц” гэж нэмэх;

6) 3.2.2 дахь заалтын “нийт...” гэсний өмнө “нийтийн зориулалттай орон сууцны хувьд” гэж нэмэх;

7) журмын 2.13 дахь заалтыг хасах.



Монгол Улсын Ерөнхий сайд

Барилга, хот байгуулалтын сайд

Н.АЛТАНХУЯГ

Ц.БАЯРСАЙХАН




МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэлд:

"ХҮ.1. ХЭЛЭЛЦСЭН нь: Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцээд, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган хуулийн үзэл баримтлалыг батлан, хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэлд:

"ХИҮ.4. Засгийн газрын үнэт цаасны санхүүжилтээр инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээг нь барьсан орон сууцны барилгын нийт талбайн тодорхой хувийг төрийн эзэмшилд шилжүүлэн авч иргэдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын талаар Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан цаашид инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээг барих хөрөнгө бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаасны санхүүжилтээр инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээг нь барьсан орон сууцны барилгын нийт талбайн тодорхой хувийг төрийн эзэмшилд шилжүүлэн авах оновчтой хувилбарыг судлан боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгав." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 8 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 249

Улаанбаатар
хот

Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын
талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжсэн "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх 1, 2 дугаар төсөл"-ийн дамжуулан зээлдүүлэх нөхцөлийг өөрчлөх, зээл төлөх хугацааг дотооддоо сунгах, зээлийн хүүг бууруулах, зээлийг төгрөгт шилжүүлэх, ханшийн эрсдэлийг төсөвт тусгах зэргээр зээлдэгчид үүсэх дарамтыг үе шаттайгаар бууруулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай.

2. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газарт хэрэгжсэн төслүүдийн зээл, зээлийн хүүг төлж барагдуулах асуудлаар салбар дундын ажлын хэсэг байгуулан холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-үүл нарт үүрэг болгосугай.

3. Одоо хэрэгжиж байгаа болон хэрэгжээд дуусч байгаа төслүүдийн зээл, зээлийн хүүг дамжуулан зээлдүүлэх гэрээнд тусгасны дагуу үе шаттайгаар төлж барагдуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, эрхзүйн орчинг боловсронгуй болгох, санхүүгийн чадавхийг дээшлүүлэн усны үйлчилгээний тарифын тогтолцоог шинэчлэх, төслүүдийн үр дүнг тооцон, хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

Барилга, хот байгуулалтын сайд

Ц.БАЯРСАЙХАН

Сангийн сайд

Ч.УЛААН



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Манай улсын хувьд орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох нь нэг талаас барилгын салбарын үйлдвэрлэл, орон сууцны нийлүүлэлтийг дэмжих хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, санхүү, зээлийн үйлчилгээний шинэлэг хэлбэрүүдийг бий болгох, нөгөө талаас стратегийн хөрөнгө оруулалтыг татах замаар банк, санхүүгийн байгууллагуудын дунд өрсөлдөөнийг бий болгох, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг бий болгох санхүүгийн арга механизмыг бүрдүүлж, хөгжүүлэх шаардлага тулгараад байна.

Дэлхийн олон оронд хүн амыг орон сууцаар хангах асуудлыг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн арга механизмыг ашиглан шийдвэрлэсэн байдаг байна. Манай улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл үүсч, хөгжиж эхэлж байгаатай холбогдуулан төрийн зүгээс дэмжих шаардлага чухлаар тавигдаж байна.

Улсын Их Хурлын 2002, 2010 оны чуулганаар хэлэлцэгдэж батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль, “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай” хуулиудтай нийцүүлэн манай улсад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд нэн чухал хүчин зүйл болох дотоодын хөрөнгө оруулалтын тогтолцоог бий болгох харилцааг зохицуулах шаардлагатай байна.

Энэхүү зах зээлийг хөгжүүлэх нь зөвхөн хүн амыг орон сууцаар хангах асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөөд зогсохгүй үүний цаана барилгын салбарын хөгжлийн асуудал хамт хөндөгдөж, энэ салбарыг дагаад зам, тээвэр, холбоо, үйлдвэрлэл, худалдаа хөгжих нөхцөл бүрдэж, цаашлаад ажлын байр нэмэгдэх баталгаа бий болж байгаагаараа эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал ач холбогдолтой.

Иймд “Нийгмийн даатгалын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан бөгөөд тус хуулинд өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

Энэхүү хуульд холбогдох өөрчлөлтийг оруулснаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах нь нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөс банкинд байршуулж тодорхой хугацаанд хүүгийн хамтаар буцаан авахтай адил нийгмийн даатгалын хөрөнгийг нэмэгдүүлэх санхүүгийн үйл ажиллагаа бөгөөд эдийн засгийн хувьд үр нөлөө ихтэй юм. Тус сангийн хөрөнгийг банкинд байршуулснаар тухайн нэг банк хадгаламжийн эх үүсвэртэй болж олон төрлийн зээл олгодог, харин хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авсан тохиолдолд уг үнэт цаасыг баталгаажуулж буй чанартай орон сууцны зээл олгосон хэд хэдэн банкууд нэгэн зэрэг эх үүсвэртэй болох боломж бүрдэнэ.

Ингэснээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эргээд иргэдэд урт хугацаат орон сууцны зээл олгоход зориулах, барилгын салбар болон хөрөнгийн зах зээлийг мөн дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг банкинд байршуулах нь тухайн банкны эрсдэлээс хамаардаг бол хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эрсдэл нь холбогдох хууль тогтоомж болон олон шатлалт санхүүгийн арга хэрэгслээр хамгаалагддаг. Тухайлбал Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль мөн Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоодог заавал хангавал зохих шалгуур, шаардлага, зохистой харьцаа, эрсдэлээр жигнэсэн хувь зэргийг тогтоосон эрх зүйн актад заасан шаардлагыг хангуулдаг нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эрсдэлийг бууруулдаг.

Мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хамгийн сайн чанартай орон сууцны зээлээр баталгааждаг ба хэрэв тухайн зээл эргэн төлөгдөхгүй болсон тохиолдолд үнэт цаас гаргагч өөр чанартай зээлээр солих буюу мөнгийг төлөх үүрэг ногдуулах, эсвэл үнэт цаас гаргагч өөрөө эрсдэлд орсон тохиолдолд үнэт цаасны төлбөрийг төлөх үүрэг нь үйлчилгээ үзүүлэгч банкинд буюу орон сууцны зээл олгосон банкинд шилжих, мөн банк эрсдэлд орсон тохиолдолд тухайн зээлийг өөр банкинд шилжүүлж үнэт цаасны төлбөрийг хэвийн журмаар төлүүлэх, барьцаа хөрөнгийн болон зээлдэгчийн амь насны даатгал гэх зэрэг олон төрлийн санхүүгийн арга хэрэгслээр дамжуулан эрсдэлээс хамгаалагддаг байна.

Дээр дурьдсан маш олон давуу тал мөн амьдралаас урган гарч буй хэрэгцээ шаардлагаас үндэслэн энэхүү хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгаа бөгөөд хуулинд өөрчлөлт орсоноор барилгын салбар, тэр дундаа иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийн үр өгөөж асар их нэмэгдэх бөгөөд үүнийг дагаад эдийн засагт ч мөн эерэг үр дүн үзүүлэх ач холбогдолтой юм.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗАР

Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан ОРОН НУТАГТ АЖИЛЛАЖ БАЙНА

Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт ажиллахаар орон нутгийг зорилго.

Тэрбээр Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сум” төслийн явцтай танилцах юм байна.

Хэнтий аймгийн Биндэр, Дорнод аймгийн Баян-Уул, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд “Шинэ сум” төсөл хэрэгжиж байгаа юм.

Үүний зэрэгцээ дээрх аймгуудад хэрэгжүүлж буй “1000” айлын орон сууц” хөтөлбөрийн инженерийн шугам сүлжээ буюу суурь дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил хэрхэн явагдаж байгааг шалгана.



Мөн Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан Төв аймагт ажиллаж, Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 1000 айлын орон сууц хөтөлбөрийн явц, тус аймаг дахь инженерийн шугам сүлжээ зэрэг төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудтай танилцаа. Түүнчлэн “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөрт хамрагдсан Лүн суманд хийгдэж буй ажил, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Бүрэн сум, Зуунмод хотын Зүүндэлгэр багт хэрэгжиж байгаа цэвэр бохир усны шугмын ажлын талаар мэдээлэл авлаа.

Төвийн бүсийн тулгуур төв, Төв аймгийн Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК, Герман Улсын “RSAA” компанитай хамтран боловсруулжээ. Төв аймгийн хөгжлийн гарц хамтын ажиллагааг Шинэ Зуунмод хот, Шинэ нисэх буудлын төсөл, Эх газрын боомт, эдийн засгийн нээлттэй бүс, Майдар эко сити, Улаанбаатар дагуул хот гэдэг байдлаар тодорхойлж байна.

Төв аймагт 1000 айлын орон сууц хөтөлбөр эхэлж, барилга, угсралтын “Бүти” компани 980 айлын орон сууцны хороолол барьж эхэлжээ. Үйлчилгээ, нийгэм ахуйн барилга бүхий цогц хорооллын үнийг гүйцэтгэгч компани орон нутагтай тохирсоны үндсэн дээр тогтоох бөгөөд үнийг 1 сая

төгрөг дотор тогтоох боломжтой талаар салбарын сайддаа танилцууллаа. “1000 айлын орон сууц” хөтөлбөр хэрэгжих газрыг чөлөөлж, жил гаруйханы дотор эхний 100 айлын орон сууцыг барьжээ.

Төв аймгийн Засаг дарга Д.Баярбат шинэ хороолол болон инженерийн шугам сүлжээ, гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх газруудаа үзүүлээ.

“Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөрт хамрагдсан Лүн суманд хатуу хучилттай зам, явган хүний зам, гэрэлтүүлгийн хамт тавигдсан. Сургууль, цэцэрлэг, сумын тамгын газар, соёлын төвийг нэг өнгө загварын фасадтай болгосон. Удахгүй гүйцэтгэгч компани цэвэр, бохир усны шугмын ажлыг хийнэ гэв. Харин Бүрэн сумын тухайд НҮБХХ-ийн санхүүжилтээр ажил хийгдэж байна. Цэвэр ус, гадна бохирын ус, цэвэрлэх байгууламжийн ажил, гадна дулааны шугам 90-100 хувьтай яваа гэж байв. Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж МОН 13/302 НҮБХХ-ийн төсөл Зуунмод хотын Зүүндэлгэр багт хэрэгжиж байгаа. Тус багийн дунд сургуулийн халаалтыг төслийн шугмаар газрын гүний дулаан ашиглан шийдсэнтэй сайд Ц.Баярсайхан танилцав.



Төв аймгийн хувьд бүтээн байгуулалтын ажил эрчимтэй хийгдэж байна. Улаанбаатар хоттой ойролцоо байршилтай ч төсвийн хөрөнгө оруулалт, бусад эх үүсвэрийн санхүүжилт орхигдож унтаа байдалд байсан аймагт ажил өрнөж байгаад Ц.Баярсайхан сайд орон нутгийн удирдлагуудад талархав. Барилга, хот байгуулалтын сайдын дэмжлэгтэйгээр дээрхи ажлууд хийх бололцоо бүрдсэн гэж Төв аймгийн удирдлагууд хэлж байна. Ирэх жилийн төсөвт зарим дутагдаж байгаа хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж өгөхийг хүслээ. Энэ нь Бүрэн суманд дулааны шугам тавих хөрөнгө, 1000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд гадна усан хангамжийн өргөтгөл, 4000-ийн усан сан, цэвэр усны хангамж зэрэг ажлууд байв.



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



АЗИЙН ХӨГЖЛИЙН
БАНК

МОН-G0204 ӨМНӨГОВЬ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА, ТООН МЭДЭЭЛЭЛ

Буцалтгүй тусламжийн дугаар:	G0204-МОН
Төслийн дугаар:	42184
Хүлээн авагч:	Монгол улсын Засгийн газар
Гүйцэтгэгч агентлаг:	Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам
Хэрэгжүүлэгч агентлагууд:	Төслийн А хэсгийн хувьд БХБЯ Төслийн В хэсгийн хувьд Өмнөговь болон Дорноговь аймгийн ЗДТГ
Төслийн нийт өртөг	21.9 сая ам.доллар
Монгол улсын Засгийн газар	6.9 сая ам.доллар
Азийн хөгжлийн банк	15.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжиж дуусах хугацаа	2015.05.31 (1 жилээр сунгагдана)

ТАНИЛЦУУЛГА

1. Төслийн хүрээнд хийгдэх ажлууд
2. А багцын ажлууд (Сумдын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, НААБ-ын менежментийг сайжруулах)
3. Дэд бүтцийн барилга байгууламж Дорноговь аймагт
4. Дэд бүтцийн барилга байгууламж Өмнөговь аймагт

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД

Д/д	Байгууламжийн нэр	Хөрөнгө оруулалт /сая ам.доллар/
1	V1-1: Сайншанд сумын цэвэр, бохир ус, дулаан хангамжийн системийг сайжруулах	2.7
2	V1-2: Сайншанд сумын 8.4МВ халаалтын зуухны ханган нийлүүлэлт, барилга угсралтын ажил	1.0
3	V1-3: Сайншанд, Замын Үүд сумдын замын ажил	1.1
4	V1-4: Замын Үүд сумын цэвэр, бохир усны системийг сайжруулах	1.7
5	V1-5: Замын Үүд сумын дулаан хангамжийг сайжруулах	1.5
6	V2-1: Гурвантэс сумын цэвэр, бохир усны системийн угсралт	2.1
7	V2-2: Ханбогд сумын цэвэр, бохир ус, дулаан хангамжийн системийн угсралт	2.7
8	V2-3: Цогтцэций сумын цэвэр, бохир усны системийн угсралт	1.0
9	V2-4: Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын замын ажил	1.7
10	V3: Даланзадгад хотын ус хангамж, ариутгах татуургын шугамын угсралт	0.9
11	C1: Төслийн хотуудад хог хаягдлын машин механизм нийлүүлэх	1.1
12	A3: Төслийн хот, сумдын төвүүдийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, байгууллагын чадавхи, хүний нөөцийг хөгжүүлэх, хилийн хамтын ажиллагааг сайжруулах	1.7
13	A4: Нийтийн аж ахуйн байгууллагуудын менежментэд ТХХТ-ийг нэвтрүүлэх, Усны зохицуулах газрыг чадавхижуулах	0.5
	Бүгд	21.9



А БАГЦЫН АЖЛУУД АЗ: СУМДЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ А4: НААБ-ЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ

АЗ: Зөвлөх үйлчилгээний ажил 3 хэсэгтэй.

Хэсэг 1. Байгууллагын чадавхи, хүний нөөцийг хөгжүүлэх

Дууссан. Сумдын тайлангуудыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Хэсэг 2. Ерөнхий төлөвлөгөө боловсруулах

Сайншанд, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс, Зүүнбаян болон Сайншандын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дуусан, орон нутгаар хэлэлцүүлсэн. Улсын экспертизэд өгөх бэлтгэл ажил хийгдэж байна.

Хэсэг 3 – Хилийн хамтын ажиллагаа

Дууссан. Эцсийн тайланг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

А4: Усны Зохицуулах зөвлөлийг чадавхижуулах ажил хийгдэж дууссан.

Төсөл хэрэгжиж буй сумдын шугам сүлжээний ашиглалтыг хариуцах Оператор компани байгуулахад туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажил хийгдэж байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД, ЗАМЫН-ҮҮДЭД ХИЙГДЭХ АЖЛУУД

Сайншанд		км
1	Цэвэр усны хуучин шугам өргөтгөх	4,85
2	Цэвэр усны шинэ шугам	1,6
3	Дулааны хуучин шугам өргөтгөх	2,75
4	Бохир усны хуучин шугам өргөтгөх	3,46
5	Бохир усны шинэ шугам	1,6
6	8,4мВт-ийн дулааны станц	1ш
7	Авто зам	2

Замын-Үүд		км
1	Цэвэр усны хуучин шугам өргөтгөх	13,4
2	Бохир усны хуучин шугам өргөтгөх	3,4
3	Бохир усны шинэ шугам	4,47
4	Дулааны шугам өргөтгөх	2,96
5	Дулаан дамжуулах төв	3ш
6	Ус түгээх байр	3ш
7	Бохирын насос станц	1ш
8	Авто зам	1

ГҮЙЦЭТГЭГЧ КОМПАНИУД


№	Төслийн багцүүд	Гүйцэтгэгч компани
1	V1-1: Сайншанд сумын цэвэр, бохир ус, дулаан хангамжийн системийг сайжруулах	“Эс энд Эй Трейд” ХХК
2	V1-2: Сайншанд сумын 8.4МВ халаалтын зуухны ханган нийлүүлэлт, барилга угсралтын ажил	БНХАУ-ын “Тайшин” Групп, МУ-ын “Цагаан шүтээн” ХХК-ийн түншлэл
3	V1-3: Сайншанд, Замын-Үүд сумдын замын ажил	Тендерийн үнэлгээ хийгдэж байна.
4	V1-4: Замын-Үүд сумын цэвэр, бохир усны системийг сайжруулах	“Эс энд Эй Трейд” ХХК
5	V1-5: Замын-Үүд сумын дулаан хангамжийг сайжруулах	“Хангилцаг” ХХК
6	C1: Төслийн хотуудад хог хаягдлын машин механизм нийлүүлэх	“Ананд холдинг” ХХК

АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ


	Ажлууд	Ажлын тоо хэмжээ, /км/	Гүйцэтгэл /км/	Гүйцэтгэлийн хувь, %/
1.	V1-1: Сайншанд сумын цэвэр, бохир ус, дулаан хангамжийн системийг сайжруулах багц, нийт явц - 73%			
	Дулааны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	2,7	2,7	100
	Цэвэр усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	6,45	5.0	78
	Ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	5,06	2.0	40
2.	V1-2: Сайншанд сумын 8.4мВт –ийн станц, нийт явц- 30%			
	8,4мВт дулааны станцын ханган нийлүүлэлт, барилга угсралтын ажил	1 ш	Барилгын суурийн ажил хийгдэж байна	
3.	V1-4: Замын-Үүд сумын цэвэр, бохир усны системийг сайжруулах- 73%			
	Цэвэр усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	13,4	13,1	90
	Ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	7,78	4.5	50
	Ус түгээх байр 1,2,3	3 ш	Өрлөг хийгдэж дууссан	80
	Ариутгах татуургын насос станц	1 ш		80
4.	V1-5: Замын-Үүд сумын дулаан хангамжийг сайжруулах – 95%			
	Дулааны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх	2,96	2,96	100
	Дулаан дамжуулах төв (ЦТП) 8,9,10	3 ш	Барилгын ажил 90%-тай хийгдэж байна. Тонго төхөөрөмж суурилуулалт хийгдэж байна.	90



ЗАМЫН ҮҮДИЙН ЦЭВЭР УСНЫ ШУГАМЫН СХЕМ



ЗАМЫН ҮҮДИЙН АРИУТГАХ ТАТУУРГЫН ШУГАМЫН СХЕМ




ЗАМЫН ҮҮД СУМАНД ХИЙГДЭЖ БҮЙ АЖЛУУДЫН ЯВЦААС

САЙНШАНДЫН ДУЛААНЫ ШУГАМЫН СХЕМ (100% ДУУССАН)

Цэвэр усны шугам угсралтын ажил



Бохирын насос станцын 6х6х7h бүрэн цутгамал барилга 7м түвшинд цутгасан байдал



ЗАМЫН ҮҮД СУМАНД ХИЙГДЭЖ БҮЙ АЖЛУУДЫН ЯВЦААС

Ус түгээх байрны барилгын хана - дулаалгын хөөс 10см, 380 тоосгон хана өрж буй байдал



Шугам угсралтын ажлын дараа нөхөн сэргээлт хийж буй байдал



14м өргөнтэй авто зам сүвлэж дулааны шугам угсралтын ажил гүйцэтгэж байгаа



Дулаан дамжуулах төвийн барилгын ажил





**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД,
ХАНБОГД, ЦОГТЦЭЦИЙ, ГУРВАНТЭС
СУМДАД ХИЙГДЭХ АЖЛУУД**

	Хийгдэх ажил	Далан- задгад	Хан- богд	Цогт- цэций	Гурван- тэс
1	Цэвэр усны шугам	1.4км	5.1км	5.9км	5.5км
2	Бохир усны шугам	4.7км	5км	2.8км	2.6км
3	Дулааны шугам	-	2км	-	-
4	Цахилгаан дамжуулах шугам	1.4км	-	-	-
5	Гүний худаг	1	-	-	2
6	Усан сан	1 (1000м3)	-	1 (100м3*2)	1 (100м3*2)
7	Гүний худгийн барилга, хашаа	1	-	-	2
8	Хлоржуулах байгууламж	-	-	-	1
9	Ус түгээх байр	-	2	3	3
14	Бохир усны насосны станц	-	-	2	-
15	Бохир ус цэвэрлэх байгууламж	-	1	-	1
16	Зам	-	-	2км	2км
17	Үерийн далан	-	-	-	1.9км

ГҮЙЦЭТГЭГЧ КОМПАНИУД

№	Төслийн багцууд	Гүйцэтгэгч компани
1	В3: Даланзадгад хотын цэвэр, бохир усны шугам сүлжээний барилга угсралт	"Санжат" ХХК
2	В2-1: Гурвантэс сумын цэвэр, бохир усны шугам сүлжээний барилга угсралтын ажил	"Санжат" ХХК
3	В2-2: Ханбогд сумын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний барилга угсралтын ажил	"Сан" ХХК
4	В2-3: Цогтцэций сумын цэвэр, бохир усны шугам сүлжээний барилга угсралтын ажил	"Монинжбар" ХК
5	В2-4: Гурвантэс, Цогтцэций сумын зам, үерийн далангийн ажил	Тендерийн үнэлгээ хийгдэж байна.
6	С1: Төслийн хотуудад хог хаягдлын машин механизм нийлүүлэх	"Ананд холдинг" ХХК

АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Ажлууд	км	Гүйцэтгэл / км/	Гүйцэтгэлийн хувь, /%/
В3: Даланзадгад хотын ус хангамж, ариутгах татуургын шугамын угсралт, нийт гүйцэтгэл- 100%. 2013 онд ашиглалтад хүлээлгэн өгсөн.			
1. Усан сан, хашаа, харуулын байр	1 (1000м3)	Дууссан.	100
Гүний худаг, барилга, хашаа	1	Дууссан.	100
Цэвэр усны шугам сүлжээ	1,4	Дууссан.	100
Бохир усны шугам сүлжээ	4,7	Дууссан.	100
Цахилгааны шугам	1,4	Дууссан.	100
2. В2-1: Гурвантэс сумын цэвэр, бохир усны шугам сүлжээний угсралт, нийт гүйцэтгэл- 80%			
Цэвэр усны шугам сүлжээ	4,7	4,7	100
Бохир усны шугам сүлжээ	3,8	3,8	100
Гүний худаг	2	2	60
Цэвэрлэх байгууламж	1	1	60
Ус түгээх байр	3	3	80
Усан сан, хашаа, харуулын байр	2	2	80
3. В2-3: Цогтцэций сумын цэвэр, бохир усны шугам сүлжээний угсралт, нийт гүйцэтгэл- 40%			
Цэвэр усны шугам сүлжээ	5,9	2,5	40
Бохир усны шугам сүлжээ	2,8	0,8	30
Ус түгээх байр	2	1	40
Усан сан, хашаа, харуулын байр	2	Цутгалт хийгдсэн.	60
Бохир усны насосны станц	1	Суурь цутгасан	30
4. В2-2: Ханбогд сумын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний угсралт, нийт гүйцэтгэл -10%			
Цэвэр усны шугам сүлжээ	5,1	Улаан шугам тавьж, бараа материалын таталт хийж байна.	10%
Бохир усны шугам сүлжээ	5,0		
Дулааны шугам сүлжээ	2,0		
Ус түгээх байр	2		
Цэвэрлэх байгууламж	1		
*Гүний худаг, ундны ус цэвэршүүлэх байгууламж, усан сан		* Оюу Толгой компани гүйцэтгэнэ.	

**САЙНШАНД СУМАНД ХИЙГДЭЖ
БҮЙ АЖЛУУДЫН ЯВЦААС**

Усан шахалт хийж дулааны шугам шалгаж байгаа нь



Худаг угсралтын ажил гүйцэтгэж байгаа нь



**ЦОГТЦЭЦИЙ СУМАНД ХИЙГДЭЖ
БҮЙ АЖЛУУДЫН ЯВЦААС**

Цэвэр усны шугам угсралт



Насосны станцын суурь





ЦОГЦЭЦИЙ СУМАНД ХИЙГДЭЖ БҮЙ АЖЛУУДЫН ЯВЦААС

Шугамын худаг угсралт



Цэвэр усны шугамын элсэн дэвсгэр



Усан сангийн цутгалт



ГУРВАНТЭС СУМАНД ХИЙГДЭЖ БҮЙ АЖЛУУДЫН ЯВЦААС

Бохир усны шүүрүүлэх талбай



Арматурын бэлдэц



Усан сан



Гүний худгийн барилга



Худгийн бетон бэлдэц



Бохир усны тунгаагуурын цутгалт



**ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ,
ТЭРБУМ ТӨГРӨГ**

**ТӨСЛИЙН НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ,
ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ**

Төслийн төлөвлөсөн санхүүжилт		Зарцуулалт /өссөн дүнгээр/		2014 оны зарцуулалтын төлөвлөгөө		2014 оны зарцуулалт		2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	
МЗГ	АХБ	МЗГ	АХБ	МЗГ	АХБ	МЗГ	АХБ	МЗГ	АХБ
12.72	27.80	4.91	11.23	7.30	13.78	3.82	6.83	3.48	6.95

Тайлбар: Төслийн хөрөнгө оруулалтын зардалд Монголын Засгийн газраас 2014 онд 2.5 тэрбум төгрөг батлагдсан. Одоогийн байдлаар 3.82 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил хийгдсэн. Үүнээс 2014 оны 9 сарын 16-ны байдлаар 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, 2.02 тэрбум төгрөгийн барилгын ажлын гүйцэтгэл Сангийн яам болон Төслийн удирдах нэгжид хянагдаж байна. Монголын Засгийн Газрын хөрөнгө оруулалт 4.8 тэрбумаар дутагдана.

Төслийн ажлын нийт гүйцэтгэл: 70%
Барилгын ажлууд төлөвлөсөн хугацаандаа явагдаж байна.

Шийдвэрлэх асуудал: МЗГ-ын 2014 оны санхүүжилт 4,8 тэрбум төгрөгөөр дутахаар байгаа тул төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх хүсэлт тавьсан.



ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ “СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧИЛЭЛ” ТӨСӨЛ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

“Сумын төвийн шинэчлэл”

төсөлд Лүн сум хамрагдах үндэслэл:

- Аймгийн анхны төв байгуулагдсан газар
- Улсын чанартай авто зам дайран өнгөрдөг
- Дулааны нэгдсэн шугам сүлжээтэй
- 2009 онд Ерөнхий төлөвлөгөө боловсруулагдан батлагдсан.
- Гадаадын болон дотоодын жуулчид дайран өнгөрч буй зорчигчдод шинэ сум төслийг сурталчилж таниулах
- Төслийн үр дүнд шинэ ажлын байр бий болгох

Ажлын зохион байгуулалт

- Ажлыг шуурхай чанартай зохион байгуулах зорилгоор ажлын хэсгийг 2014.03.21-ний А/117 тоот захирамжаар байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2014.03.27-ны А/131 тоот захирамжаар байгуулсан
- 3-р сарын 28-нд тендерийг зарласан.
- 04.18-нд Ажлын хэсэг Лүн суманд бүтээн байгуулалтын ажлын тендерт оролцогч нартай уулзалт зохион байгуулсан

- 04.23-ны Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн санал авсан.
- 2014.05.01-ний ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн хийгдэх ажлын даалгаврыг батлуулсан.
- 2014.05.12-нд тендерийг хүлээн авч нээлтийг хийсэн. тендерийг үнэлэх шатандаа байна.
- Тендерт “Ану сервис”ХХК болон “ТЗМ”ХХК-ууд санал ирүүлсэн.

Сумын төвийн харагдах байдал




Сумын төвийн шинэ төлөвлөлт хийгдэж буй газар



Сумын төвийн өндөрлөг



Сумын төвийн авто зам






Хийгдэх ажлын даалгаварт

1. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын зураг төсөл
2. Инженерийн шугам сүлжээ угсралтын ажил / Шинээр төлөвлөсөн болон одоо байгаа айл өрхүүдийг хангах/
3. Барилга байгууламжийн ажил / Одоо байгаа нийгмийн салбарын барилга байгууламжийг сүлжээнд холбох, их засвар хийх сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулах тохижилтын ажлууд

Лүн сумын төслийн хүрээнд хийгдэх ажлын зураглал



1. ЗУРАГ ТӨСӨЛ

д/д	Хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд	х/нэгж	Тоо хэмжээ
1. Зураг төсөл боловсруулах ажил			
1.	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	га	30
2.	Инженерийн гадна шугам сүлжээний ажлын зураг төсөл	Бохир	3973м шугам сүлжээ болон БХБЯ-ны нэг загварын зураг болох 100мЗ-150мЗ-ийн цэвэрлэх байгууламж суурилуулна.
		Цахилгаан	1х400кВа, 1х250кВа дэд станц 400м агаарын шугам, 1,0км хэрэглэгчийн шугам, 13ш шит
		Дулаан	1. Дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг тооцоогоор нэмнэ. 2. Шинэ төлөвлөлт хийж байгаа газарт -1242м*2 3. Одоо байгаа айл өрх 1978м *2
		Цэвэр	1. Шинэ төлөвлөлт хийж байгаа газарт -1242м 2. Одоо байгаа айл өрх 1978м 3. Хүчин чадлыг тооцоолж шаардлагатай тохиололд 1 худаг гаргана. 4. Худгуудыг цэвэр усны сүлжээнд холбоно.
3.	1. Үйлчилгээний төвийн авто зогсоолын талбай, явган зам талбайн зураг төсөл 2. Сумын төвийн хайрган зам, гүүр-2, -ийн зураг төсөл 3. 1 айлын амины орон сууцны барилга 4. Сургууль, цэцэрлэг, Соёлын төв, Эмнэлэгийн гадна фасадны зураг төсөл 5. ЕБС-ын дотуур байрны барилгын их засварын зураг төсөл 6. ЗДТГ-ын өргөтгөл их засварын зураг төсөл 7. Сумын төвийн гэрэлтүүлэгийн зураг төсөл 8. Сургуулийн хашаанд 200 м гүйлтийн зам бүхий хөл бөмбөг, сагсны талбай зэрэг ажлын зураг төсөл боловсруулах	Зураг төсөл	1. Худалдаа үйлчилгээний төвийн авто зогсоол 7500м ² /асфальт бетон/, Үйлчилгээний төвийн явган зам, талбай- 2550м ² 2. Хайрган зам 610м, 2 гүүр 3. 64м ² амины орон сууц 1ш 4. Фасад: Сургууль-2200м ² , Цэцэрлэг-650м ² , Эмнэлэг-862,5м ² , Соёлын төв-1198,5 м ² 5. 75 ортой дотуур байрны барилгын их засвар: Үүнд: Дээвэр, Хучилт, хаалга цонх, цахилгаан, халаалт, дотор засал, шал, фасад, цэвэр бохир, ариун цэврийн өрөөг 100% буулгаж, шинээр хийнэ. 6. Цэцэрлэгийн баруун талын ашиглалтгүй байгаа барилгыг ЗДТГазар болгон иж бүрэн засварлаж, иргэний танхимын өргөтгөл хийнэ. 7. Сумын төвд хийгдэх авто зам, үйлчилгээний төв, сургуулийн хөл бөмбөгийн талбайн нийт 57ш гэрэлтүүлэг угсарна. 8. Сургуулийн хашаанд 200 м тойрогтой 3м өргөнтэй гүйлтийн зам байна. Хөл бөмбөгийн талбайг тэгшилж зүлэгжүүлнэ. Мөн сагсан бөмбөгийн талбайг бетоноор цутгана.



2. Инженерийн шугам сүлжээ угсралтын ажил

2. Инженерийн шугам сүлжээ угсралтын ажил			
4.	Гадна цахилгаан хангамж	Шугам сүлжээ	1. 1х400кВа -ийн 400м агаарын шугам, 2. 1,0км хэрэглэгчийн шугам, 13ш шит
		Дэд өртөө /2ш/	1. Цахилгаан 1 х АТП-250кВа, /гэр хороололд/ 2. 1хХТП-400кВа/шинэ төлөвлөлтөнд/
5.	Дулаан хангамж	М	Одоо сумын төвд хийгдсэн шугам сүлжээний технологийг ашиглана. 1. Шинэ төлөвлөлт хийж байгаа газарт -1242м х2 / үйлчилгээний цогцолбор, амины орон сууц/ 2. Одоо байгаа айл өрх 1978м х 2
		Эх үүсвэр	3. Дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг тооцоогоор нэмнэ.
6.	Цэвэр усан хангамж	Шугам сүлжээ	1. Шинэ төлөвлөлт хийж байгаа газарт -1242м / үйлчилгээний цогцолбор/ 2. Одоо байгаа айл өрх 1978м
			3. Хүчин чадлыг тооцоолж шаардлагатай тохиолдолд 1 худаг гаргана. 4. Худгуудыг цэвэр усны сүлжээнд холбоно. /Гэр хороололын худаг 8л/сек, АНУ сервисийн худаг..... л/сек хүчин чадалтай. /
7.	Цэвэрлэх байгууламж		Одоогийн хэрэглээг тооцсоны үндсэн дээр БХБЯ-ны нэг загварын зураг болох 100м3-150м3-ийн цэвэрлэх байгууламжийг ашиглана.
	Ариутгах татуурга	Шугам сүлжээ	Газрын өндөржилт, хэрэглээг тооцоно. Шугамын урт 3973м
8.	Үерийн ус зайлуулах суваг		780м 2 гүүр

3.Барилга байгууламжийн ажил

3. Барилга байгууламжийн ажлууд			
Авто зам, зогсоол	М		Хайрган зам 610м,
Худалдаа үйлчилгээний цогцолборын зам талбай	м2		7500м2 асфальт талбай
	м2		Үйлчилгээний төвийн явган зам, талбай- 2550м2
Нийгмийн салбарын барилгуудын гадна фасадны их засварын ажил	Сургууль		Сургууль-2200м2
	Цэцэрлэг		Цэцэрлэг-650м2,
	Эмнэлэг		Эмнэлэг-862,5м ²
	Соёлын төв		Соёлын төв-1198,5 м ²
Сургууль, цэцэрлэг, Соёлын төв, Засвар хийгдэх ЗДТГ-ын дотор талд ариун цэврийн өрөө шинээр байгуулж, цэвэр ус, ариутгах татуургын анхны худагт холбох	Сургууль		1, 2-р давхарт хуучин ариун цэврийн өрөөг засварлан тус бүр 2 суултуур 2 угаалтууртай болгон гадна худагт холбоно. Мөн цэвэр усны шугамыг татна.
	Цэцэрлэг		4 ангийн хуучин ариун цэврийн өрөөг тус бүр 3 суултуур 3 угаалтуур тавьж гаргалгааг хийн анхны худагт холбоно. Мөн цэвэр усны шугамыг татна.
	Соёлын төв		Соёлын төвийн одоо интернетийн өрөөг эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө болгож, тус бүр 2 суултуур2 угаалтуур байрлуулна.
	ЗДТГазар		1 өрөөг сонгон ариун цэврийн өрөө болгож, засварлан 2 суултуур, 2 угаалтуур байрлуулна.
Дотуур байрны их засварын ажил	75 ортой дотуур байр		Үүнд: Дээвэр, Хучилт, хаалга цонх, цахилгаан, халаалт, дотор засал, шал, фасад, цэвэр бохир, ариун цэврийн өрөөг 100% буулгаж, шинээр хийнэ.
ЗДТГ-ын их засвар, иргэний танхимын өргөтгөл			Цэцэрлэгийн барилгын баруун талд байгаа ашиглалтгүй байгаа барилгыг засварлан иргэний танхимын өргөтгөл хийнэ.
Инженерийн бүрэн шугам сүлжээ бүхий 4 айлын орон сууц	4 айл		64м2 талбай бүхий 4 айлын амины орон сууцныг барина.
Сумын төвийн гэрэлтүүлэг	ш		Сумын төвд нийт 57ш гэрэлтүүлэг угсарна.
Явган хүний зам талбай хийх	м2		1992м2
Сумын төвийн авто зам дагуух айл өрхийн хашаа хийх	м		Шинэ хашаа 306м Хуучин хашаа 472м
Сургуулийн хашаанд хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбай байгуулах			Сургуулийн хашаанд 200 м тойрогтой 3м өргөнтэй гүйлтийн зам байна. Хөл бөмбөгийн талбайг тэгшилж зүлэгжүүлнэ. Мөн сагсан бөмбөгийн талбайг бетоноор цутгана.



Сумын төвийн гадна талд худалдаа үйлчилгээний цогцолбор



ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР



- Дайран өнгөрч буй жолооч, зорчигч, үйлчлүүлэгч, худалдаачдад зориулсан тохилог орчин бүрдүүлэх
- 7500м² авто зогсоол
- 2500м² явган зам
- Инженерийн нэгдсэн шугам сүлжээ
- Гэрэлтүүлэг

Худалдааны цогцолборт:



- 300м² хэмжээтэй нийт 30 газрыг дуудлага худалдаагаар худалдаалж хөрөнгө төвлөрүүлнэ.
- Төвлөрүүлсэн хөрөнгөөр эхний ээлжинд шаардалагатай авто замын асфальто хучилт, ногоон байгууламж, иохижилтын ажлуудыг хийнэ.

Нийгмийн салбарын барилгуудын гадна засвар

Соёлын төвийн барилга

Одоо байдал Засварласны дараахи байдал



Сургууль

Одоо байдал Засварласны дараахи байдал



Нийгмийн салбарын барилгуудын гадна засвар

Дотуур байр

Одоо байдал Засварласны дараахи байдал



Цэцэрлэг

Одоо байдал Засварласны дараахи байдал



Сургуулийн гадна хүүхэд залуучуудын чөлөөт цаг өнгөрүүлэх спорт талбай





Сумын төвийн гэрэлтүүлэг



Одоогийн сууршил болон шинээр төлөвлөгдсөн амины орон сууцны хорооллын гадна хашаа

- Шинээр баригдах амины орон сууцны хороололд хашаа 306м
- Одоо байгаа 472м хашааг шинэчилэх ажил хийгдэнэ.



Сумын төвийн хайрган зам

- Сумын төвийн 610м хайрган авто зам
- Үерийн ус зайлуулах хоолойн 2 гүүрийн байгууламж



**Сумын төвийн явган хүний зам
Сумын төвийн явган хүний зам 1992м²**





“ХЭРЭГЛЭГЧДЭЭ СОНСЪЁ” ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсад Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 83 жилийн ойг угтан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах, бодлого, үйл ажиллагааг танилцуулах, түүнчлэн орон сууц, нийтийн аж ахуйн салбарын ажил үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг таниулах зорилгоор Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс “ХЭРЭГЛЭГЧДЭЭ СОНСЪЁ” орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын нээлттэй хаалганы өдрийг 2014 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан байна.



Тус нээлттэй хаалганы өдөрт УСУГ, ОСНААУГ болон ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 50 гаруй байгууллага оролцож, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад салбарын үйл ажиллагааг танилцуулан, тэдний гаргасан санал, гомдлыг хүлээн авч, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг өгсөн байна.





ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО МЭДЭГДЭЛ ХИЙЛЭЭ



ШӨХТГ-аас Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэрийг хүчингүй болгох тухай мэдэгдэл хийсэн тул албан ёсоор хуулийн дагуу дараах тайлбарыг хийж байна.

Нэг: Эрчим хүчний тухай хуулийн 8-р зүйлийн 8.1. "Эрчим хүчний зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй байна." гэж Эрчим хүчний зохицуулах хорооны эрх зүйн статус, чиг үүргийг тодорхойлжээ. Энэхүү чиг үүргээ ЭХЗХ хэрэгжүүлэхдээ эрчим хүчний талаарх төрийн бодлогын хүрээнд аливаа байгууллага, албан тушаалтан хэнээс ч хараат бусаар хэрэгжүүлдэг. Эрчим хүчний тарифын талаар ЭХЗХ-оос 2014 оны 7 дугаар сарын 21-ний өдөр гаргасан шийдвэр нь УИХ-ын 2010 оны 72 дугаар тогтоол, 2014 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 34 дүгээр тогтоолын хүрээнд гарсан юм. Энэ тогтоолын хавсралт буюу эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээний чиглэлийн 4.2-т "Монгол Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд түлш, эрчим хүчний үнэ тарифыг чөлөөлж, тус салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эрчим хүчний шинэ эх үүсвэр болон дамжуулах шугамыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар барьж байгуулах асуудлыг шуурхай шийдвэрлэх" гэж заагаад энэ ажлыг Засгийн газар, Эрчим хүчний зохицуулах хороонд тус тус шууд даалгасан байна.

Хоёр: Эрчим хүчний үнэ тарифыг хянаж, батлах нь ЭХЗХ-д хуулиар олгогдсон бүрэн эрх юм. Тухайлбал: Эрчим хүчний тухай хуулийн:

9.1.4.тариф тогтоох аргачлал боловсруулах,

тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх; /Эрчим хүчний тухай хуульд 2011 оны 12 дугаар сарын 9-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлт/

9.1.5. эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох; гэж тус тус заасан байна.

Гурав: Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан тогтоолыг хүчингүй болгох субъект нь ШӨХТГ биш бөгөөд энэ талаар эрх зүйн зохицуулалтыг Эрчим хүчний тухай болон Өрсөлдөөний тухай хуулиудад нарийвчлан тусгасан байна. Тухайлбал, Эрчим хүчний тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д "Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь эрх бүхий байгууллага, ажилтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно." гэж заасан бол Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчиж гаргасан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгуулах саналыг холбогдох дээд байгууллага, албан тушаалтан, захиргааны хэргийн шүүхэд гаргаж шийдвэрлүүлэх" гэж заасан байна.

Дөрөв: Өрсөлдөөний тухай хуулийн зорилт нь аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог.

Гэтэл манай орны эрчим хүчний салбар нь шудрага өрсөлдөөнт зах зээл бус үнэ тарифын хатуу бодлого, төрийн зохицуулалттай зах зээл бөгөөд энэ тохиолдолд Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн үйлчлэл эрчим хүчний зах зээлд хамаарах эсэх нь тодорхойгүй байна.

Өрсөлдөөний тухай хуулийн үйлчлэл эрчим хүчний зах зээлд хамаарах ёстой бол харин ч уг хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4 дэх хэсэгт "бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн" үйл ажиллагаа явуулахыг хориглосон байна.



Эрчим хүчний үнэ нэмэх шалтгаан санхүү эдийн засгийн байдалтай салшгүй холбоотой. Иймд салбарын өнөөгийн байдлын талаар товч дурдвал:

Хэрэглэгчдэд худалдаж буй эрчим хүчний үнэ тариф нь өөрийн өртөгт хүрээгүйн улмаас Монгол Улсын түлш, эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээний санхүүгийн алдагдалтай ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөт засвар үйлчилгээ, техник зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг бүрэн хийх, найдвартай ажиллагааг хангахад хүндрэл учруулж байна.

Эрчим хүчний компаниуд нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаанаас 2012 онд 66.3 тэрбум төгрөгийн, 2013 онд 65.4 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн. Мөн Дулааны цахилгаан станцуудад эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нүүрс нийлүүлж буй томоохон уурхайнууд болох Багануур, Шивээ овоо ХК-иуд 2013 онд нийт 16.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаад байна.

Өнөөгийн байдлаар Төвийн бүсийн хэмжээнд 1 кВт.цаг цахилгаан эрчим хүчний өөрийн өртөг 2014 оны байдлаар 145 төгрөгт хүрч байгаа боловч хэрэглэгчдэд борлуулж буй дундаж үнэ 105 төгрөг байгаа буюу өртөгөөс 40 төгрөгөөр доогуур байгаа болно. Харин дулааны эрчим хүчийг өөрийн өртөгөөс нь 2-3 дахин бага үнээр хэрэглэгчдэд борлуулж байна.

Цахилгаан эрчим хүчний үнийг 5 төгрөгөөр нэмэгдүүлснээр сард 150 - 200 кВтц хэрэглээтэй айл өрхийн хувьд сарын төлбөр 750 - 1000 төгрөгөөр нэмэгдэж байгаа юм. Ер нь айл өрхийн орлогод цахилгаан эрчим хүчний төлбөрийн эзлэх хувийн жин жилээс жилд буурч ирсэн ба 2005 онд өрхийн орлогын 8.1 %-ийг эзэлж байсан бол 2014 онд 3.2 %-ийг эзэлж байгаагаас харахад эрчим хүчний үнэ харьцангуй тогтвортой байгаа юм.

УИХ-ЫН ДАРГА З.ЭНХБОЛД ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАЙ ТАНИЛЦЛАА



УИХ-ын дарга З.Энхболд “Амгалангийн дулааны станц”, “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК-иудад ажиллаж эрчим хүчний салбарын бүтээн байгуулалтын ажилтай танилцлаа.

УИХ-ын даргын хамт Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Эрчим хүчний сайд М.Сономпил, УИХ-ын гишүүн Д.Арвин, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга С.Отгонбаяр, УИХ-ын даргын зөвлөх Ц.Буянцогтоо нар болон албаны бусад хүмүүс ажиллав.

“Амгалангийн дулааны станц”-ын барилга угсралтын ажилтай танилцсан бөгөөд энэхүү станц ашиглалтад орсноор Баянзүрх дүүргийн 20 гаруй мянган айл өрхийн дулаан хангамжийг шийдвэрлэх боломж бүрдэж байгаа юм. Төслийн ажил өнгөрсөн оны наймдугаар сарын 23-нд эхэлсэн ч газар чөлөөлөлтөөс шалтгаалан хугацаа алдсан байна. “Амгалангийн дулааны станц”-ын барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмжийг импортлоход Гаалийн албан татвараас чөлөөлөх хууль батлагдаж 2014 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн нь ихээхэн үр дүнгээ өгчээ. Тус станцын эхний хэсгийг энэ ондоо багтаан хүлээлгэн өгөхөөр ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар ажлын явц 75 хувьтай байгаа талаар албаны хүмүүс мэдээлэв.



Үүний дараа УИХ-ын дарга З.Энхболд “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК-ийн 50 мВт-ийн өргөтгөлийн төслөөр хийгдсэн ТГ-9, станцын шинээр баригдсан ус хөргөх цамхагтай танилцлаа. Монгол Улсын төвийн бүсийн эрчим хүчний системийн хүчин чадал 50 мВт-аар нэмэгдсэнээр Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн найдвартай ажиллагаа дээшилж Хан-Уул, Баянзүрх дүүрэгт шинээр барьж байгуулагдаж буй 95 барилгыг дулаанаар хангах боломж бүрдэж байгаа юм.

Харин “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК дээр цахилгааны 123 мВт өргөтгөл хийгдсэн бөгөөд станцын сүлжээний утасны болон эргэлтийн усны шугамын шинэчлэлийн ажилтай танилцлаа.



хуучин станцууддаа шинэчлэлт хийх зорилго тавин ажиллаж байгаа юм. Чойбалсан, Дархан, “Дулааны цахилгаан станц-3”, Эрдэнэт гэх мэт дарааллаар шинэчлэлийн ажил хийгдэнэ. Шинэ станц баривал ихээхэн цаг хугацаа шаардлагатай учраас жил тутам нэмэгдэж буй хэрэгцээг хуучин станцуудаа өргөтгөх замаар шийдвэрлэх нь хамгийн оновчтой стратеги юм. Энэ стратеги зөв алхам болсон гэдэг нь “Дулааны цахилгаан станц-3”-ийн өргөтгөл 6 дугаар сарын 13 ний өдөр ажиллаж эхэлснээр харуулж байна. Мөн «Амгалангийн дулааны станц» ашиглалтад орох хугацаанаасаа нэг сарын өмнө буюу 11 дүгээр сарын 15-наас үйл ажиллагаагаа явуулж Улаанбаатар хотын зүүн хэсгийг дулаанаар хангах гэж байгаад баяртай байна. Ирэх 10 дугаар сард БНХАУ-д хийх албан ёсны айлчлалын үеэр урд хөрш улстай цахилгаан эрчим хүчний ерөнхий гэрээ байгуулан манай улсад үйлдвэрлэгдсэн цахилгааныг борлуулах талаар хоёр тал хэлэлцээ хийнэ.” гэв. Энэ жил эрчим хүчний салбарт их бүтээн байгуулалтын ажил өрнөж жилээс жилд өсөн нэмэгдэх эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангахаар зорилт тавин ажиллаж байгааг УИХ-ын дарга З.Энхболд сайшаасан юм.

Ажлын алба

ҮЙЛДВЭР, ААН, БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр		
	<i>Үүнд: Нүүрс олборлолт, боловсруулалт Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт</i>		
1.1	Энгийн тоолууртай	Төг/кВт.ц	138.00
1.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	138.00
б	Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	244.00
в	Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	66.30
2	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага		
2.1	Энгийн тоолууртай	Төг/кВт.ц	113.00
2.2	3 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	113.00
б	Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	186.00
в	Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	66.30
2.3	“Цахилгаан тээвэр” ХК	Төг/кВт.ц	66.30
3	Улаанбаатар хот, аймгийн төвийн нийтийн зориулалттай зам талбайн гэрэлтүүлэг болон нийтийн зориулалттай орон сууцны орцны гэрэлтүүлэг		
3.1	10, 11, 12, 1, 2, 3 дугаар саруудад		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 19.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	113.00
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 19.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	66.30
3.2	4, 5, 6, 7, 8, 9 дүгээр саруудад		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	113.00
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	66.30



2. Айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Энгийн тоолууртай		
A	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц хүртэлх хэрэглээг	Төг/кВт.ц	85.70
б	Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц болон түүнээс дээшхи хэрэглээг	Төг/кВт.ц	103.60
2	2 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас шөнийн 21.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	91.00
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	66.30
3	Сарын суурь тариф	Төг/сар	1000.00

3. Ахуйн тоолуургүй цахилгаан хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээг төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Сарын хэрэглээ
1	Айл өрх	кВт.ц	350

ТӨВИЙН БҮСИЙН ХҮРЭЭНД МӨРДӨХ ЭМЗЭГ БҮЛГИЙН ТАРИФ

1. Эмзэг бүлгийн хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Бүсийн ялгаа	Сарын хэрэглээ (кВт.ц)	Тариф /НӨАТ-гүй/ (төг/кВт.ц)
1	Улаанбаатар хот	100 кВт.ц хүртэл	40.00
		101 кВт.ц - аас дээш	59.20
2	Дархан хот, Эрдэнэт хот,	75 кВт.ц хүртэл	40.00
		76 кВт.ц - аас дээш	59.20
3	Бусад /1 ба 2 дугаар мөрнүүдэд орохгүй бүх аймаг, сум /	50 кВт.ц хүртэл	40.00
		51кВт.ц - аас дээш	59.20



СУМДЫН УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ СУРГАЛТ

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр аймаг, сумын төвүүдэд цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байгуулах, өргөтгөн шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээрх арга хэмжээтэй уялдуулан тус яамны зүгээс сумын төвүүдийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцах мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтыг Шинжлэх ухаан технологийн их сургууль болон НҮБХХ, АХБ-тай хамтран 2014 оны 5 дугаар сар, 9 дүгээр саруудад үе шаттайгаар зохион байгуулсан.

Энэхүү сургалт нь инженерийн шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээний анхан шатны мэдэгдэхүүнээс нь эхлэн засварчны түвшинд хүртэл үе шаттайгаар үргэлжилж, улмаар мэргэжлийн зэрэг олгон төгсгөөд байна. Сургалтад 18 аймгийн 41 сумын 43 хүн хамрагдсан.



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



ӨМНӨД СОЛОНГОСЫН ШИНЭ ХАНДЛАГА

Өмнөд Солонгост ажил хийхээр зорих монголчуудын цуваа сүүлийн жилүүдэд эрс багассан байна. Тэр тусмаа одоогийн Ерөнхийлөгчийнх нь авч хэрэгжүүлж буй шинэ бодлого дорно зүгт тэмүүлэх хэнд ч хатуу сонгогдож мэдэхээр. Амьдралаа сайжруулахаар очсон гаднынханд энэ нь тун таагүй байдлаар эргэж байгаа аж. Ийм хөндүүр сэдвээр тэмдэглэлээ эхэллээ. Тэндээс тээж ирсэн хатуу үнэнг дэлгэе. Дэлхийн эхний аравт орох эдийн засагтай тус улсад хууль бусаар ажиллаж амьдрах гаднынхан нутаг буцсаар байгаа аж. БНСУ-ын удирдагч Пак Гынхе солонгосчуудаа ажилтай, орлоготой болгох үүднээс ийн гадаадын ажиллах хүчнээс татгалзахад хүрчээ.

Шалтгаан нь солонгосчууд өөрсдөө ажилгүй байгаад оршиж байгаа юм. Өөрөөр хэлбэл, тухайн ажлын байранд нь гаднын иргэд ихээр ажиллах болсон нь нийгэмд сөрөг хандлага үүсгээд эхэлсэн байна. Иймээс зорилтот аян өрнүүлж, хяналт шалгалтыг өндөржүүлжээ. Энэхүү бодлогын хүрээнд хараар амьдардаг нутаг нэгтнээ барьж өгвөл 500 мянган воны урамшуулал олгоно гэсэн зар хүртэл түгээсэн гэнэ. Зөвхөн үүнээс болж цөөнгүй монголчууд нутаг буцсан гэж Сөүлд суралцаж буй Б.Болорчулуун ярьсан юм. Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай Өмнөд Солонгост албан бус тоогоор 30 гаруй мянган монгол хүн ажиллаж амьдарч байгаа гэх. Гэхдээ сүүлд явуулсан судалгаагаар 25 мянга гэж тогтжээ.

Ган хайлуулалтаар дэлхийд эхний гуравт, автомашин үйлдвэрлэлээрээ тавд багтах БНСУ хямд зээлээр үйлдвэрлэлээ дэмжиж, дараагийн "Самсунг", "Хьюндэй моторс"-тэй зэрэгцэх хэмжээний брэндийг төрүүлэхээр шамдан буй. Төвбанкных нь мөнгөний бодлогын хүү манайхаас арав дахин бага бөгөөд инфляци нь гурван хувьтай тэнцэж байна. Мөнгөний бодлогын хүү нь хоёр хувиас хэтрэхгүй, тогтвортой. Мөн ам.доллартай харьцах воны ханш сүүлийн таван жилийн хугацаанд огцом хөдлөөгүй байна. Солонгост нэг ам.доллар 1035 вонтой тэнцэх бөгөөд зээлийн жилийн дундаж хүү 4.39 хувь. Энэ нь манай арилжааны банкуудын олгож буй ипотекийн зээлийн хүүнээс бараг хоёр дахин бага.

Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн, Азийн тэргүүлэх эдийн засаг импортлогч бус экспортлогч. Богино хугацаанд хөгжиж чадсан

бөгөөд хөгжингүй орны зэрэглэлд хамаарагдах Өмнөд Солонгос одоогоос 50 жилийн өмнө Азийн хамгийн ядуу орнуудын нэг байсан гэдэг. Тэгвэл өнөөдөр дэлхийд шинээр үйлдвэрлэж буй гурван онгоц тутмын нэгийг тус улс үйлдвэрлэж буй. АНУ-ын хөгжлийн загварыг хуулбарласан хан улсын иргэдийнх нь дундаж цалин 2.5 сая вон. Сөүлд 100 орчим сая вонтой байхад хотын төвөөс холгүйхэн гурван өрөө байр худалдан авах боломжтой юм байна. Гадаад худалдааны гол түнш нь БНХАУ бөгөөд "Made in china" гэсэн шошго үйлдвэрлэгч орны зах зээлийг эзэлсэн байгаа нь хачирхмаар.

"Өвлийн хайрын дуу". Уншигч та үүнийг андахгүй мэдэх байх. Хэдхэн жилийн өмнө монголчууд шимтэн үздэг байсан олон ангит уран сайхны киноны зураг авалт хийсэн газар өдгөө аялал жуулчлалын чухал үзмэр болон хувирчээ, Сөүлд. Нами хэмээх жанжин амьдарч байсан гэх хэн ч үл анзаарах буйд арлыг "Өвлийн хайрын дуу" хөгжүүлж, жуулчдын төдийгүй солонгосчуудын зорин очих дуртай газрын нэг болсон байна. Үндэс нэг атлаа тусгаар улс болон орших нь Хойд, Өмнөд солонгосчуудын амьдрал, өнөөгийн хөгжил нь тэнгэр, газар шиг зөрүүтэй. Гэхдээ хоорондоо өширхөн дайсагнах бус нэгдэн нийлэх тэр цагийг хүлээдэг гэмээр. Ийм цаг ирнэ гэдэгт эрхгүй итгэдэг бололтой. Хэдий дайны түгшүүр зарлахад бэлэн байх ёстойг ухаарсан ч үндэстэн хоорондоо дайтахгүй гэх битүүхэн горьдлого Өмнөд солонгосчуудад байдаг аж.

Хан мөрний хөвөөн дэх Дорнод Азийн улс буюу БНСУ тусгаар тогтнолоо олоод 60 гаруй жилийн үдэн буй. Экспортод чиглэсэн эдийн засагтай тус улс Европын холбооны улс дахь экспортын хэмжээгээ нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа аж. Өөрөөр хэлбэл, Азийн зах зээлээс гадна Евро бүсэд ч эцсийн бүтээгдэхүүнээ нийлүүлэх туйлын хүсэлтэй байгаагаа илэрхийлсээр. Бидний өвөг дээдсийн довтолгоонд өртөж, 30 гаруй жилийн турш хараат байсан Хангүг үндэстэн Ази тивийн хөгжлийн чигийг тодорхойлдог. Хөх толботой хүүхэд төрвөл манай хүн гэж гүнээ итгэх солонгосчууд монголчуудад хүндэтгэлтэй ханддаг юм билээ. Будан суух уулс нь номин ногоон, нарны өнгөнд хувилах моддын навчис нь салхин нүүдэлтэй, Сөүлийн урт намар ард хоцорлоо.

Сэтгүүлч: Б.Баяртогтох



ЦАЛИН, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭГ 2.5 ДАХИН НЭМЭГДҮҮЛНЭ

УИХ-д өргөн бариад буй төсвийн төслөө Сангийн сайд Ч.Улаан сэтгүүлчдэд танилцууллаа. Ирэх оны төсвийн төсөлд орлогыг 7.2 их наяд, зарлагыг 8.4 их наяд төгрөг байхаар тус тус тооцжээ. Төсвийн алдагдалд ДНБ-ий долоон хувьтай тэнцэж байгаа аж. Энэ нь улсын нэгдсэн төсөвт төсвөөс гадуурх зардлыг ирэх оноос тооцох болсонтой холбоотойг Сангийн сайд тайлбарлалаа. Алдагдал эхний жилдээ өндөр гарч байгаа бөгөөд цаашдаа буурна гэв. Төсөвт аль болох захиргааны зардлыг нэмэгдүүлэхгүй байх зарчим баримталсан байна. Ингэснээр төсөв хэмнэлтийн горимд шилжиж байгаа аж.

Төсвийн төсөлд төгрөгтэй харьцах ам.долларын ханшийг 1750 төгрөг байхаар төсөөлсөн бол нэг тонн зэсийн баяжмал тэнцвэржүүлсэн үнээр 6900 ам.доллартай дүйцэх нь. Мөн 2015 онд 20 сая тонн нүүрс экспортолж, нэг тонныг нь 80-130 ам.долларын үнэтэй байхаар зураглажээ. Нүүрсний хувьд чанар, зэрэглэлээс шалтгаалан үнэ харилцан адилгүй байх аж. Ингэснээр уул уурхайн салбар

улсын нэгдсэн төсвийн нийт орлогын 1.7 их наядыг дангаар бүрдүүлэх юм байна.

Сангийн сайд Ч.Улаан “Ирэх оны төсвийн төсөлд гурван онцлог бий. Нэгд, Орон нутаг, анхан шатанд төсвийн эрх мэдэл, үүрэг, хариуцлагыг цогцоор нь шилжүүлсэн. Хоёрт, ирэх онд цалин тэтгэвэр, тэтгэмжийг 2.5 дахин буюу 500 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ. Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх үүднээс авч буй энэхүү арга хэмжээг инфляцид сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр салбарын онцлог болон цаг хугацааны хувьд ялгавартай авч үзнэ. Гуравт, Монгол Улс нэг төсөвтэй боллоо. Өмнө нь төсвөөс гадуурх санхүүжилт, зардал их байна гэж хэлдэг байсан. Тэгвэл ирэх оноос Чингис бонд, Хөгжлийн банк, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт оруулан тооцсон” гэлээ. Ирэх оны төсвийн нийт хөрөнгө оруулалт 824 тэрбум төгрөг байна. Үүн дээр Хөгжлийн банкны хөгжлийн санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж буй.





ШИНЭЧЛЭЛ ЗОГСООГУЙ

Монгол Улсад шинэ үеийн татварын тогтолцоо бий болоод 21 жил болжээ. Уг тогтолцоог бүрдүүлэхийн тулд татварын тухай багц таван хуулийг баталсан нь өдгөө бидний амьдралд хэрэгжиж байна. Эдгээр хууль нь батлагдсанаар шинэ үеийн татварын тогтолцооны суурь тавигдсан гэдэг. Манай улс олон улсад нийтлэг хэрэглэгддэг хэрэглээнд суурилсан татварын тогтолцоог 1997 онд нэвтрүүлсэн гэж хэлж болно. Тус тогтолцоонд нэмэгдсэн өртгийн албан татвар болон онцгой албан татвар онцгой байр суурь эзэлдэг.

Харин татварын нэгдүгээр шатны шинэчлэл 2007 онд өрнөсөн бөгөөд Монгол Улсад хэрэглэж байсан татварын хуулийг цогцоор нь өөрчлөн шинэчилсэн юм. Хувь хэмжээний хувьд дөрвөн 10-ын зарчимд нийцүүлж багасгасан байдаг. Татварын шинэчлэлийн гол зорилго нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэж байсныг Сангийн сайд Ч.Улаан онцлон тэмдэглээд хоёр дахь шатны шинэчлэл хийх шаардлагатай байгааг тэрбээр мэдэгдсэн.

Хэдий эхний шинэчлэлээр дөрвөн 10-ын тогтолцоонд шилжсэн ч сүүлийн жилүүдэд хавтгайрсан, үр нөлөө багатай хөнгөлөлт чөлөөлт ихсэж татвараас зайлсхийх, татварын тэгш шударга байх зарчим алдагдах болсон нь хоёр дахь шинэчлэл хийхэд ийн хүргэсэн гэх. Одоогийн хуулиар 40-өөд төрлийн хөнгөлөлт, 180 гаруй төрлийн чөлөөлт үйлчилж байгаа

бөгөөд нийт хөнгөлөлт, чөлөөлтийн хэмжээ нь нэг их наяд төгрөгт хүрч байна. Энэ нь татварын орлогын 30 хувьтай тэнцэж байгаа юм. Татварын шинэчлэлийн хүрээнд нийт 17 хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, гар хүрэх нь аж.

Аливаа улсын өөрийгөө орлогожуулах гол хэрэгсэл татвар. Сангийн яамны Төсвийн газрын Орлогын хэлтсийн дарга Э.Батбаяр “Татварын өнөөгийн тогтолцоог дүгнэвэл эрх зүйн орчны хувьд татварын дөрвөн 10-ын зарчмыг нэвтрүүлж, хувь хэмжээ тогтвортой байна. Хөнгөлөлт, чөлөөлөлт байнга нэмэгдсээр ирсэн. Харин татварын маргаан жил ирэх тусам өссөн. Дэд бүтцийн орчны хувьд татвар төлөхөд зарцуулах цаг хугацаа өндөр үзүүлэлттэй гарсан” гэв.

Монгол Улс дөрвөн төрлийн татварыг өнөөдрийг хүртэл огт хэрэглээгүй байна. Энэ нь өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар, нийслэл хотын албан татвар, нохойны албан татвар, газрын хэвлий ашигласны төлбөр аж. Эдгээрээс нохойны албан татварыг авах шаардлагагүй гэж үзэн хуулийн төсөл боловсруулаагүй байна. Харин үлдсэн гурван төрлийн татварыг хэрэгжүүлэхээр тусгайлсан хуулийн төслийг Сангийн яамнаас боловсруулж, Засгийн газарт өргөн барихаар зэхсэн.

Татварын шинэчлэл иргэн бүрт хамаатай. Тиймээс тус зохицуулалтад анхаарлаа хандуулья.



Шинэчлэлийн явцад одоогийн баримталж буй татварын чиглэлийг зангидах 24 хуулийн зохицуулалт 13 болж цөөрөх нь. Эдгээр хууль нь сүүлийн үед гарч байгаа татварын хууль, эрх зүйн маргааныг нэг мөр шийдэх юм. Мөн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж, хөрөнгө оруулалт, хөдөлмөрийг дэмжих чиглэлд татварын НӨАТ-ын босгыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх аж.

Татварын хууль, тогтоомжийн шинэчлэлийн хувьд баримтлах бодлого нь хоёрдмол салаа утгагүй, энгийн, ойлгомжтой. Цаашилбал татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нэгдсэн бодлого баримтлах, олон улсын нийтлэг зарчмыг тусгасан байхаар тогтжээ. Гэхдээ татварыг зөвхөн татварын хуулиар зохицуулахаар хуульчлах юм.

Далд эдийн засгийн хувь хэмжээ багасгахад НӨАТ-ын тодорхой хувийг иргэдэд буцаан олгох зохицуулалт хийснээр үр дүнгээ өгнө хэмээн үзжээ. Энэ жилээс татварын албаны үйлчилгээг цахимжуулах хэлбэрт шилжүүлнэ. Ингэснээр иргэд, аж ахуйн нэгж байгууллага татварын бүх төрлийн тайлан тооцоо, мэдээллийг цахим хэлбэрээр хүлээн авна гэсэн үг. Өнгөрсөн хугацаанд татварын цаасан тайланг халснаар манай улс 6.4 тэрбум төгрөг хэмнэсэн байна.

Татварын албаны үйлчилгээг цахимжуулснаар татвар төлөгчийн мэдээллийн нэгдсэн систем болон хөндлөнгийн мэдээллийн бааз бүрдэх юм. Өөрөөр хэлбэл, татвар+гааль+бүртгэл=мэдээллийн цогц системтэй болно гэсэн үг. Ингэснээр бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоог бүртгэлжүүлэх, хянах систем бий болно. Үр дүнд нь бизнес эрхлэгчид татвараа цахим хэлбэрээр төлөх боломж бүрдэнэ. Үүнээс гадна НӨАТ-ын падааны цахим систем нэвтрэх аж. Шинэчлэлийн хүрээнд газрын хэвлийн татварыг авахаар багц хуулийн төсөлд тусгасан. Манай улсын хувьд зөвхөн тухайн орд газраас гарсан бүтээгдэхүүнээс татвар авч байгаа билээ. Тэгвэл газрын хэвлий хөндөж буй барилгын компани шинэ хуулиар татвар төлөх юм.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан ёсоор 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой компанийн орлогын албан татварыг 90 хувь хүртэл хөнгөлнө” гэж байсан. Түүний хэлж буйгаар одоо арван хувийг төлж байгаа аж ахуйн нэгжүүд энэ хөнгөлөлтийг эдэлснээр

нэг хувийн татвар төлөх аж. Татварын алдагдал шилжүүлэх хугацааг уртасгаж, хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөх бололцоог хоёр дахь шатны шинэчлэл олгох гэж байгаагаараа ихээхэн онцлог гэж хэлж болно.

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн босгыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан нэмэгдүүлэх аж. Татварын шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ эдийн засгийн өсөлтийг дэмжихүйцэнгийн, тогтвортой, шударга татварын тогтолцоог бүрдүүлэхээр зорьж буй. Тиймээс энэ хүрээнд татварын хууль, тогтоомжийг шинэчлэх, хөрөнгө оруулалт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого татварын шинэчлэлд сууж өгчээ. Өнгөрсөн хугацаанд 101 хууль батлагдсанаас 46 нь хүчингүй болж, 55 хууль хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Татвар гэдэг нэг талаасаа хөгжлийн толь. Тиймээс эдийн засгийн тамир тэнхээ, орлого, амьдралын түвшин гэх мэт олон зүйлээс татвар тогтоох үндэслэл бүтэж, бүрэлдэнэ. Тэгвэл хоёр дахь шатны татварын шинэчлэл хийгдсэнээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд цөөнгүй нааштай бодлогын өөрчлөлт орох нь. Тухайлбал, шинээр бизнес эрхэлж буй аж ахуйн нэгжийг 1-1.5 жилийн хугацаанд татвараас чөлөөлөх, өндөр технологи, иновацийн үйл ажиллагааг дэмжих, татварын алдагдал шилжүүлэх хугацааг сунгаж таван жил болгох зэрэг таатай заалтыг онцолж болох юм. Гол нь татварын хувь хэмжээ нэмэгдэхгүй.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар хувь хүний орлогын албан татвартай нэгтгэх бодлогыг цаашид баримтлах аж. Үүнээс гадна Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд босгыг 50 сая төгрөг болгон нэмэгдүүлэхээр өөрчлөх бололтой. Мөн сайн дурын татвар төлөгчөөр бүртгүүлэх босгыг /10 сая төгрөг/ хэвээр хадгалах аж. Энэ нь УИХ дахь олонхийн дэмжлэг авсан тохиолдолд ногоон гэрлээр хууль болон төрөх юм. Татварын илүү төлөлтийг буцаан олгох механизмыг боловсронгуй болгон татвар төлөгчдөд шуурхай олгохоор шинэчлэлийн бодлогод ч онцолжээ. Үүнээс гадна иргэдийг урамшуулах замаар иргэдийн оролцоог нэмэгдүүлж, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөлтийг хянах тогтолцоог бүрдүүлэх юм байна. Шинэчлэл гацаагүй, үргэлжилсээр.



Australian Government
AusAID



УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ТУРШЛАГА

“УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ” Үндэсний сургалтанд зориулав.


АГУУЛГА

1. УСУГ-ын товч танилцуулга
2. УАБТ-г хэрэгжүүлсэн туршлага, ололт амжилт
3. УАБТ-г хэрэгжүүлэхэд тохиолдсон хүндрэл бэрхшээл

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



УСУГ нь 1700 гаруй ажилтантай, хотын хүн амын усан хангамж, ариутгах татуургын асуудлыг хариуцсан захиргааны 4 хэлтэс, үйлдвэрлэлийн 7 алба, 2 товчоо, 4 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



ГЭР ХОРООЛЛЫН УСАН ХАНГАМЖ



58 усны машин



270 зөөврийн УТБ
226433 оршин суугчид




319 шугаманд холбогдсон УТБ
356200 оршин суугчид



Үүнээс гадна:

хувийн гүний худгийн ус хэрэглэдэг: 170000 орчим оршин суугчид
булаг шандны ус хэрэглэдэг: 18000 орчим оршин суугчид



УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТУУД

2013 он: ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

2014 он: ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ, ТОЙМ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

2015 он: ХЯНАЛТЫГ АВТОМАТЖУУЛАХ, ТОЙМ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

2016 он: ХЯНАЛТ, ТОЙМ ҮНЭЛГЭЭ, НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН ЖИЛ



УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Багийг УСУГ-ын даргын тушаалаар шинэчилж байгуулсан бөгөөд 24 хүний бүрэлдэхүүнтэй. Багийн дарга, нарийн бичгийн дарга нар чухал үүрэгтэй.
- 2 удаа багийн бүрэлдэхүүнийг шинэчилсэн.
- Багт УСУГ-ын ажилтнуудаас гадна МХЕГ, Туул голын сав газар, БОНХГ, Онцгой байдлын газрын төлөөллүүдийг урьж оролцуулсан.

УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2012 оны 8-р сар



2014 оны 6-р сар



2014 оны 7-р сар





УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ МЭДЭЭЛЛИЙН САН



УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ ЗУРАГЛАЛ




УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ ЗУРАГЛАЛ






УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ ГАЗРЫН ЗУРАГ



УС ХАНГАМЖИЙН АЛБАНЫ ЗУРАГЛАЛ



ШУГАМААР УС ТҮГЭЭХ АЛБАНЫ ЗУРАГЛАЛ



ЗӨӨВРИЙН УС ТҮГЭЭХ АЛБАНЫ ЗУРАГЛАЛ



УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ ЗУРАГЛАЛ

- Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулахад инженер техникийн ажилтнуудад сургалт зохион байгуулж татан оролцуулсан нь эрсдэл тооцох, зураглал гаргахад ач холбогдол өгсөн.
- Улаанбаатар хотын ус хангамжийн тогтолцоо нь нүсэр байгууламжтай учир зураглалыг нарийвчилж гаргахад бэрхшээлтэй байсан.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

- ДЭМБ-ын зөвлөлтэй хамтран багийн гишүүд эрсдэлийн үнэлгээний талаар тодорхой мэдлэг хуримтлуулсан.
- Эрсдэлийн үнэлгээг газар дээр нь явж гүйцэтгэсэн.




• Эрсдэлийн дэлгэрэнгүй буюу 46 хуудас протокол хөтлөн баримт болгон хадгалсан.




Эрсдэлийн үнэлгээнд инженер техникийн болон бусад ажилтнуудыг татан оролцуулсан.



УСУГ-ЫН УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ НЭГДСЭН ЗУРАГЛАЛ



ЗӨӨВРӨӨР УС ТҮГЭЭХЭД ҮҮСЧ БОЛОХ ЭРСДЭЛИЙН ЭГЗЭГТЭЙ ЦЭГҮҮД



ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ, ЭРСДЛИЙГ ЭРЭМБЭЛЭХ

- Томоохон нийлмэл ус хангамжийн тогтолцоонд зориулсан тоон матрицийн аргыг ашиглан эрсдэлийн үнэлгээг явуулсан.
- Эрсдэлүүдийг тооцон гаргаж эрэмбэлсэн. /74 эрсдэлд 179 сайжруулах арга хэмжээ/
- Хамрагдах объектын тоо олон учираас эрсдэлийг нэгбүрчлэн тооцож гаргахад бэрхшээлтэй байсан.
- Хяналтын арга хэмжээг тодорхойлон баталгаажуулж, эрсдлийг дахин үнэлж эрэмбэлсэн.



УАБТ-Г САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2. Ундны усны аюулгүй байдлыг хангах хөтөлбөр



ДЭМБ-ЫН МОНГОЛДАХ СУУРИН ТӨЛӨӨЛГӨЧИЙН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАР



УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР



УАБТ-Г САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

2014-2016 ОНУУДАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙХ АЖЛЫН ТООЦОО

№	Хөрөнгийн эх үүсвэр	Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая төгрөг			
		2014 он	2015 он	2016 он	Нийт дүн
1	Улсын төсөв	4,000.0	1,250.0	1,250.0	6,500.0
2	Нийслэлийн хөрөнгө оруулалт	3,395.0	4,075.0	2,965.0	10,235.0
3	Олон улсын төсөл, бусад	110.0	200.0	50.0	360.0
4	Ус сувгийн удирдах газар	699.1	386.0	241.0	1,326.1
5	Туул голын сав газрын захиргааны саналаар	235.0	1,535.0	1,985.0	3755.0
НИЙТ ДҮН, /САЯ ТӨГРӨГӨӨР/		8,439.1	7,446.0	6,491.0	22,176.1

УАБТ-Г САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулахад Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн хуралдаанаар оруулж батлуулахад Монгол улсын хэмжээнд хууль эрх зүйн актанд тусгагдсан заалт байхгүй учраас бэрхшээл тулгарч байгаа.
- ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсээс зарласан “Эрүүл хотын танилцуулга – 2014” уралдааны Ундны усны тэргүүн туршлага бүхий төлөвлөгөө шалгуулах болзлын дагуу материалыг бэлтгэж хүргүүлсэн.

ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ

Хяналтын арга хэмжээ нь хөндлөнгийн болон дотоод гэсэн 2 чиглэлээр явагдаж байна.

Хөндлөнгийн хяналтыг МХЕГ, НМХГ, БОНХГ

Дотоод хяналтыг УСУГ-ын дотоод хяналтын хэсэг, Усны төв лаборатори хариуцан гүйцэтгэж байна.

Лабораторийн хяналт баталгаажуулалтыг УСУГ-ын болон НМХГ-ын даргын хамтран баталсан хуваарийн дагуу явуулдаг.

ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ



ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ

- Хяналт, баталгаажуулалтыг явуулах цэг салбарын тоо олон учир давтамж цөөхөн байх бэрхшээл байсан. Энэ оноос давтамжийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг бодлогоор зохицуулсан.
- Хяналт, баталгаажуулалтыг явуулах тусгай хөтөлбөр боловсруулж ажиллах шаардлагатай байгаа бөгөөд энэ ажлыг эхлүүлж байна. Ирэх оноос энэ ажлыг хэрэгжүүлнэ. Ингэснээр цаашдын үйл ажиллагаанд байнга мөрдөх баримт бичиг болох юм.

УДИРДЛАГЫН АРГА АЖИЛЛАГАА

- Удирдлагын дэмжлэг авах талаар багийн зүгээс идэвхи чармайлт гарган ажиллаж байна. Газрын даргын 4 тушаал



- гаргуулсан.
- УСУГ-ын удирдлагууд бүрэн дэмждэг.
- Удирдлагын дүн шинжилгээ хийх талаар зарим туршлагыг хуримтлуулж байна. Технологи горимын явцад удирдлагын хяналтыг тавьж, хяналтын явцад илэрсэн гажуудлыг залруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байна.
- Тулгамдсан асуудлыг ИТА нарын зөвлөгөөн, Удирдлагын зөвлөгөөнд оруулж шийдвэрлүүлдэг дотоод журамтай.
- Хяналт, баталгаажуулалтыг явуулахад зайлшгүй шаардлагатай удирдлагын баримт бичиг болох дүрэм, журам, заавруудыг боловсруулах ажлууд хийгдэж эхэлж байна.
- Хяналт, үнэлгээг явуулж шийдвэр гаргуулахад санхүүгийн бэрхшээл тохиолдож байгаа.
- Нийслэлийн засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд асуудлыг танилцуулж дэмжлэг авч байгаа.

ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРҮҮД

УАБТ-г хэлэлцүүлэх зорилгоор устай холбоотой чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг яам, тусгай газрын мэргэжилтнүүдэд салбар дундын хэлэлцүүлэг, ярилцлагыг явуулан протокол хөтөлж, үүнээс гарсан 30 гаруй саналыг төлөвлөгөөнд тусгаж оруулсан.



ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРҮҮД

- Ундны усны аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрсдэлийн үнэлгээг хэрхэн явуулах, түүнд авах арга хэмжээг төлөвлөх, хяналт баталгаажуулалтыг хийх талаар УАБТ боловсруулах үе шатуудтай холбогдсон сургалтыг ИТА, ажилтнууд нийт 600 гаруй хүнд явуулсан.
- Тухайн оролцогчдын ажил мэргэжлийн онцлогт тохируулсан хөтөлбөрийг боловсруулж сургалтыг явуулдаг.

- Тухайлбал,
- Удирдах ажилтнууд
- Ус хангамжийн инженер техникийн ажилтнууд
- Дотоод хяналтын болон лабораторийн ажилтнууд
- Ус түгээгч нар
- Усны машины жолооч нар
- Хлорын слесарь, операторууд
- Харуул хамгаалалтын ажилтнууд г.м





УАБТ-г боловсронгуй болгохын тулд ИТА нарт сургалт явуулж өөрсдөөр нь эрсдлийн үнэлгээг хийлгэн төлөвлөгөөнд тусгаж оруулсан.

Сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай байгаа дүрэм, журам, заавар боловсруулах ажлыг багийн гишүүд, эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор хийж байна.



Улаанбаатар хотын хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг сурталчилах зорилгоор эрдэм шинжилгээ, судалгааны бага хурлыг зохион байгуулсан бөгөөд уг хуралд нийт 23 эрдэмтэн судлаачид илтгэл бичиж оролцож ундны усны нөөц, чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр үнэтэй санал, зөвлөгөөний гаргасан нь чухал ач холбогдолтой ажил болсон. Уг хурлаар хэлэлцүүлсэн илтгэлүүдийг эмхэтгэл болгон гаргасан.



ДЭМБ, ЭМЯ-наас зохион байгуулсан “УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ СУРГАГЧ БАГШ” бэлтгэх сургалтанд 8 хүн суралцаж сертификат авсан. Ингэснээр УАБТ-г боловсруулах чиглэлээр Баянхонгор, Дорноговь, Архангай, Хөвсгөл зэрэг аймгуудад сургалт явуулах ажилд оролцлоо.



Бидний хийж буй ажлын талаар ДЭМБ-аас эрхлэн гаргадаг олон улсын сэтгүүлд ярилцлага өгч нийтлүүлсэн.

Interview with the WSP team of Ulaanbaatar Water Supply and Sewerage Authority

In this issue, we feature three key members of the WSP team, of the Ulaanbaatar Water Supply and Sewerage Authority, namely:



Bumaa S /training officer : WSP team secretary



Urnaa B /Head of testing laboratory : WSP team member



Bolormaa Ts /Chemist-quality manager of testing laboratory : WSP team member

- БНХАУ-ЫН БЭЭЖИН ХОТ, “Хотын усны аюулгүй байдал” сэдэвт сургалтанд багийн гишүүн Б. Урнаа оролцсон.



- КИРГИЗ УЛСЫН БИШКЕК ХОТ, Европын бүсийн уулзалтанд УАБТ боловсруулах багийн ахлагч Б. Батсүх оролцож танилцуулга хийсэн.
- “Building Capacities for the Development of WSPs”, 2014.06.24-25
- ФИЛЛИППИНИЙ МАНИЛА ХОТ, Номхон далайн баруун эргийн бүсийн уулзалтанд багийн гишүүн Ц.Болормаа оролцож танилцуулга хийсэн.
- “Midterm review meeting of phase 3 of the water safety plan programme (2012-2016)”





- УАБТ-г боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр хийж буй ажлыг баримтжуулсан дүрс бичлэгийн кино хийсэн /5, 10 минутын/.
- УАБТ-ний чиглэлээр зохион байгуулсан ажлуудын зургуудаас бүрдсэн альбом хийж байна.
- Сургалтын төвийн номын санд УАБТ-тэй холбоотой хийгдсэн ажлуудаар булан байгуулж байна.
- Байгууллагын вэб сайтад шинээр цэс нэмэх ажил хийгдэж байна.
- Сургалтыг явуулахад ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар идэвхитэй дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.

ТОЙМ ҮНЭЛГЭЭ

- Тойм үнэлгээг жил бүр хийж тайлан гаргаж хэвшсэн.
- Цаасан болон цахим архивыг хийж мэдээллийн сан бүрдүүлсэн.
- Багийн гишүүдээс УАБТ-д тойм үнэлгээг хийж, тайланг гаргаж байгаа боловч бүх объектонд хүрч нарийвчилсан үнэлгээг бүрэн хийх, шинэчлэн сайжруулах ажил дутагдалтай байна.

НОЦТОЙ БАЙДЛЫН ДАРААХ УАБТ-НИЙ ШИНЭЧЛЭЛТ

- Байгууллагын хэмжээнд 2013 онд Нийслэлийн ОБГ-ын буюу УАБТБ багийн гишүүнтэй хамтран гамшгийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.
- Гамшгийн төлөвлөгөөг хүн бүрт хүргэж хэрэгжүүлэх ажил учир дутагдалтай байна гэж үзэж байгаа.

УАБТ-НИЙ ЧИГЛЭЛЭЭР БОЛОВСРУУЛЖ БУЙ БАРИМТ БИЧГҮҮД

1. Эрсдлийн үнэлгээний протокол 46 хуудас
2. Усны аюулгүй байдлын сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө /Монгол хэл дээр 26 хуудас, Англи хэл дээр 26 хуудас/
3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /Монгол хэл дээр 5 хуудас, Англи хэл дээр 5 хуудас/
4. Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний тухай танилцуулга /НЗДТГ-т/, 86 хуудас
5. Төсөл хэрэгжихээс өмнөх үеийн төлөв байдалд хийсэн судалгаа, үнэлгээний ажлын тайлан /Монгол хэл дээр 71 хуудас, Англи хэл дээр 71 хуудас/
6. Д Э М Б - ы н Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай харьцсан албан захианы тоо - 18 /Монгол, Англи хэл дээр/
7. Эрдэм шинжилгээ, судалгааны бага хурал
8. Газрын дарга тушаал – 4
9. Дүрэм, журам, заавар – 230 хуудас



10. Боловсруулсан хөтөлбөр, удирдамжийн тоо – 25
11. ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт өгсөн үйл ажиллагааны тайлан – 10
12. ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт өгсөн санхүүгийн тайлан-8
13. Хэвлүүлсэн гарын авлага – 3
14. Бэлтгэж хэлэлцүүлсэн илтгэлүүд – 8
15. ДЭМБ-тай уулзалт, ярилцлага – 16 удаа
16. Аймаг орон нутагт УАБТ-ний чиглэлээр заасан хичээлийн тоо – 6
17. УАБТ-ний сургалтанд зориулж бэлтгэсэн хичээлийн сэдэв – 15
18. ДЭМБ-аас эрхлэн гаргадаг олон улсын сэтгүүлд ярилцлага өгч нийтлүүлсэн.



ЦААШИД ХИЙХ АЖИЛ 2015-2016 онд

1. Эх үүсвэрийг хамгаалах хамгаалалтын бүсийг хашаажуулах ажлыг дуусгах
2. Эх үүсвэрүүдийг камержуулах
3. Удирдлагын автомат хяналтын сүлжээтэй болох
4. Шугам хоолойг доторлох, солих, шинэчлэх
5. Хяналтанд байх шаардлагатай цэг салбаруудыг шилэн кабельд холбох, WIRE-LESS давхар холбоо бий болгох
6. Усан сан руу гадны хүн нэвтрэх боломжийг таслан зогсоох, шөнийн камер тавих, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
7. УТБ-уудыг дохиолол хяналтын системтэй болгох
8. Шаардлага хангахгүй УТБ-ын барилгыг буулгаж шинээр УТБ барих, засвар үйлчилгээ хийх
9. Усны машин худалдан авах /15 машин/
10. Автомашины ус юүлэх шланкийг битүүмжлэлтэй болгох /49 машин/
11. УТБ-уудыг цахилгаан халаагуур, утаагүй зуухаар хангах
12. Зөөврийн УТБ-ыг шугамд холбох
13. Дохиолол хамгаалалтын бүрэн шаардлага хангасан техник суурилуулах /580 УТБ/
14. Хяналтын цооногийн тоог нэмэгдүүлэх
15. Хяналтын анализаторыг ажилд оруулах, хлоржуулах байгууламжийн тоног төхөөрөмжийг шинэчлэх
16. Усны чанарын хяналтын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
17. Боловсон хүчнийг үе шаттайгаар сургалтанд хамруулах
18. УАБТ-ний үр дүнд хяналт тавьж, тасралтгүй үйл ажиллагаа явуулах журам тогтоох



Сайншанд хотын усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТҮРШЛАГА

Дорноговь аймаг



Засаг захиргаа: 14 сум, 60 багтай

Хүн ам 62484

Өрхийн тоо 18574

Сайншанд сум

Хүн ам 22011

5 багтай

Төвийн 4 баг: 5988, Зүүнбаян

541 өрхтэй



Сайншанд хотын усны аюулгүй байдлын төлөвлөгөө

Сайншанд хотын усны аюулгүй байдлын төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2013 оны А/294 дугаар захирамжаар холбогдох байгууллагын төлөөлөл 12 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулсан.

Усны аюулгүй байдлын төлөвлөгөө

- АЗД-ын 2013 оны А/582 дугаар захирамж
- Ойр, дунд, хэтийн хугацаанд хэрэгжих
- Жил тутам-10
- 2013,2014-25
- 2013-аас-2015,2020,2030 онд-42, бусад -15
- 4 бүлэг,13 дэд бүлэг,92 заалт

“Чандмань – Илч” ОНӨ ХХК -ийн үйл ажиллагаа

- Цэвэр усаар хангах
- Бохир ус татан зайлуулах
- Дулаан хангамж

Сайншанд сумын I, II, III багийн нутаг дэвсгэрт орших 223 аж ахуйн нэгж байгууллага болон иргэдийг унд ахуйн хэрэгцээний усаар хангадаг.

Хүнцэл бууруулах төхөөрөмж өрөө



БНСУ-ын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар хүнцэл бууруулах төхөөрөмжийг 15000 доллараар гүйцэтгэгч компани ирж суурилуулсан.

Байгаль орчны ногоон хөгжлийн яамны санхүүжилтээр усны тоолуур шалгах төхөөрөмжийг 20 сая төгрөгөөр суурилуулсан.

Усны тоолуур шалгах лаборатори



Манай компани өөрийн хөрөнгөөр дотоод хяналтын ус шинжилгээний лабораторийг байгуулахаар байр болон зарим төрлийн багаж, тоног төхөөрөмжийг бэлтгэсэн байсан. 2013 онд Улсын хөрөнгө оруулалтаар лабораторын тоног төхөөрөмжийг хүлээж авсан. Ингээд 2013.07.01-ээс эхлэн лабораторийг ажиллуулсан. Ундны усанд химийн 12 үзүүлэлт, бактерлогийн 4 үзүүлэлтээр сар бүр шинжилгээг хийж байна.





Дотоод хяналтын лаборатори



Дээж хүлээн авах

Химийн лаборатори



Химийн шинжилгээнд ашиглагдах багаж тоног төхөөрөмж



Кондуктометр

Аналитик жин

Усмал дозлогч



Спектофотометр

Усан банн

Нян судлалын шинжилгээнд ашиглагдаж буй багаж, тоног төхөөрөмж



Автоклав

Ус нэрэгч

Термостат

Сайншанд сумын цэвэр усныцуглуулах, түгээх төв шугам хоолойг 2,6 км болон ариутгах татуургын төв шугам сүлжээг 1,3 км газар өргөтгөн шинэчлэх ажил гүйцэтгэлийн шатандаа явж байна.

Сайншанд сумын инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажил



Сум хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар УТБ 11-ийн барилгыг бүрэн засварлаж, УТБ 12 зөөврийн усан сан байсанг төвлөрсөн шугам сүлжээнд холбож барилгыг бүрэн засварлаж, Өмчийн хэлбэр нь Сайншанд сумын харьяанд байсан УТБ 17 “Чандмань-Илч” ОНӨ ХХК-ний мэдэлд шилжүүлсэн. Нийт 3 УТБ-ыг 60 сая төгрөгөөр барилга ба шугам сүлжээний засварын ажлыг гүйцэтгэсэн.

УТБ №12

Өмнө нь

Дараа нь



УТБ 11

Өмнө нь

Дараа нь





УТБ 17



Унд ахуйн усыг зөв хэрэглэж хэвшүүлэх сургалт сурталчилгаа

Зорилтот бүлгийн хүн ам

- 0-5 насны хүүхэдтэй эхчүүд
- Өрх толгойлсон эхчүүд, эмзэг өрхийн гишүүд

Хүүхдийнбайгууллага

- 5 сургууль
- 10 цэцэрлэг

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

- DSB телевиз
- МНТ телевиз

Унд ахуйн усыг зөв хэрэглэж хэвшүүлэх сургалт сурталчилгаа

- 15 сургууль цэцэрлэгийн 4200 гаруй хүүхэд 350 эцэг эхчүүд “ Усыг зөв хэрэглэж хэвших зан үйл төлөвшүүлэх , гар угаахын ач холбогдол” сургалт сурталчилгаанд хамрагджээ.
- Худгийн ус түгээгч нар болон гэр сувилалд сувилуулсан хүүхдүүдийн эцэг эхчүүд, аймгийн БГ-тай хамтран сургуулийн захирал, менежер, цэцэрлэгийн дарга эрхлэгч нийт 125 хүнд сургалт хийж, 6 цуврал 558 ш тараасан.
- Сайншанд сумын цэцэрлэгүүдийн эцэг эхчүүдэд хуралд “Унд ахуйн усны эрүүл ахуй” сэдэвт мэдээлэл хийж, 112 хүн хамрагдсан.

Унд ахуйн усыг зөв хэрэглэж хэвшүүлэх сургалт сурталчилгаа



“Чандмань – Илч” ОНӨ ХХК



ХҮРЭЭ ХАУС ХХКОМПАНИ “ЕСО АЯЛАЛ” ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дэлхий дээр амьдарч байгаа ан амьтан, хүмүүс бид бүгдээрээ байгалийн амьтан билээ. Энэ сайхан газар шороон дээрээ амь биеийг олоод төрсөн л бол эргээд газар шороондоо шингэдэг жамтай. Ийм учраас хүмүүс бид эх дэлхий байгалиа хайрлан хүндэтгэж, цэнгэг ариунаар нь хадгалан хойч үедээ үлдээх учиртай.

Манай компанийн хамт олон энэ удаад зүгээр нэг амарч зугаалаад салхинд гараад ирэхийг зорьсонгүй. Зорилготойгоор “Эко аялал”-ыг зохион байгууллаа. Иргэд маань салхинд гараад амраад явахдаа байгаль, уул усандаа хүндэтгэлээ илэрхийлж идээ цайныхаа дээжийг өргөдөг уламжлалтай билээ. Гэвч тэд байгальд хортой бүхнийг хаяад явчихдаг нь хачирхалтай. Тэр хогон дунд байхгүй юм алгаа. Архины шил, ундааны сав, ариун цэврийн хэрэглэл, гялгар уут ер нь юу эс байхав дээ.

Бид хамт олноороо 8-р сарын 22,23-ны өдрүүдэд “Цэнхэр мандал” амралтанд амрахын зэрэгцээ амралтын ойр орчмын газрууд болон хар усан тохойн голын эрэг дагуух хэсэг газрын хогийг цэвэрлэн байгаль орчноо хамгаалах үйлст хувь нэмрээ оруулсандаа баяртай байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.





ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ 32 МӨНГӨНИЙ ҮНЭТЭЙ

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны Удирдах зөвлөлийн гишүүд 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Монголын үндэсний өдөр тутмын сонин болох “Өнөөдөр” сонинд ярилцлага өгч нийтлүүлээ.

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өдрөөс өдөрт өсөж байгаа. Хэдхэн хоногийн өмнө 400 төгрөгөөр хямд байсан махны үнэ маргаааш, нөгөөдөр нь 1000 төгрөгөөр ч нэмэгдэж мэдэх өнөө үед иргэдийн гол хэрэглээ, амьд явах баталгаа болсон усны үнэ л өөрчлөгдөөгүй. Өөрчлөгдөөгүй удсан тул зарим хүн хэдээр авдгаа ч мартсан байх. Гэр хорооллын иргэдийн олонх нь нэг литр усыг нэг төгрөгөөр, алслагдсан зарим газрынхан хоёр төгрөгөөр авдаг нь усны хамгийн дээд үнэ.

Орон сууцны хэрэглэгчид нэг литр усыг 32 мөнгөөр авдаг. НӨАТ-ыг нь нэмээд энэ. НӨАТ-ыг нь оруулахгүйгээр орон сууцны иргэд нэг литр усыг 29 мөнгөөр авч буй. Нэг литр ус 32 мөнгөний үнэтэй тул нэг тонн буюу 1000 литр ус 320 төгрөг. Жилээс жилд нөөц нь багасаж байна, бид усгүй боллоо гэж уулга алддаг хэрнээ ийм багаар үнэлж, хэтэрхий үнэлэмжгүй болгосон нь хэр зөв бэ. Үнэ хэт хямд байгаагаас болж, энэ салбарт ажиллаж буй байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн бус болж, дампуурлын ирмэгт ирээд байгаа аж. Энэ талаар тус салбарт ажиллаж буй хүмүүсийн саналыг сонслоо.

200 ГАРУЙ ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛД ОРЧИХООД БАЙНА

Б.Жигжид (Дэд бүтцийн сайд асан):

-Усан хангамж, эрчим хүчний салбарт үнийн бодлогын зохицуулалт хийхгүй байгаагаас алдагдалд орж, зарим байгууллага дампуурлын ирмэгт хүрсэн. Монголын нийтийн аж ахуйн байгууллагууд 200 гаруй тэрбум төгрөгийн алдагдалд оржээ. Усан хангамж, ариутгах татуургын тухай хуульд хоёр жилийн өмнө өөрчлөлт оруулж, Хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл байгуулсан. Энэ зөвлөл нь усны үнэ ямар байхыг тооцоолон гаргаж, зайлшгүй нэмэх шаардлагатайг холбогдох газарт нь уламжилсан ч шийдэлгүй өнөөг хүрчээ. Үүнээс болоод энэ салбарт, ялангуяа, орон нутаг дахь байгууллагууд боловсон хүчингүй болсон.

ТӨР, ЗАСГИЙН ТУСЛАЛЦАА ХЭРЭГТЭЙ БАЙНА

Б.Пүрэвжав (Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны гүйцэтгэх захирал):

-Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар төрийн бодлогын гадна орхигджээ. Сүүлийн 5-6 жилд үнийг нь хөдөлгөөгүйгээс болоод тухайн салбарт ажиллагсдын цалинг тавьж чадахгүй, үйлчилгээ доголдож, саатдаг, оршин суугчид сэтгэл ханамжгүй байдаг болсон. Хот, суурингийн усан

хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл Засгийн газар, ШӨХТГ-тай зөвшилцөж, үнэ нэмэх асуудлыг шийдүүлж чадахгүй байна. Урсгал засвар хийн, ирэх өвлийн бэлтгэлээ хангаж, найдвартай ажиллана гэж хэлж чадах байгууллага ховор. Манай салбарынхан ажил хаяж, шаардлага тавьж чадахгүй учир төр, засагт дуу хоолойгоо хүргэж чаддаггүй. Энэ салбар аль нэг яамны бүрэлдэх үүнд байсан ч тухайн яам нь шинэ хөрөнгө оруулалтад анхаарахаас биш ашиглалт, үйлчилгээ хариуцсан энэ салбарт анхаараагүй. ОХУ өнгөрсөн оны арванхоёрдугаар сард Барилга, нийтийн аж ахуйн яам байгуулсан. Манайх ч БХБЯ-аа ийм болгож, салбараа хөл дээр нь тогтоох хэрэгтэй. Үүний тулд төр, засгийн тусалцаа хэрэгтэй. Манай салбарынхан ажлаа л хийж байвал асуудал хэзээ нэгэн өдөр шийдэгдэх байх гэсэн итгэлтэй ажилладаг. Удахг үй нааштай шийдвэр гаргана гэж найдаж байна.

УСНЫ ҮНИЙГ 52 МӨНГӨ БОЛГОХ САНАЛТАЙ

С.Үнэн (Ус сувгийн удирдах газрын дарга):

- Ус сувгийн удирдах газар (УСУГ) 2013 онд 11 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Гаднын байгууллагуудаас авсан зээл хүүтэйгээ нийлээд 120 тэрбум төгрөгийн өртэй. Валютын ханшийн өсөлтөөс болоод 20-30 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Усны хангамж, түгээлт хариуцаж буй манай байгууллага санхүүгийн чадавхгүй болон дампуурчихаад байна. Манайх зардлаа хэмнэж, хамгийн бага зардлаар ажиллаж байгаа ч тус болохгүй. Мөн усны үнийг хянаж, тохируулдаг Хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллаж байна. Энэ зөвлөл усны үнийг хэдээр тогтоохыг тооцож, нэмүүлэх саналаа ШӨХТГ-т хүргүүлсэн. ШӨХТГ зургадугаар сарын 2-нд хуралдаж, энэ асуудлыг хэлэлцэнэ. Алдагдалтай ажиллаж, өртэй байна гэдэг нь манай үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэйгөөс зээл тусламж үзүүлж буй гаднын улсуудад хүнд цохилт болно. “Засгийн газар нь алдагдалтай ажиллаж буй салбарынхаа үнийг зохицуулах чадваргүй тул зээлээ төлж чадахгүй нь” гэдэг хөрөнгө оруулахаа болино. Тэд манайд “Зээлээ төлөхдөө үнийн зохицуулалт хийж, чөлөөлөөрэй” гэдэг ганцхан шаардлага тавьсан байдаг.

Гэр хорооллынхныг усаар хангахын тулд түгээх байранд аваачиж, иргэдийн саванд юулж буй зардал нэг литр усанд 7-8 төгрөг. Гэтэл борлуулах үнэ нь нэг төгрөг. Орон сууцанд амьдарч буй иргэдэд 32 мөнгөөр буюу гэр хорооллынхноос 3.5 дахин бага үнээр ус зардаг. Орчин үед мөнгөөр илэрхийлэх нь битгий хэл 100 төгрөгөөр авах юм ховорсон байхад цэвэр ус ийм хямд байж болохгүйг иргэд ойлгож байгаа. Харин эрх баригч, шийдвэр гаргаж буй хүмүүс ойлгохгүй байгаа. Эдийн засаг



хүндэрч, бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсээр байхад усны үнийг хүртэл өсгөж, иргэдийн нуруун дээр дарамт үүсгэхгүй гэж ингээд байгаа болов уу. Би үүний эсрэг бодолтой байгаа. Үнийг хатуу барьснаар иргэдэд тус болохгүй. Бид дааж давшгүй их нэмэх гээгүй, 32 мөнгийг 52 болгох саналтай байгаа. Гэр хорооллын иргэдийн усанд төлдөг мөнгийг нэмэхгүйгээр орон сууцны хэрэглэгч нэг литр усыг 32 мөнгөөр авч байгааг 52 болгоё гэсэн. Энэ нэмэгдэл нь хэрэглэгчид санхүүгийн дарамт болохгүй. Бид өрхийн орлогоос эхлээд бүх зүйлийг нь тооцоолон үзэхэд нэг айлд 3000-4000 төгрөгийн ачаалал ирэхээр байсан.

САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТҮЛХҮҮР НЬ ҮНЭ НЭМЭХ

Ч.Эрдэнэчимэг (Хот, суурингийн усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга):

-Усны үнийг зөвлөл байгуулснаас хойших хоёр жилийн турш ярьсан ч шийдэж өгөх хүн алга. Салбарыг хөгжүүлэх түлхүүр нь усны үнийг нэмэх. Үнийг өөрчлөхгүй олон жил болж байгаа нь энэ салбарыг маш хүнд байдалд оруулж, усан хангамжийн үйлчилгээ тааруу болж байна. Зарим газарт зэвтэй ус гарч байна, ус хатуулагтай байна. Энэ зун төлөвлөгөөт засвар, үйлчилгээгээ хийж чадах, эсэх нь тодорхойгүй. Иргэн, аж ахуйн нэгж ямар хэмжээний ус хэрэглэж байна, тэр хэрээр бохир ус гардаг. Бохир усыг нь цэвэрлэдэг Төв цэвэрлэх байгууламж маш хүнд байдалтай ажиллаж, шаардлагатай хэмжээнд нь цэвэрлэж чадалгүй Туул голд асган, бохирдуулж байгаа. Энэ мэтийн асуудал олон бий. Манай усны үнэ хэтэрхий хямд байгаа учраас хэрэглээ өндөр байна. Цаашид бүх айлыг тоолууржуулан, усаа зөв үнэлж, энэ хэрээр зохистой хэрэглэдэг болох шаардлагатай.

ИЙМ ИХ ХЭМЖЭЭНИЙ ӨРНИЙ АРД ЯАЖ ГАРНА ДАА

Л.Лхамаасүрэн (Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны санхүүгийн ажилтан):

-Би УСУГ-т ажиллаж байсан. Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, Засгийн газраас бараа бүтээгдэхүүний үнийг чөлөөлөх үед усны үнэ чөлөөлөгдөөгүй үлдсэн юм. Чөлөөлөгдсөн гэсэн нэртэй боловч ямар нэгэн аргаар барьж, нэмэх санал тавьсан ч тухайн үеийн төр, засгийнхан тоохгүй байсаар ганцаараа үлджээ. Ярихдаа чандмань эрдэнэ, маш чухал гэдэг ч үнэлэмжид нь анхаарахгүй байна. 2008 оноос хойш манай улсад хэрэгжүүлсэн нийтийн аж ахуйг сайжруулах төсөлд хамруулсан 10 байгууллагын эдийн засгийн үр дүнг авч үзэхэд бүгд өр төлбөрөө төлөх чадваргүй болсон байсан. Үүнийг холбогдох газрынханд нь дуулгахад нүүрэн дээрээ "Заавал шийднэ" гэдэг ч усыг үнэгүй хэрэглээд сурчихсан болохоор ч тэр үү бүтэн зургаан жил хөөцөлдсөн ч шийдэлд хүрсэнгүй. Үүнээс болж энэ салбарын байгууллагууд үйл ажиллагааныхаа зардлаар алдагдлаа нөхөж чадахаа больсон. Орчин

үеийн тоног төхөөрөмж авч бүр чадахгүй. Гараа тосоод хандивлагч орон байна уу гээд хараад суудаг. 2004 оноос УСУГ алдагдалд орж, зээл, зээлийн хүүгээ төлж чадахаа больсон. Би УСУГ-т ажиллаж байхдаа тайлан балансыг нь хараад айдаг байсан. Ийм их хэмжээний өрний ард яаж гарна даа гэж. Эцсийн дүндээ хэрэглэгчид л үүнийг төлнө дөө гэж боддог байсан. Энэ асуудлыг эртнээс шийдээд явсан бол хүнд байдалд хүрэхгүй байсан. Нэлээд цаг алдсан ч дахиж алдахгүйгээр одоо л шийдэх хэрэгтэй. Усны үнийг нэмэхдээ аймаг, бүс нутаг бүрийн онцлогт тааруулан, шатлалтай болгох шаардлагатай. Дээр нь олон жил болсон өрийг төр, засаг шийдэх ёстой юм.

ЦЭВЭР УСААР МАШИНАА УГААГААД, ШАВАР ЗУУРАХ АШИГТАЙ

Д.Басандорж (ШУТИС-ийн профессор):

-Манай усны салбар зах зээлийн зарчмаар ажиллах тал дээр нэлээд хоцрогдолтой байгаа. Үнэ нэмнэ гэдэг нэг их сайн зүйл биш боловч ус гэдэг зүйл бол маш чухал. Нэг өдөр ус хаах юм бол иргэдийн амьдралд юу болох билээ. Тиймээс усны үнээр дамжуулан, үнэлэмжийг нь нэмэгдүүлэх шаардлагатай юм. Саарал усаа цэвэршүүлэн хэрэглэнэ гэж яриад байна. Гэтэл амьдрал дээр цэвэр ус нь саарлаасаа илүү хямд. Саарал усыг боловсруулахад маш их өртөг гарч байгаа учир цэвэр усаар машинаа угаагаад, шавар зуурах ашигтай. Тиймээс усыг ямар үнээр хэрэглэгчдэд хүргэж байна. Хэд болговол ашиг олохгүй юм гэхэд алдагдалгүй ажиллуулах ёстойг сайтар тооцон, нэн даруй шийдэх хэрэгтэй. Усыг иргэдэд хүргэх үнэ нь таван төгрөг байгаа юм бол үнийг нь гурван төгрөг болго. Энэ үйлчилгээг ард иргэдэд хүргэх үүрэг нь төрд байгаа учир үлдсэн хоёр төгрөгийг нь төр гаргах ёстой. Дэлхийн аль ч улсад манайх шиг хямд ус байхгүй. Цэвэр усыг манайх шиг замбараагүй хэрэглэдэг улс ч алга. Зарим нь огт цэвэр усгүй болоод борооны ус, саарал ус цэвэршүүлэн ууж байна шүү дээ.

ДАДЛАГА, ТУРШЛАГАГҮЙ ХҮМҮҮС ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨ САЙН МЭДЭХГҮЙ, ЭВДРЭХЭД НЬ ЗАСАЖ ЧАДАХГҮЙ

Г.Цогтсайхан (Төв аймгийн "Төв чандмань" дулааны эрчим хүчний газрын гүйцэтгэх захирал):

-Манай дундаж цалин бусад салбарын байгууллагатай харьцуулахад 2-2.5 дахин бага. Цалин ийм бага байхад ажиллах хүч олдохгүй, боловсон хүчний бодлого алдагдан, олон жил ажилласан хүмүүс нь өөр газар луу явж байна. Дадлага, туршлага багатай хүмүүс ажиллахаар тоног төхөөрөмж өө сайн мэдэхгүй, эвдрэхэд нь засаж чадахгүй байна. Ингээд үйл ажиллагаа доголдож эхэлнэ. УИХын тогтоолоор зардлаа нөхөж чадахгүй тохиолдолд алдагдлыг нь улсын төсвөөс татаасаар нөхөж олгох нөхцөл бий. Гэсэн ч татаас байдаггүйгээр үл барам үнийг нь барьчихсан. Манай аймагт 2009 оны үнээр ус борлуулж байна. 2009 оноос хойш юмны үнэ хэд дахин нэмэгдсэн билээ.

"Өнөөдөр" сонин Ч.МӨНХЗУЛ



УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАНГАГДВАЛ АЙХ АЮУЛГҮЙ, ЦЭВЭР, ЦЭНГЭГ УСАА ТАЙВАН ХЭРЭГЛЭЖ БОЛОХ НЬ ЭЭ

“Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг орон нутагт өргөжүүлэх ус, сувгийн удирдах газрын туршлагыг судлах” үндэсний сургалт энэ сарын 15-19 өдрүүдэд болсон юм. Энэ сургалтад 10 орчим аймгаас ус хангагч байгууллагын захирал, инженер, Засаг даргын орлогч нар хүрэлцэн иржээ. ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 2011 оноос ус хангамжийн тогтолцоонд “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө” төслийг боловсруулах ажлыг манай улсад хийж байна. Энэ ажлын хүрээнд Ус сувгийн удирдах газар, Дорноговь аймгийн Чандмань илч ХХК-ийг загвар болгон түшиглэж ирсэн бөгөөд Баянхонгор аймгийн Шинэжинст, Баянговь сум, Говь-Алтай аймгийн Баян-Уул, Төгрөг сум, Дорноговь аймгийн Сайншанд сум, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Булган суманд уг төслийг хэрэгжүүлж эхэлжээ. Мөн Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгтэйгээр Архангай аймагт, НҮБ-ын дэмжлэгтэйгээр Хөвсгөл аймагт тус төслийг эхлүүлээд байна. Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх үйл явц салбар дундын хамтын ажиллагаа шаардсан, багаар хийгддэг ажил тул цаашид уг төслийг орон нутагт өргөжүүлэх, тогтвортой байдлыг хангах үүднээс багийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах ажлыг үе шаттайгаар явуулсан. Үүний нэг нь үндэсний хэмжээний сургалт юм.

ДЭМБ-ын Усны аюулгүй байдлын зөвлөх Жонн Дэннис ярихдаа “Бид цаашид усны аюулгүй байдлын төлөвлөгөөний талаар хийх зүйл их бий. ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр олон ажил хийгдэнэ гэж төлөвлөсөн. Одоо хийж байгаа зүйл бол усны чанарыг сайжруулах, аюулгүй байдлын төлөвлөгөөг Монгол Улсын хууль тогтоомж, бодлого шийдвэрт хэрхэн тусгах, хэрхэн хэрэгжүүлэхэд чиглэсэн, мөн өөрчлөх үйл ажиллагаанууд хийгдэж байгаа. Тухайлбал, Монгол Улсын ундны усны стандартад усны аюулгүй байдлын төлөвлөгөөний талаар төдийлөн тусгаагүй байгаа. Иймээс бид усны аюулгүй байдлын төлөвлөгөөг ундны усны стандартад тусгах талаар ажиллаж байна. ЭМЯ, БХБЯ-тай хамтарч усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх вэ, цаашид ямар аргачлалаар явах вэ зэрэг чиглэлээр зөвлөмж боловсруулсан. Энэ зөвлөмжийг хүчин төгөлдөр болгож хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах болно. Энэ төсөл Монголд хэрэгжээд хоёр жил болж байна. Анхны сургалтаар 21 аймгуудын төлөөлөгчдөд усны аюулгүй байдлын төлөвлөгөөний ойлголт, аргачлал, зарчим, хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдлэг ойлголтыг өгч байна. Нөгөө талаар усны

аюулгүй байдлын чиглэлээр бэлтгэгдсэн боловсон хүчин Монголд хангалттай байдаг. Эдгээр мэргэжилтнүүдийн мэдлэгийг улам сайжруулахын тулд дараачийн шатны сургалтыг 10-р сард хийхээр төлөвлөж байна. Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг илүү сайжруулахын тулд хэд хэдэн төлөвлөгөөт алхмууд хийгдэх ёстой ” гэв.

Жонн Деннисийн ярьснаар манай улсад ундны усны бохирдол ямар байгааг тогтоосон анхан шатны судалгаа хийгджээ. Хамгийн түрүүнд “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө” төслийн хүрээнд Монгол Улсын хүн амын ундны усыг сайжруулахын тулд эрсдлийн үнэлгээг хийсэн байна. Яг одоо хүн амд хүрч байгаа ундны ус ямар эрсдэлтэй байна, эрсдлийг бууруулахын тулд менежментийн ямар арга хэмжээ авахыг зорьж байгаа, ямар ажиллагаа хийснээр эрсдэл буурах вэ гэдгийг тодорхойлсон төлөвлөгөөг гаргажээ. Гэхдээ хүн амын ундны усанд ямар нэгэн эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлийг арилгах менежмент хийнэ гэдэг тодорхой хугацаа шаардсан ажил байдаг аж. Энэ бүх ажлыг нэг дор хийхгүй, үе шаттайгаар хийх юм байна. Энэхүү эрсдлийн үнэлгээнд ямар эрсдлийг бууруулснаар Монгол Улсын хүн ам эрүүл, аюулгүй, чанартай усаар хангагдах вэ гэдгийг тогтоосон төлөвлөгөө боловсруулжээ. Одоо хэрэгжиж эхлээд байгаа юм.

Судалгаанаас үзэхэд усны аюулгүй байдлын түвшин, үнэлгээг мэргэжлийн судлаач, шинжээч, байцаагчид хийжээ. Ундны усны аюулгүй байдал гэдэг ганц үгээр хэлэх зүйл биш юм байна. Монгол орны хэмжээнд ундны усны нөөц багасч, улмаар аюулгүй, эрүүл ахуйн орчин байдалд анхаарах цаг болсныг энэ төлөвлөгөө харууллаа.

Харин ДЭМБ-ын орчны асуудал хариуцсан мэргэжилтэн В.Дэлгэрмаа “ДЭМБ Австралийн Засгийн газрын санхүүжилтээр одоогийн байдлаар есөн оронд “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө” хөтөлбөр хэрэгжүүлж байна. Манай улс энэ хөтөлбөрт хожуу 2011 оны сүүлийн хагаст бэлтгэл ажлаа хийж, хамрагдсан. Ингээд 2012 онд Улаанбаатар хот, Дорноговь аймагт усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн. Ус сувгийн удирдах газрыг түшиглэн “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө” амжилттай хэрэгжих эхний алхмаа хийсэн. Манай улс 2012 оны 7-р сараас хэрэгжүүлж эхэлсэн ч 2005, 2006 онд хэрэгжиж эхэлсэн улс орнуудын түвшинтэй богино хугацаанд амжилттай явуулж байна гэсэн дүгнэлтийг Филиппин улсын Манила хотод болсон



бүх улсын төлөөлөл оролцсон дунд үе шатны эргэн үнэлэх уулзалтад дүгнэсэн. Манай улс өвөрмөц онцлогтой. Улаанбаатар хотод төвлөрсөн болон төвлөрсөн бус усан хангамж хэрэглэж байна. Жишээ нь, эх үүсвэрээс авахуулаад крантаар гоожиж байгаа усыг хэрэглэх хүртэл ямар эрсдэл байна вэ. Мөн төвлөрсөн усны худгаас усны машинаар ус зөөж, дараачийн ус түгээх нөөцийн байранд өгч, хэрэглэгчдэд хүргэдэг. Энэ бүх үе шатанд янз бүрийн байдлаар аюулгүй байдал зөрчигдөж, эрсдэл нүүрлэх юм бол хүн болгон усаар өвчлөх боломжийг бүрдүүлдэг. Тиймээс хэрэглэгч ямар усанд усаа авч, ямар саванд усаа зөв хадгалах талаар эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааг тэдэнд байнга хүргэж байх ёстой. Усны саваа байнга угааж, ариутган, зориулалтын саванд усаа хадгалдаг зүй тогтол, хэвшилд сургах ёстой. ДЭМБ-ын зүгээс энэ төлөвлөгөөг яваандаа 21 аймаг болон бүх сумуудад жижиг суурин газарт усны аюулгүй байдлын төлөвлөгөөтэй болгох зорилготой байна. Бид тогтвортой байдлыг хангахын тулд бодлогын бичиг баримтанд өөрчлөлт оруулах ёстой болж байгаа.” гэж ярьсан юм.

Ер нь манай улсын усны үндэсний хорооны хүмүүс одоогийн бодлогын бичиг баримтандаа дүн шинжилгээ хийхдээ усны аюулгүй байдалтай яаж холбогдож байгаа ялгааг гаргажээ. Энэхүү бодлогын бичиг баримтыг судлах ажлыг мөн

ДЭМБ-аас санхүүжүүлжээ. Ингэж дүн шинжилгээ хийсний дараа ямар ямар хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж болох саналыг боловсруулсан байна. Энэ саналаа ажлын хэсэг Ариун цэвэр эрүүл ахуйн ажлын хэсгээр хэлэлцүүлээд эцсийн байдлаар ДЭМБ-д өгөөд байгаа аж. Мэргэжлийн хяналтын газар Монгол улсын ундны усны стандартад усны аюулгүй байдалтай холбоотой тодорхой өөрчлөлтүүдийг оруулж өгч байгаа гэнэ. Мэргэжлийн хяналтын газар усны аюулгүй байдалд хяналтын арга хэмжээг тогтмол хийж, бусад холбогдох байгууллагуудтай хамтран тандалт хийж эхэлсэн байна. Энэ тандалтын зорилго нь усны чанарыг хянаж, үнэлэх ёстой юм. Үүнд тулгуурлаж бодлогын бичиг баримтанд өөрчлөлт хийж эхлээд байна. Ийнхүү “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-г Усны аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр, Хүрээлэн буй орчны эрүүл мэндийн хөтөлбөрт нэг бүлэг болгож оруулахаар мэргэжилтнүүд ажиллаж байна. Харин энэ бүх ажилд ДЭМБ боломжоороо санхүүжүүлж байгаа аж. Энэ төлөвлөгөө манай улсад тогтмол, эрчимтэй, чанартай явагдвал хүн амын ундны усны аюулгүй байдал хангагдаж, айх аюулгүй, цэвэр, цэнгэг усаа тайван хэрэглэж болох нь ээ. Мөн улмаар усаа хэмнэх үүднээс гадаргын усыг ариутгаад, ундны усанд зориулах “төлөвлөгөө” ч хэрэгжих бололтой.



Б.БАЯРМАА



Б.ТӨМӨРХУЯГ: МАНАЙ АЙМГИЙН ТӨВИЙН ЦЭВЭР УСАН ХАНГАМЖИЙН НӨӨЦ БАГАССАН БАЙНА

“Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг орон нутагт өргөжүүлэх, Ус сувгийн удирдах газрын туршлага судлах” үндэсний сургалт энэ сарын 15-19-ны өдрүүдэд ЭМЯ-д болж байна. Сургалтын үеэр Дорноговь аймгийн Засаг даргын орлогч Б.Төмөрхуягтай ярилцлаа.

- Энэ сургалтаас шинэлэг юу мэдэж авч байна вэ?

-Манай аймаг Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг аймагтаа хэрэгжүүлэх төслийн тухай ярьж байгаа. Цаашдаа төлөвлөгөөг нэг удаа боловсруулж орхих биш жил болгон сайжруулж байх нь зөв юм. Тиймээс манай аймгаас ирсэн инженер,техникч хоёр сургалтад хамрагдаж, ДЭМБ-ын зөвлөх гадаад хүнээс зөвлөмж, үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа Ус сувгийн удирдах газрын болон холбогдох байгууллагын туршлага зэргийг судлаж, мэдэж байна. Аймагтаа очоод төлөвлөгөөгөө сайн сайжруулах, төлөвлөгөөний дагуу идэвхитэй ажиллах шаардлагатай гэдгээ ойлголоо. Сум багийн түвшинд Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг гарган олон нийтийн оролцоог хангаж төлөвлөгөөтэй болгох хэрэгтэй юм байна. Ирэх 10-р сард хийх сургалтад оролцоно.

- Танай аймаг Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд яаж ажиллаж байна вэ?

- Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэхдээ хамгийн эхний асуудал болсон усанд хүний биенд сөрөг нөлөөтэй хиймийн элементүүдийг багасгах зорилго баримтлаж байгаа. Жишээ нь, нэгдэл, гүнцэл химийн элементийг бууруулах зорилгоор БНСУ-ын Засгийн газрын тусламжтайгаар усныхаа төв шугаманд хоёр ширхэг том тоног төхөөрөмж тавьсан. Эндээс авсан дээжээ явуулж шинжилгээ өгч байна. Манай аймгийн ундны усны гүнцэл элемент буурч байгаа. Хоёрт, Ус түгээх байрны эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангуулж байна. Манай аймгийн ус түгээх байрууд зөөврийн усаар биш төвлөрсөн усан хангамжтай холбогдсон. Гуравт, төвлөрсөн усан хангамжийнхаа шугам сүлжээг шинэчлэх ажлыг зохион байгуулж байгаа. Энэ ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкнаас 10 сая ам долларын төсөл хэрэгжиж байна. Энэ төслийн хүрээнд усны төмөр хоолойг зэвэрдэггүй хуванцар хоолойгоор сольж, усан хангамжийн шугам сүлжээнд хэрэглэдэг жишээг сүүлийн үед дэлхийн нийтэд зөвлөмж болгодог болсон.

-Аймгийн иргэдэд усны аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуйг сахих тухай зөвлөмж, мэдлэгийг ямар арга замаар олгож байна вэ?

-Аймгийн хэмжээнд хүүхэд, залуучууд, оюутнууд, иргэдэд зориулсан хэсэгчилсэн сургалт явуулж байгаа. Манай аймгийн Эрүүл мэндийн болон Мэргэжлийн хяналтын газраас энэ ажлыг зохион байгуулаад хэвшсэн. Харин ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөтэй холбоотойгоор сургалтын давтамжийг нэмэгдүүлсэн. Жишээ нь, гараа угаахдаа усаа хэмнэх ухамсрыг суулгах тухай, гэр хорооллын оршин суугчид цэвэр, бохир усныхаа системийн дээд доод хэсэг гэж тусгаарлах, эрүүл ахуйг нь хамгаалах талаар хүн болгонд зөвлөж, зааж байна.

-Танай аймгийн цэвэр ундны усны нөөц бусад аймгуудыг бодвол ямар хэмжээтэй байгааг судалсан уу?

-Манай аймгийн төвийн цэвэр усан хангамжийн нөөц багассан байна. Одоогоос 30 жилийн өмнө аймгийн төвөөс 17 км-т хэрэгждэг “З” хөтөлбөр аймгийн хүн амыг усаар хангадаг. Гэвч одоохондоо усны түвшин нэлээд доошилсон. Энэ нь цаашлаад 10 –хан жил усаар хангаж магадгүй байдал ажиглагддаг. Одоогийн байдлаар манай аймагт усны хайгуулын ажил хангалттай хийгдэж байна. Энэ хайгуулын судалгаа Сайншандын аж үйлдвэрийн парк байгуулах төлөвлөгөөтэй холбоотой. Сайншанд хот өргөжин тэлэхийн хэмжээгээр ундны усыг хангах асуудалд анхаарч гүний усны судалгаа хангалттай хийгдсэн. Ер нь манай аймагт Бор хөөврийн говь, Долоодын говь гэдэг хоёр том газрын доорхи усны бассейн оршдог. Энэ хоёрыгоо нэлээн сайн судалсан. Тиймээс Сайншанд хот цаашдаа эндээс цэвэр усаар тэжээгдэж болох юм гэж тооцож байгаа. Харин Монгол Улсын хэмжээнд яригдаж байгаа хамгийн чухал ажлын нэг бол усны том эх үүсвэр болсон “Хэрлэн говь төсөл”, “Орхон говь” төсөл юм. Энэ төслүүдээр голийн усыг говь руу татах асуудал яригдаж байна. Иймэрхүү хэтийн төлөвтэй судалгаа явагдаж байгаа нь усны асуудлыг шийдэх гарц болж байгаа гэж үзэж байна.

- Гүний усны судалгааг танай аймагт ямар компани хийж байгаа юм бэ?

- Өнгөрсөн жил ҮХААЯ-д Сайншандын аж үйлдвэрийн парк нэртэй төрийн өмчит компани байгуулагдсан. Энэ компани Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжиж, Сайншандын аж үйлдвэрийн паркын усны судалгааны төслийн хүрээнд судалгаа хийж байгаа. Энэ төсөл Чингис бондноос өндөр хэмжээний санхүүжилттэй ажиллаж байна.

Б.БАЯРМАА



С.БУМАА: УСААР ДАМЖИЖ ХАЛДВАРЛАДАГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОМЖ БҮРДЭНЭ

Ус сувгийн удирдах газрын сургалтын багш С.Бумаагаас “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар тодруулсан юм.

-Иргэдийн ундны усны аюулгүй байдлыг хангахын тулд чухал төлөвлөгөө боловсруулж байгаа юм байна. Эхний алхамд юу хийгдэж байна вэ?

-Хүн амыг аюулгүй, чанартай, баталгаатай усаар хангах асуудал нийгмийн өмнө тулгамдаж байна. Энэ чиглэлээр бид ДЭМБ-ын зөвлөмжөөр усны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж байна. УСУГ-аас 2012 оны 8-р сараас эхлээд Улаанбаатар хотын хүн амын ундны усны аюулгүй байдалд тохиолдож болох ямар эрдслүүд байна вэ, тэр эрдслүүдийг тогтоосны үндсэнд ямар арга хэмжээ авах талаар төлөвлөгөө боловсруулсан.

-Улаанбаатар хотын ундны усны аюулгүй байдалд нөлөөлсөн ямар эрдслүүд судалгаагаар илэрсэн бэ?

- Улаанбаатар хотын ундны усны аюулгүй байдалд нөлөөлж болох 74 тооны эрсдэл байна. Эрсдэл үүссэн болон үүсч болох гэж байгаа юм. Энэ эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд 179 арга хэмжээ авах шаардлагатайг төлөвлөгөөндөө тусгаж боловсруулсан.

- Ямар байгууллагуудтай хамтарч судалгаа хийж, энэ төлөвлөгөөг боловсруулсан бэ?

-УСУГ-ын даргын тушаалаар батлагдсан баг гарч ажилласан. Энэ багт УСУГ-ын инженер техникийн ажилтнууд, Нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, экологчид, БОНХЯ, МХГ-ын мэргэжилтан, Туул гол сав газрын захиргаа, ОБГ,НЗДТГ, Захирагчийн ажлын албанаас холбогдох мэргэжилтнүүдийг урьж оролцуулсан. Улаанбаатар хотын хүн амын ундны усны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө юм. Энд 2014-2016 онд хийх бүх ажлаа тооцож гаргасан.

- Монгол орны цэвэр болон ундны усны хангамж, усны чанар үнэхээр аюулгүй байдалд хүрчихээд байгаа юм уу?

-Ундны усны хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах асуудал зөвхөн Монгол оронд биш дэлхийн улс орнуудын өмнө тулгамдсан асуудал болоод байгаа юм. ДЭМБ энэ асуудалд онцгой анхаарал хандуулан Азийн бүсийн тодорхой орнууд, Номхон Далайн баруун бүсийн орнуудад хүн амын ундны усны аюулгүй байдлыг хангах хөтөлбөр боловсруулж, зохион байгуулан хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу манай улс хүн амын ундны усны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулсан. Ер нь Улаанбаатар хотын ундны усны хангамж, хүртээмжийн хувьд найдвартай эх үүсвэрээс хангагддаг гэж үздэг боловч ундны ус хэрэглэгчдэд хүрэх замдаа эрдсэл үүсч болох юм гэж мэргэжилтнүүд үзэж байгаа. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд ийм төлөвлөгөө гаргаж байгаа юм. Энэ асуудлыг шийдэхийн тулд Монгол улсын хэмжээнд, 21 аймагт ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар үндэсний сургалт, семинар таван өдөр явагдаж байна.

- Энэ төлөвлөгөө хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ?

-УСУГ-ын хувьд төлөвлөгөөг боловсруулж дуусгаад НЗДГ-ын удирдлагын зөвлөлийн хурал, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлж, батлуулна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт шаардлагатай. Ийм учраас хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн хуралд хэлэлцүүлэхээр бэлэн болсон. Гэхдээ бид энэхүү төлөвлөгөөний зарим арга хэмжээнээс хэрэгжүүлж эхэлсэн. Ус хангамжийн эх үүсвэр дээр тоног төхөөрөмж суурилуулах, усны шугам хоолойг шинэлчлэх, солих, доторлох гэх мэт ажлууд эхлүүлэх гэж байна. Гэр хороололд байгаа ус түгээх байруудыг шинэлчлэх, шугамд холбох, мөн хоолны давснаас хлор гарган авч халдваргүйжүүлэх шинэ технологи нэвтрүүлэх ажлууд хийгдэж байна. Ундны усны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх асуудал бол хүн амын эрүүл мэндийг хамгаалах чухал үүрэгтэй. Бид хүн амыг аюулгүй, чанартай усаар хангаж чадвал усаар дамжиж халдварладаг янз бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

- Улаанбаатар хотын ундны усны нөөц багасч байна гэх юм. Үнэн юм уу?

-Жилээс жилд Улаанбаатар хотын ундны усны нөөц багасч байна. Яагаад гэвэл маш их төвлөрөл бий боллоо. Хотод үйлдвэр, аж ахуйн газар, хүн ам өсч байна. Энэ нь ундны ус багасахад нөлөөлж байна. Тиймээс ундны усанд гадаргын усыг хэрэглэх асуудал хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан. Ер нь Туул голын сав газар усны нөөцийг нарийн судалсан байдаг.

-Энэ төлөвлөгөөг боловсруулах явцад ямар бэрхшээл тулгарч байна вэ?

-Монголд анх удаа хэрэгжиж эхэлж байгаа загвар төлөвлөгөө учир бидэнд бэрхшээл саад учирсан. Ялангуяа эрсдлээ үнэлэх, үнэлгээг зөв хийх ажилд нэг жил гаран хугацаа зарцуулсан. Байгууллагын стратегийн болон бизнесийн төлөвлөгөөтэй уялдуулах, НЗДТГ, Нийслэлийн иргэдийн хурлын бодлоготой уялдуулах гэх мэтийн бэрхшээлтэй ажлуудыг давж туулаад байна.

-Хөрөнгө оруулалтын санхүүжилт тодорхой болсон юм уу?

-Хөрөнгө оруулалтыг Монгол Улсын Засгийн газар, НЗДТГ, Нийслэлийн иргэдийн хурлаас шийдвэр гаргаад, УСУГ-аас ямар хөрөнгө оруулалт оруулж, юу хийх нь тодорхой тусгагдаж байгаа.

-Ийм төлөвлөгөөг хэрэгжүүлсэн гадаадын ямар орны сайн туршлага байдаг вэ?

-Олон орны туршлага байдаг. Бидний судалж байгаа орон бол Австрали улсын туршлага их сайн юм байна. ЭМЯ, ДЭМБ, Суурин төлөөлөгчийн газар, бусад холбогдох газруудаас мэргэжилтнүүд Австрали улс руу явж, арвин туршлага, мэдээлэл хуримтлуулсан байсан.

Б.БАЯРМАА



ОРХОН АЙМГИЙН “ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК

ЭРХЭМ ЗОРИЛГО

Манай компани орчин үеийн техник технологийн ололт амжилтад тулгуурлан хэрэглэгчдээ цахилгаан, дулаан, усаар хангана.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

- Компанийн эдийн засгийн үрашиг, санхүүгийн чадавхыг сайжруулах, авлага, өр төлбөрийг барагдуулах, компанийн тогтвортой хөгжлийн хэрэгцээг хангахуйц үнэ тарифын механизмыг бүрдүүлж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн засвар шинэчлэлийг мэргэжлийн өндөр төвшинд шуурхай гүйцэтгэх шинэ техник технологи, тоног төхөөрөмжтэй байх, компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.
- АХ Банкны зээл тусламж, өөрийн эх үүсвэрийн нөөц бололцоог оновчтой үр дүнтэй ашиглах зэрэг тэргүүн зорилтуудыг тавин ажиллаж байна

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮД:

1. Цахилгаан түгээх,
2. Цахилгаанаар зохицуулалттай хангах,
3. Дулаан түгээх,
4. Дулаанаар зохицуулалттай хангах,
5. Барилга угсралт /2.1.1; 2.1.2; 2.2.1; 2.2.2, 2.2.3, 2.2.5/
6. Хот, суурины ус хангамж, ариутгах татуурга ашиглалтын ажил үйлчилгээ эрхлэх /12.2.1-12.2.14/ тусгай зөвшөөрөл,
7. Цахилгаан угсралтын ажил үйлчилгээ эрхлэх,
8. Цахилгаан шатны ашиглалт, засвар үйлчилгээ эрхлэх,
9. Цахилгаан эрчим хүчний нэг ба гурван фазын тоолуур
10. Цахилгаан тоолуур суурилуулах, худалдах,
11. Цахилгаан болон усны тоолуур, даралтын болон хүчилтөрөгчийн манометр бусад төрлийн даралтын датсик засварлах,
12. Халуун хүйтэн ус, дулааны тоолуур суурилуулах, худалдах,
13. Мөн хүчилтөрөгчийн болон бусад төрлийн манометр, даралтын датчик суурилуулах, засварлах худалдах





“Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ” компани нь Эрдэнэт хотын 345 байрны 11860 өрхийн 27450 хүн ам, 1460 орчим аж ахуйн нэгж байгууллага, Жаргалант болон Баян Өндөр сумын 60 гаруй мянган гэр хорооллын хүн амыг унд ахуйн хэрэгцээний цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулж, дулаан, цахилгаан эрчим хүчээр хангаж, хотын төв болон багуудын авто замын дагуух гэрэлтүүлгийн ашиглалт, засвар үйлчилгээ мөн тэдгээрийн инженерийн байгууламж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган ард иргэдийн тав тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэн 24 цагийн турш тасралтгүй үйлчилгээ үзүүлж байна.

Манай компани нь нийт 322 ажиллагсадтай Инженер, эдийн засгийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Дулаан түгээх сүлжээний алба, Цахилгааны алба, Усан хангамжийн алба, Ариутгах татуургын алба, Диспетчерийн алба, Барилга, засвар техник үйлчилгээний алба, Борлуулалтын алба, тоолуурын лабораторийн хэсэг гэсэн бүтэц зохион байгуулалттай ажиллаж байна. Монгол улсын хугацаагүй эрхт зөвлөх инженер 1, хугацаагүй эрхт мэргэшсэн нягтлан бодогч 2, хугацаагүй эрхт зөвлөх эдийн засагч 1, мэргэшсэн инженер 7 зэрэг хөдөлмөрч хамт олон ажиллаж байна.

шилдэг ажил олгогч” байгууллага.

7. 2009 онд - Нийгэмд стандарт хэвшүүлэх сангаас шалгаруулсан “Итгэл хүлээлгэсэн хамт олон”.
8. 2009 онд - МҮХАҮТанхимын “Үнэмлэхүй манлай” байгууллага.
9. 2010 онд - Монголын Татварын албаны “TOP-30” байгууллага.
10. 2011 онд - Орхон аймгийн НДХэлтсийн “Тэргүүний шимтгэл төлөгч TOP-10” байгууллага.
11. 2011 онд - Монголын шилдэг ажил олгогч эздийн Есөн эвт холбооны “Оны шилдэг ажил олгогч” өргөмжлөл
12. 2011 онд - Орхон аймгийн Татварын хэлтсээс Тэргүүний татвар төлөгч TOP 10
13. 2011 онд - Ажил олгогч эздийн холбооноос аймгийн 3 талт хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлсэн шилдэг байгууллагаар шалгарч “Өргөмжлөл”.
14. 2012 онд - Орхон аймгийн Татварын хэлтсээс “Тэргүүний татвар төлөгч” байгууллага.
15. 2013 онд - Ажил олгогч эздийн холбооноос аймгийн 3 талт хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлсэн шилдэг байгууллагаар шалгарч “Өргөмжлөл”.
16. 2013 онд - Үйлдвэрчний эвлэлийн холбооноос “Шилдэг, удирдагч, дэмжигч” зэрэг шагналт байгууллага юм.

БИДНИЙ АМЖИЛТ

1. 1997, 2002 онд - Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартыг нэвтрүүлсэн анхны 10 байгууллагын нэг.
2. 1997, 2002 онд - Орхон аймгийн 2003 оны “ТОП-10” аж ахуйн нэгж.
3. 2006 онд - Шилдэг тохижилттой байгууллага.
4. 2005, 2006, 2009 онд - Найдвартай татвар төлөгч.
5. 2008 онд - Нийгмийн даатгалын итгэлтэй түнш “TOP-10”.
6. 2009 онд - Нийгмийн даатгалын ерөнхий газраас “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч





МАНАЙ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД

- Ус хангамжийн 104 км шугам, 222 ш гадна худаг, цэвэр усны эх үүсвэр гүний 10 худаг, цэвэр усны 2000 м3, багтаамжтай 2ш, 1000 м3 багтаамжтай 2ш, 100 м3 багтаамжтай 1ш, 50 м3 багтаамжтай 10ш резервуар, 2-р өргөлтийн насос станц, 72ш ус түгээх байр.



Дулааны 41 км шугам, хэрэгцээний халуун усны 9.8 км гадна шугам, дулаан дамжуулах 38 төв, 175-н дулааны худгийн 1400 гаруй хаалт арматур, 324 дулааны зангилаагаар хэрэглэгчдэд халаалт, хэрэгцээний халуун усыг түгээж, хангаж байна. ДДТөвүүд нь сүүлийн үеийн халаалт болон хэрэгцээний халуун усны Danfoss Siemens маркийн ялтсан бойлороор шинэчлэгдэж байгаа бөгөөд халаалтын 41,5 хувь нь хэрэгцээний халуун усны 70 хувь нь мөн Грунтфос, WILLA фирмийн 82 ширхэг цахилгаан насосыг шинэчлэн суурилуулсан.

- Цахилгаан дамжуулах 35кВ – 8,7км, 6кВ – 6км, 0,4кВ – 20,1км нийт 34,8км агаарын шугам, 6кВ -19,1км, 0,4кВ – 52,6км нийт 71,7км урттай кабель шугам.
- 35/6кВ - 1ш, 6/0,4кВ -19ш /ЛПИ/, 6/0,4кВ– 8ш / АТП/, гэрэлтүүлгийн 7 дэд станц цахилгаан хуваарилах төвүүд



- Цахилгааны 1 ба 3 фазын механик электрон ба импульсийн тоолуур засварлах шалгах тоолуурын лаборатори.



- Ф15-Ф50 хүртэлх халуун, хүйтэн усны тоолуур шалгах, засварлах тоолуурын лаборатори.



- Гудамж талбайн 2200 ш шон 504 ш орчин үеийн LED гэрэл 6900 толгойн гэрэлээр гэрэлтүүлэгт ашиглагдаж байна.



- Ус зөөвөрлөх, бохир ус соруулах, замын гэрэлтүүлэгийн авто вишка, кран, сомосвал, экскаватор, аваарь техникийн засвар үйлчилгээний зэрэг тусгай тоноглолын болон шуурхай үйлчилгээний 34 ш машин механизм ажиллаж байна.



- Ариутгах татуургын 52,2 км шугам, 2600 ш гадна худаг, хоногт 400 м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 16 м3/цаг хүчин чадалтай бохир ус татан зайлуулах станц.



- Жаргалант сумын 84,2 км цэвэр усны шугам 400м³ хүчин чадалтай цэвэрлэх байгууламж зэрэг шугам сүлжээ, тоног төхөөрөмж ашиглагдаж байна.

2014 онд манай компанийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжөө шинэчлэн засварлаж, хэрэгжсэн шинэ техник технологи, бүтээн байгуулалтын томоохон ажлууд. Үүнд

1. АХБ-ны зээл тусламжаар Хот байгуулалтын салбарын МОН-2301 төслийн хүрээнд хэрэгжсэн ундны эх үүсвэр, өргөлтийн насосны станц, усан сан, шугам сүлжээг шинээр барьж 49 ш ус түгээх байр, гэр хороололд байрлалтай сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон бусад аж ахуйн нэгжийг усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбосон ажлыг 2014 оны 5-р сарын 30-нд хүлээн авч ашиглалтын байдлыг хариуцан ажиллаж байна.



Төслөөр дараах барилга байгууламж, шугам сүлжээ ашиглалтад орлоо.

- o Хлоржуулах тоног төхөөрөмж
- o Цэвэр ус дамжуулах 35 км шугам
- o 2-р өргөлтийн насосны станц
- o 5,7 км ариутгах татуургын шинэ шугам
- o 4.8 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөө
- o 1000 м3 багтаамжтай 2 усан сан болон 100



м3 багтаамжтай 1 ш усан сан
 о МОН 2301 төсөл хэрэгжсэнээр Орхон аймгийн Баян-Өндөр сумын 48000 орчим хүн ам, гэр хороололд байршилтай 2 сургууль цэцэрлэг бусад аж ахуйн нэгж, хэрэглэгчдийг орчин үеийн зөөлөн ширэм, хуванцар хоолойтой инженерийн төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системд холбож эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан усаар хангах нөхцөл бүрдсэн. Цаашид айл өрх, хэрэглэгчдийг усан хангамжийн энэ системд нэмж холбох бололцоотой юм.

2. Улсын хөрөнгө оруулалтаар хотын дулаан, цэвэр усан хангамжийн 5535 м төв болон салаа шугам сүлжээг зэвэрдэггүй хуванцар хоолойгоор сольж шинэчилсэн нь шугам хоолойн насжилтыг нэмэгдүүлж, унд ахуйн усны чанарын шаардлага хангасан усаар тасралтгүй хангаж байна.

3. Хотын цахилгааны өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ, хангамжийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн хөрөнгөөр РП-201-ээс ТП-216, ТП-216-аас ТП-215, ТП-205-аас ТП-219, ТП-215-аас ТП-204, ТП-238-аас ТП-239 хүртэл насжилт өндөртөй 6 кВ-ын 3,6 км кабель шугамын шинэчлэл хийсэн. Гэр хороололын хэрэглэгчдийн зүй бус алдагдлыг бууруулах зорилгоор 25 ширхэг тоолуур нэгтгэлийн хайрцаг суурилуулан 2,0 км агаарын АС-16 утсыг СИП кабелиар шинэчлэн солиод байна. Хотын төв хуваарилах байгууламж 35/6 кВ-ын ЦРП -2 дэд станцын нийт 24 тосон таслуурыг вакуум таслуураар сольж шинэчилсэн. 35/6 кВ-ын ЦРП -2 дэд станц нь телемеханикийн системээр диспетчирийн удирдлагатай холбогдсоноор реле хамгаалалт автоматикийн мэдээлэлийг шууд авч аваарь гэмтлийг цаг алдалгүй түргэн шуурхай арилгаж, болзошгүй аваарь ослоос урьдчилан сэргийлж байна.

4. Хотын доторхи төв замын 96 ширхэг 400Вт, 250Вт -ийн улайсах лампыг 156, 84Вт-ын LED гэрэлтүүлгээр шинэчлэн сольсон. Үүний үр дүнд асаалтын зардлыг 1,5-2,0 дахин хэмнэж чадсан. Дээрхи гэрэлтүүлгүүд нь GSM сүлжээнд холбогдсон бөгөөд интернэтээс тоолуурын заалт харах, цаг тохируулах, асааж, унтраах, асалтыг хянах бүрэн боломжтой болсон нь ажлын бүтээмжийг дээшлүүлсэн шинэлэг ажил болсон. Энэ шинэ санааны үргэлжлэл болгон гэр хороололд шинээр 2900 ширхэг 56Вт-ийн LED гэрэлтэй гэрлийн шонг гудамж, хооронд суурилуулж байна. Ингэснээр оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөл сайжирч байна.

5. Эрдэнэт хотын 9 давхар орон сууцны 4-14-1, 4-14-2, 4-18-1, 4-18-2, 4-20-2, 5-2, 5-6, 5-7, 5-20 дугаар байруудын хуучирсан цахилгаан шатуудыг ПП-401 Могилев маркийн шинэ лифтээр шинэчлэн

засварлалаа. Цахилгаан шатны шинэчлэлийн ажлаар хийгдсэн онцлог ажил нь манай компанийн диспетчирийн нэгдсэн удирдлага хяналтад орж байгаа явдал юм. Ингэснээр бид цахилгаан шатны асаалт, зогсолт, цаг ашиглалт сайжирч гэмтэл саатлыг засах, ашиглалт үйлчилгээг диспетчирийн удирдлагаар хянаж шуурхай үйлчилгээг хангаж ажиллах давуу талтай юм. Нийтдээ манай компани 17 байрны цахилгаан шатны засвар ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

6. Эрдэнэт хотын усны эх үүсвэр, усан хангамжийн барилга байгууламжийг харуул хамгаалалттай болгох аюулгүй байдлыг хангах асуудлыг АИТХТ-ийн 2010 оны 87 р тогтоолоор шийдвэрлэж 2013-2014 онд Дэнж багийн 50*10м3 усан сан, Бүрэн бүстэд байршилтай өөрийн эх үүсвэрийн гүний худгууд, 100 м3 усан сан, 2-р өргөлтийн насос станц, 1000*2 м3 усан сан цагдаагийн харуул хамгаалалттай ажиллаж, эх үүсвэрийн орчны хамгаалалт, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн тохижилт, ариун цэврийн байдал сайжирч байна.

7. Компанийн хэмжээнд нэгж хэсгүүдэд доголдолтой байгаа үйл ажиллагааг сайжруулах, бүтээмж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж, орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр олж авах санал санаачлага гарган хэрэгжүүлэх зорилготой болзолт уралдаан хэлэлцүүлгийг инженер техникийн ажилчид 2014 оны 03-р сард зохион байгуулж, дүгнэн шагнаж урамшуулж, хэлэлцүүлгийн дүнгээр хийгдэх 20 ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Барилга, хот байгуулалтын сайдын

2014 оны 90 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

АРИУТГАХ ТАТУУРГА, ГАДНА СҮЛЖЭЭ БА БАЙГУУЛАМЖ БНБД 40-01-14

Sewerage. External network and facilities

1. Хамрах хүрээ

Энэхүү норм ба дүрмийг ахуйн бохир ус түүнтэй ижил төстэй найрлага бүхий үйлдвэрийн бохир ус, хур борооны усны байнгын зориулалт бүхий ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламжийг өргөтгөх, шинэчлэх, шинээр барих зураг төсөл боловсруулахад мөрдөнө. Энэхүү норм ба дүрэм нь 300 000 м³/хон-оос дээш хүч чадалтай ариутгах татуурын системд хамаарахгүй.

2. Норматив ишлэл

Энэхүү норм ба дүрэмд ишлэл татсан дараах стандарт баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг иш татан хэрэглэнэ. Үүнд:

MNS 4288:1995 Бохир усны цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих шаардлага

MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага

MNS 4236:2003 Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл

MNS 4943:2011 Усны чанар. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага

MNS 6279:2011 Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томъёо Тодорхойлолт-Тайлбар толь

БНБД 21-01-02 Барилга, байгууламжийн зураг

төсөл зохиох галын аюулгүйн дүрэм

БНБД 22-01-01*/2006 Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм

БНБД 22-03-09 Хөндийт ухмалтай талбай болон суумтгай хөрсөнд барилга байгууламжийг төсөллөх

БНБД 23-01-09 Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт

БНБД 30-01-04 Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт

БНБД 30-02-07 Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө

БНБД 40-02-06 Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж

БНБД 40-05-98 Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга

БНБД 3.05.04-90 Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга, байгууламж

БНБД 3.05.06-90 Цахилгаан техникийн ажил

БД 43-101-03 Цахилгаан байгууламжийн дүрэм

3. Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү норм ба дүрэмд MNS 6279:2011 “Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томъёо, Тодорхойлолт-Тайлбар толь” ба Хавсралт “А”-д дурдсан нэр томъёо, тодорхойлолтыг ашиглав.



4. Ерөнхий зүйл

4.1. Объектын ариутгах татуургын схем ба системийг сонгоходоо бохир усны цэвэрлэгээнд тавих шаардлага, цаг уурын нөхцөл, гадаргын өндөржилт, геологи ба гидрогеологийн нөхцөл, ариутгах татуургын системийн одоогийн байдал болон бусад хүчин зүйлийг харгалзсан байвал зохино.

4.2. Зураг төсөл зохиоходоо ариутгах татуургын системийг аль болохоор төвлөрүүлэн төлөвлөх оновчтой хувилбарыг авч үзэх шаардлагатай ба ашиглагдаж байгаа барилга байгууламжийн техник, эдийн засаг, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл, тавигдаж буй шаардлага үнэлэмжүүдийг харгалзан тэдгээрийг ашиглах ба ажлыг нь эрчимжүүлэх боломжтойг тусгасан байвал зохино.

4.3. Ахуйн ба үйлдвэрийн бохир усыг тэдгээрийн шинж чанараас хамааруулан хамтад нь буюу тусад нь цэвэрлэхийг зөвшөөрөх ба цэвэршүүлсэн усыг аль болох давтан буюу эргүүлэн ашиглах нөхцөлийг авч үзнэ.

4.4. Объектын ариутгах татуургын зураг төсөл нь зарчмын хувьд тэдгээрийн ус хангамжийн схемтэй уялдсан байх ёстой ба ингэхдээ цэвэрлэсэн бохир ус, хур борооны усыг үйлдвэрийн ус хангамж ба усжуулалт болон бусад хэрэгцээнд ашиглах боломжийг заавал авч үзвэл зохино.

4.5. Үйлдвэрийн ариутгах татуургын схемийг сонгоход зайлшгүй тооцох хүчин зүйлүүд:

- хуурай, хаягдалгүй үйлдвэрлэл, ус хангамжийн битүү систем, хөргөлтийн агаарын арга нэвтрүүлснээр технологийн дамжлагуудын явцад үүсдэг бохир усны хэмжээг бууруулах боломж
- зарим бүрдэл хэсгийг ялган авах зорилгоор бохир усыг байран дээр нь урьдчилан цэвэрлэх боломж
- усыг янз бүрийн технологийн процесст давтан буюу эргүүлэн ашиглах боломж
- үйлдвэрийн бохир усыг усны объектод буюу суурьшлийн бүсийн ариутгах татуургын системд нийлүүлэх боломж
- цэвэрлэгээний явцад үүсдэг лаг, тунадасыг зайлуулах ба ашиглах нөхцөл

4.6. Янз бүрийн бохирдуулагч бодистой үйлдвэрийн бохир усны цутгаланг тэдгээрийг хамт цэвэрлэх нь оновчтой бол нэгтгэнэ. Ингэхдээ шугам сүлжээнд (хийн ба хатуу бүтээгдэхүүн үүсгэх) химийн процесс явагдах боломжийг зайлшгүй тооцох хэрэгтэй.

4.7. Үйлдвэрийн газрын ариутгах татуургын сүлжээг хот, суурин газрын сүлжээнд холбохдоо үйлдвэрийн талбайн гадна хяналтын худаг бүхий

гаргалгааг төлөвлөж өгвөл зохино. Үйлдвэр бүрээс гарч байгаа бохир усны зардал хэмжигчийг төлөвлөвөл зохино. Хэд хэдэн үйлдвэрийн газрын бохир усыг үйлдвэр бүрийн хяналтын худгийн дараа нэгтгэхийг зөвшөөрнө.

4.8. Бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх үйлдвэрийн бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг мөрдөж буй норм, дүрмийг баримтлан авбал зохино. Дээрх шаардлаганд үл нийцэж байгаа үйлдвэрийн бохир усанд урьдчилсан цэвэрлэгээ хийх ёстой. Цэвэрлэгээний зэргийг ус сувгийн болон холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагатай зөвшилцөн тогтоосон байх ёстой.

4.9. Суурьшлийн нутаг дэвсгэр ба үйлдвэрийн газрын талбайгаас гардаг гадаргын урсац усыг (хур борооны ус, хайлсан цасны ус, зам, талбай усалсан ус) цэвэршүүлэлгүйгээр усны объектод нийлүүлэхийг хориглоно.

4.10. Бохир усны бүх төрлийг (суурьшлийн нутаг дэвсгэр ба үйлдвэрийн газрын талбайгаас гардаг гадаргын урсац усыг оруулаад) хамтад нь зайлуулдаг ариутгах татуургын нэгдсэн ба хагас салангид системийн цэвэрлэх байгууламжийг төсөллөхдөө энэхүү норм ба дүрмийн холбогдох заалтуудыг мөрдлөг болговол зохино.

4.11. Хур бороо, хайлсан цас, зам талбай угаасан уснаас бүрддэг гадаргын урсацын хамгийн их бохирдсон тухайлбал суурьшлийн бүсийн нутаг дэвсгэр ба үйлдвэрийн газрын талбайн жилийн урсацын хэмжээний 70%-иас доошгүй, түүнчлэн их хэмжээний органик бодис ба хортой шинж чанартай тусгай бодисоор бохирдсон хэсгийг цэвэрлэх ёстой.

4.12. Үйлдвэрийн бүс, барилгын талбай, агуулах, авто аж ахуй тэрчлэн хотын суурьшлийн бүсийн нутаг дэвсгэр дээр оршдог онцгой бохирдолтой хэсгүүд (шатахуун түгээх станц, авто зогсоол, автобусны станц, худалдааны төвүүд гэх мэт)-ээс гарах гадаргын урсацыг борооны усны сүлжээ буюу ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэхээс өмнө байран цэвэрлэх байгууламжид цэвэрлэсэн байх ёстой.

4.13. Суурьшлийн нутаг дэвсгэр ба үйлдвэрийн газрын талбайгаас гардаг гадаргын урсацыг усны объектод нийлүүлэх гаргалгааны нөхцөлийг тодорхойлохдоо "Усны тухай хууль" болон бусад холбогдох стандарт, норм дүрмийг мөрдлөг болговол зохино. Гадаргын урсац усыг зайлуулах, цэвэрлэх схем мөн цэвэрлэх байгууламжийн хийцийг түүний чанарын ба тоон үзүүлэлт, техник-эдийн засгийн үндэслэлийн хувилбаруудыг харьцуулсны үндсэн дээр гүйцэтгэнэ.

4.14. Суурьшлийн бүс ба үйлдвэрийн талбайн хур, борооны усны ариутгах татуургын байгууламжийг төсөллөхдөө цэвэрлэгдсэн усыг үйлдвэрийн ус хангамж, усжуулах буюу усалгаанд



ашиглах хувилбарыг зайлшгүй авч үзнэ.

4.15. Зураг төсөлд тусгасан техникийн үндсэн шийдлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх ээлж дараалал нь ариун цэвэр, эрүүл ахуй, экологийн шаардлагыг тооцсон боломжит хувилбаруудын техник-эдийн засгийн харьцуулалт дээр үндэслэсэн байх ёстой.

4.16. Ариутгах татуургын сүлжээ, барилга байгууламжийг төсөллөхдөө дэвшилтэт техникийн шийдэл хөдөлмөр зарцуулалт ихтэй ажлыг механикжуулах, технологийн процессуудыг автоматжуулах, барилга-угсралтын ажлыг үйлдвэржүүлэхийг төлөвлөсөн байх ёстой. Цэвэрлэгдсэн ус, тунадасыг дахин ашиглах боломж, цэвэрлэх байгууламжийн хэрэгцээнд эрчим хүчний хоёрдогч эх үүсвэр байх хувилбарыг төсөллөх, дулааны ба цахилгааны эрчим хүчийг хэмнэх боломжийг тооцсон байвал зохино. Ашиглалтын явцад болон урьдчилан сэргийлэх ба засварын ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөлийг зайлшгүй биелүүлэх ёстой.

4.17. Ариутгах татуургын объектын байршил, түүний шугам сүлжээний трасс, тэрчлэн цэвэрлэгдсэн ус ба гадаргын урсацыг усны объектод нийлүүлэх нөхцөл, гаргалгааг Монгол Улсын зохих хууль тогтоомжийн дагуу орон нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага болон бусад холбогдох байгууллагатай зөвшилцөх зайлшгүй шаардлагатай.

4.18. Ариутгах татуургын системийн найдвартай ажиллагаа нь түүний бүрдэл хэсгүүдийн (шугам сүлжээ, байгууламж, тоног төхөөрөмж гэх мэт) найдвартай ажиллагаанаас хамаарах ба тэдгээрийг тодорхойлоходоо технологийн, ариун цэвэр, эрүүл ахуйн болон ус хамгаалах шаардлагуудыг зайлшгүй тооцно. Ариутгах татуургын системийн найдвартай ажиллагаа нь зайлшгүй шаардлагатай нэвтрүүлэх чадварыг хадгалах, бохир усны цэвэрлэгээний зэрэглэл, түүнийг усны объектод нийлүүлэх нөхцөл, цахилгаан хангамжийн тасалдлын улмаас шугам сүлжээ, байгууламж, тоног төхөөрөмж дээр гарч болох осол, хор уршиг, төлөвлөгөөт засварын ажил, газар хөдлөлт, хөрсний суулт, "мөнх цэвдэг" гэх мэтийн хүчин зүйлээр тодорхойлогддо.

4.19. Ариутгах татуургын системийн тасралтгүй ажиллагааг хангахад дараах хүчин зүйлүүд нөлөөлнө:

- ариутгах татуургын объект нь цахилгаан хангамжийн найдвартай эх үүсвэрээр хангагдах ёстой (үл хамаарах хоёр эх үүсвэр, нөөц цахилгаан үүсгүүр, аккумуляторын батарей гэх мэт)
- шугам хоолойг сэлгэн залгах боломжтой төлөвлөх
- ослын (буфер) сантай байх

- зэрэгцээ ажиллаж байгаа байгууламжийг засвар буюу урьдчилан сэргийлэх үзлэгийн үед сэлгэн залгах боломжтой
- нэг зориулалттай ажлын тоног төхөөрөмжийг нөөцтэй байлгах
- тоног төхөөрөмж, байгууламжийн зайлшгүй шаардлагатай хүч чадал, нэвтрүүлэх чадвар, багтаамж, бат бэхийг хангах аваарийн үед цэвэрлэгээний үр дүн буюу системийн нэвтрүүлэх чадварыг зөвшөөрсөн хэмжээнд бууруулахыг тодорхойлох

4.20. Ариутгах татуургын байгууламжаас орон сууцны барилгажилтын хязгаар олон нийтийн барилгын хэсэг, хүнсний үйлдвэр хүртэлх ариун цэвэр хамгаалалтын бүсийг тэдгээрийн хэтийн төлөвлөлттэй уялдуулан ариун цэврийн нормын дагуу авбал зохих ба тэдгээрийг зөрчих тохиолдолд эрүүл ахуй халдвар судлалын болон мэргэжлийн хяналтын байгууллагатай зөвшилцсөн байна. Хүн ам оршин суугаа болон нийтийн зориулалттай байр, хүнсний үйлдвэрийн байршил, цэвэрлэх байгууламж хоорондын зайг Хүснэгт 1-д зааснаар тооцож авна.

Хүснэгт №1 Хүн ам оршин суугаа болон нийтийн зориулалттай байр, хүнсний үйлдвэрийн байршил, цэвэрлэх байгууламж хоорондын зай

д/д	Байгууламж	Цэвэрлэх байгууламжийн бүтээмж /мян.м ³ /хон/-ээс хамаарах ариун цэвэр хамгаалалтын бүсийн зай /м/			
		0.2 хүртэл	0.2 -5 хүртэл	5 -50 хүртэл	50 -300 хүртэл
0	1	2	3	4	5
1	Исгэсэн лагийг хуурайшуулах зориулалтын талбай бүхий механик ба биологи цэвэрлэгээний байгууламж болон тусдаа байрласан лагийн талбай	150	200	400	500
2	Лагийг битүү орчинд дулаан механикийн аргаар боловсруулдаг механик ба биологийн цэвэрлэгээний байгууламж	100	150	300	400



д/д	Байгууламж	Цэвэрлэх байгууламжийн бүтээмж /мян.м ³ /хон/-ээс хамаарах ариун цэвэр хамгаалалтын бүсийн зай /м/			
		0.2 хүртэл	0.2 -5 хүртэл	5 -50 хүртэл	50 -300 хүртэл
3	Шүүрүүлэх талбай	200	300	500	-
4	Таримал ургамлын усалгаатай талбай	150	200	400	-
5	Биоцөөрөм	200	200	300	300
6	Эргүүлэн исэлдүүлэх сувагтай байгууламж	150	-	-	-
7	Насосны станц	15	20	20	30

Тайлбар:

1. Ариутгах татуургын цэвэрлэх байгууламжийн бүтээмж нь 300 мян.м³/хон-оос их ба бохир усыг цэвэрлэх болон лагийг боловсруулах технологийн өөр шийдэлтэй бол ариун цэвэр хамгаалалтын бүсийн зайн хэмжээг мэргэжлийн хяналтын байгууллагаас тогтооно.

2. Ариун цэвэр хамгаалалтын бүсийн зайн нэгдүгээр хүснэгтэд заасан хэмжээг доорх байдлаар өөрчлөхийг зөвшөөрнө. Үүнд:

2.1. Цэвэрлэх байгууламж нь суурьшлийн бүсийн салхины дээд талд байрлах тохиолдолд ариун цэвэр хамгаалалтын бүсийн зайн хэмжээг 2 дахин ихэсгэж болно.

2.2. Салхины чиглэл тааламжтай нөхцөлд дээрх зайг 25% бууруулж болно.

3. Цэвэрлэх байгууламжийн дэвсгэр нутагт лагийн талбайгүй бол уг ариун цэвэр эрүүл ахуйн бүсийн зайн хэмжээг 30% бууруулж болно.

4. Ариун цэвэр хамгаалалтын бүсийн зайн хэмжээ нь:

4.1. Шүүрүүлэх талбай 0.5 га хүртэл бол 100 м

4.2. Механик, биологийн аргаар цэвэрлэхдээ биошүүлтүүр ашиглах техникийн шийдэлтэй, бүтээмж 50 м³/хон бол 100 м

4.3. Бохир ус цэвэрлэх бүтээмж нь 15 м³/хон-оос бага, хөрсөн доор шүүрүүлэхэд 15 м

4.4. Шүүрүүлэх суваг элс хайрган шүүлтүүртэй 25 м

4.5. Септикт 5 м, шүүрүүлэх худагт 8 м

4.6. Бохир усыг бүрэн исэлдүүлж, лагийг агааржуулж бүлэгнүүлэх бүтээмж нь 700 м³/хон

хүртэл, барилга дотор байрладаг бол 50 м

4.7. Бохир усыг сүлжээнд юүлэх станц 300м

4.8. Нутагшлын дэвсгэр газрын гадаргын усны цэвэрлэх байгууламжаас 100 м, насосны станцаас 15 м, үйлдвэрийн газрын цэвэрлэх байгууламжийн зайг мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрлөөр тогтооно.

4.9. Үнс, шаарга хуримтлуулан усгүйжүүлэх байгууламжийн зайг түүний бүтэц, найрлагаас хамааруулан мэргэжлийн хяналтын байгууллага тогтооно.

5. Хотын бохир усны тооцооны зардал. Ариутгах татуургын сүлжээний гидравлик тооцоо

5.1. Хувийн зардал, жигд бусын илтгэлцүүр ба бохир усны тооцооны зардал

5.1.1. Суурьшлийн бүсийн ариутгах татуургын сүлжээг төсөллөхдөө орон сууцны барилгаас татан зайлуулах ахуйн бохир усны тооцооны хоногийн (жилийн) дундаж хувийн зардлыг "Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж" БНБД 40-02-06-д заасны дагуу зам талбай, ногоон байгууламжийн усалгааны зарцуулалтыг үл тооцсон ус хэрэглээний хоногийн (жилийн) дундажтай тэнцүү авна.

5.1.2. Төвлөрсөн зарцуулалтыг тооцох шаардлагатай үед тусдаа байрласан орон сууц, олон нийтийн барилгуудаас татан зайлуулах бохир усны тооцооны зардлыг тодорхойлохдоо хувийн зардлыг "Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга" БНБД 40-05-98-д заасны дагуу тооцно.

5.1.3. Үйлдвэрийн бохир усны хэмжээ, түүний урсацын жигд бусын илтгэлцүүрийг технологийн өгөгдлөөр тодорхойлвол зохино. Ингэхдээ эргэлтийн ус хангамж хэрэглэх болон цэвэрлэгдсэн усыг дахин ашиглах боломжийн талаарх усны балансын судалгааг үндэслэх ба ийм өгөгдөл байхгүй бол ижил төстэй үйлдвэрийн өгөгдөл буюу нэгж бүтээгдэхүүн эсвэл түүхий эдэд ногдох ус хэрэглээний томсгосон нормыг үндэслэнэ.

5.1.4. Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээгүй дэвсгэр нутагт нэг оршин суугчид ногдох бохир усны хувийн зарцуулалтыг 25 л/хон байхаар тооцно.

5.1.5. Суурьшлийн бүсийн бохир усны зардлын тооцооны хоногийн дундаж нь энэхүү норм ба дүрмийн зүйл 5.1.1 ...5.1.4-д заасан зардлуудын нийлбэртэй тэнцүү байна. Тухайн орон нутгийн үйлдвэрийн бохир усны хэмжээ мөн тооцогдоогүй зардлыг суурьшлийн бүсийн бохир усны хоногийн дундажийн нийлбэрийн 6-12% ба 4-8%-тай тэнцүү гэж үзэн нэмж тооцно.

5.1.6. Бохир усны тооцооны хоногийн зардлыг энэхүү норм ба дүрмийн зүйл 5.1.5-д тодорхойлсон хоногийн (жилийн) дундаж зардлыг "Ус хангамж.



Гадна сүлжээ ба байгууламж” БНБД 40-02-06-д заасан хоногийн жигд бусын илтгэлцүүрээр үржүүлсэн үржвэртэй тэнцүү авбал зохино.

5.1.7.Бохир усны хоногийн, цагийн, цагийн доторх жигд бусыг тооцсон тооцооны ерөнхий хамгийн их ба хамгийн бага зардлыг сүлжээний хэлбэр насосны станцтай эсэх, үйлдвэрийн газрууд, суурьшлийн бүсүүд, барилга байгууламжаас гарах бохир усны цутгалангийн графикыг харгалзан бохир усыг татан зайлуулах системийг компьютерт загварчлан тооцсон үр дүнгээр тодорхойлбол зохино. Ийм өгөгдөл байхгүй бол хамгийн их ба хамгийн бага илтгэлцүүрийг Хүснэгт 2-д заасны дагуу авна.

Хүснэгт №2 Бохир усны хоногийн, цагийн, цагийн доторх жигд бусыг тооцсон тооцооны ерөнхий хамгийн их ба бага зардал

Бохир усны цутгалангийн жигд бусын ерөнхий илтгэлцүүр	Бохир усны дундаж зардал, л/сек								
	5	10	20	50	100	300	500	1000	5000 ба дээш
1%-ийн “хангалттай” хамгийн их	3,0	2,7	2,5	2,2	2,0	1,8	1,75	1,7	1,6
1%-ийн “хангалттай” хамгийн бага	0,2	0,23	0,26	0,3	0,35	0,4	0,45	0,51	0,56
5%-ийн “хангалттай” хамгийн их	2,5	2,1	1,9	1,7	1,6	1,55	1,5	1,47	1,44
5%-ийн “хангалттай” хамгийн бага	0,38	0,46	0,5	0,55	0,59	0,62	0,66	0,69	0,71

Тайлбар:

1.Хүснэгтэнд үзүүлсэн бохир усны цутгалангийн ерөнхий илтгэлцүүрийг үйлдвэрийн бохир усны хэмжээ ерөнхий зардлын 45%-аас хэтрэхгүй байхаар авна.

2.Бохир усны дундаж зардал 5 л/сек-ээс бага бол хамгийн их илтгэлцүүрийг 3 гэж авна.

3.5%-ийн “хангалттай” гэдэгт бохир усны зардал дундажаар хоногийн хугацаанд 1 удаа ихсэх (багасах) боломжийг ойлгоно. 1%-ийн “хангалттай” гэдэгт 5-6 хоногийн хугацаанд 1 удаа ихсэх (багасах) боломжийг ойлгоно.

5.1.8.Шугам сүлжээ, байгууламжийн бохир усны тооцооны зардлыг насосоор татан зайлуулах тохиолдолд түүний бүтээмжтэй тэнцүү авна.

5.1.9.Цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээ, байгууламжийг төсөллөхдөө бохир усны тооцооны зарцуулалтыг жигдрүүлэх техник-эдийн засгийн үндэслэл оновчтой эсэх, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг авч үзвэл зохино.

5.1.10.Бохир усыг дамжуулах шугам сүлжээ,

байгууламжийн хамгийн их тооцооны нийлбэр зардлыг (энэхүү норм ба дүрмийн 5.7 зүйлд тодорхойлсоны дагуу) тооцоолохдоо хөрсний усны шүүрэлтийн нөлөөгөөр бохир усны шугам сүлжээнд болон худгийн тагны зай завсараар нэвчин орох гадаргуугийн ба хөрсний усны цутгаланг нэмж тооцвол зохино. Нэмэлт цутгалангийн хэмжээг $q_{нэм}$, л/сек, тусгай хайгуулын эсвэл ижил төстэй объектын ашиглалтын өгөгдлөөр тэдгээрийг байхгүй бол дараах томъёогоор тодорхойлно:

, (1)

Энд:

L-тухайн байгууламж хүртэлх өөрийн урсгалтай шугамын ерөнхий урт, км

- хоногт орох тунадасны хамгийн их хэмжээ, мм, “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт” БНБД 23-01-09-оос авна.

Ямар ч хэлбэрийн хөндлөн огтлолтой өөрийн урсгалтай хоолой, сувгийн нэмэлт цутгаланг нэвтрүүлэх чадварыг шалгах тооцоог хоолой, сувгийн өндрийн 0.95-тай тэнцүү дүүргэлттэй байхаар тооцох ёстой.

5.2.Ариутгах татуургын сүлжээний гидравлик тооцоо

5.2.1.Ариутгах татуургын өөрийн урсгалтай хоолойн (ховил, суваг мөн хамаарна) гидравлик тооцоог бохир усны тооцооны секундын хамгийн их зардлаар тооцно. Өөрийн урсгалтай коллекторыг төсөллөхөд тавьдаг үндсэн шаардлага нь дамжуулж байгаа бохир усны хөдөлгөөний “өөрөө цэвэрших” хурданд тооцооны зардлыг нэвтрүүлдэг байх нөхцөл юм.

5.2.2.Ариутгах татуургын түрэлттэй хоолойн гидравлик тооцоог “Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж” БНБД 40-02-06-д заасны дагуу гүйцэтгэвэл зохино.

5.2.3.Түүхий ба исгэсэн тунадас, идэвхт лагийг дамжуулах түрэлттэй хоолойн гидравлик тооцоог тэдгээрийн хөдөлгөөний горим, тунадасны бүтцийн онцлог ба физик шинж чанарыг харгалзан гүйцэтгэвэл зохино. Тунадас нь 99% буюу түүнээс дээш чийглэгтэй бол бохир усны хөдөлгөөний хуулинд захирагдана.

5.2.4.150... 400 мм голчтой лаг дамжуулах түрэлттэй хоолойн гидравликийн хэвгийг дараах томъёогоор тодорхойлно:

, (2)

Энд:

-тунадасны чийглэг, %

V-лагийн хөдөлгөөний хурд, м/сек

D-хоолойн голч, м

D_{cm} -хоолойн голч, см



БИЕ МАХБОД УС НЭХЭХ НЬ

Цуврал 7

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ДААВРУУД БА УСГҮЙЖИЛТ

Сэтгэл хямрал усгүйжилтийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл сэтгэл хямрал нь усгүйжилттэй нэг утгатай. Энэ хоёр тохиолдолд бие махбод адилхан хариу үйлдэл үзүүлдэг. Бие махбодыг “дайны бэлэн байдал”-д оруулах арга хэмжээг автоматаар нэн даруй авдаг. Хоол хүнсэн дэх усны нөөц нь дайны үеийн хуулиар хуваарилагддаг. Энэ нь хэрхэн явагддаг вэ?. Системийн шуурхай удирдлага өөртөө 5 гол тохируулагчийг авдаг. Тохируулагч тус бүр химийн гинжин урвалын туслажтайгаар янз бүрийн ажиллах горимыг заах нууц кодтой байна

ВАЗОПРЕССИН

Вазопрессин нь усны дутагдлын талаар дохио өгч, гол жагсаалтын дагуу тодорхой эсийн дотор ус хүргэхийг нормчилдог. Тэрээр эсийн бүрхүүлд бичил нүх нээж, хүчээр усыг эсийн бүрхүүл руу түлхэж оруулдаг ба вазопрессинд мэдрэг эс бусдыгаа бодвол давуу эрхтэй байдаг. Энэ нь булчингинн эд, өөх тос задарч цусны өтгөрөл нэмэгдэх үед тархи, элэг, бөөр бие махбодын бусад эрхтэнүүдийг үр дүнтэй ажиллуулдаг. Бүх үйл ажиллагааг гүйцэтгэхэд хүрэлцээтэй хэмжээний ус байна гэсэн дохио ирэх хүртэл эсэд ус хүргэхийг вазопрессин нь зохицуулдаг. Үүнээс гадна вазопрессин цусны эзэлхүүнд даралт үзүүлж, судаснаас ийлдэс гаргахын тулд артерийн судсыг нарийсгадаг. Энэ нь ийлдсэнд агуулагдах ямар нэг хэмжээний ус эсийн бүрхүүлийн нүхээр дамжин усгүйжсэн эсэд очих боломжийг бий болгодог. Вазопрессин ялгарсныхаа дараа асаах, унтраах зарчмаар ажилладаг кортизоныг чөлөөлөхөд хүчтэй эрчимжүүлэгч болдог. Вазопрессины ийм үйлчилгээ нь бие махбодын нөөцийг хоослох чадвартай метаболизмын асуудлын үед удаан хугацааны усгүйжилт үүсэхэд хүргэдэг.

КОРТИЗОНЫГ ЧӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

Кортизоныг чөлөөлөх хүчин зүйл нь бөөрний дээд булчирхайн дааврыг шүүрүүлэхэд нөлөөлдөг. Кортизон нь уураг, өөх тос, нүүрсусыг тэднийг анхны бүрэлдэхүүнд нь задлаж, зарим

нь тархинд ашиглагдах сахар үүсгэдэг. Эцэстээ энэ үйл ажиллагаа нь бие махбодын нөөцөлсөн чухал аминхүчлүүд болох триптофан, тирозины хуримтлалыг дуусгадаг. Энэ нь нилээд олон өвчин үүсгэдэг. Кортизон нь биеийн дархлааны тогтолцоог шууд дарангуйлдаг. Бие махбод усгүйжсэн болон усгүйжилт үргэжлэх нөхцөлд дархлааны тогтолцоог дарангуйлдгаар энэ механизмын үйлдэл нь тайлбарлагддаг. Кортизоны нөлөөгөөр дархлааны тогтолцоог идэвхжүүлэгч интерферон ба интерлейкин-2-ын боловсруулалт бас зогсонги байдалд ордог. Алдсан чухал элементүүдийг тийм амархан нөхдөггүй. Бие махбод уургийн боловсруулалтанд шаардлагатай нэн чухал аминхүчлүүдийн дутагдалд орох боломжтой. Энэ алдагдлаас зарим нь нөхөгдөх боломжгүй байдаг. Зайлшгүй хэрэгтэй бодисууд цаг хугацаа өнгөрөхөд нөхөгддөг ч урьдынх шигээ байдаггүй. Үүнээс үзэхэд сэтгэл хямралыг арилгахад чиглэсэн булчингийн идэвхжил зайлшгүй шаардлагатай бөгөөд алхах, алхах бас дахин дахин алхах нь хэрэгтэй. Сэтгэл хямралын физиологийн үр дагаврыг арилгахад уух усаа нэмэгдүүлэх нь бүр их чухал.

ЭНДОРФИНҮҮД

Эндорфинүүд-биемахбодын өвдөлтийг хурдан намдаадаг байгалийн гаралтай мансууруулагч бодис юм. Сэтгэл хямралын үед, эсвэл гэмтлийн дараа эндорфины чөлөөлөгддөг. Үүнд цус алдалт, хүчтэй өвдөлт мөн нөлөөлдөг. Хүний тэвчиж чадах өвдөлтийн босгыг эндорфин нэмэгдүүлдэг ба биеийн гэмтлийг анзаарахгүй эцсээ хүртэл үр дүнтэй ажилладаг. Эндорфин чөлөөлөгдсөний ачаар холын зайн гүйлтээ үргэлжлүүлж чаддаг. Гэмтэл байхгүй бол эндорфиныг чөлөөлөх явц нь баярлах, таашаал авах мэдрэмжийг бий болгодог. Эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн болон хүүхэд төрүүлэх үедээ эндорфины өвчин намдаах үйл ажиллагаанаас ихэнхдээ хүчтэй хамаардаг. Эмэгтэйчүүдийн эндорфиныг идэвхжүүлэх чадвар үеэс үед удамшуулан дамжигддаг. Биологийн төрлийн бүх эм амьтад ялангуяа, хүнд энэ нь хромосомын кодын хэсэг болсон. Иймээс эмэгтэйчүүд өвдөлтийг эрэгтэйчүүдээс илүү дааж, тэднээс урт насалдаг.



Спирт-энэ нь усгүйжүүлэгч нэгдэл. Үүний зэрэгцээ вазопрессины идэвхийг бууруулж, бүр их усгүйжүүлдэг. Эмэгтэйчүүдэд спирт нь эндорфин чөлөөлөхийг өдөөдөг. Хэдий чинээ спирт их авна эсийн усгүйжилтийн үр дүнд төдий чинээ эндорфины түвшин нэмэгддэг.

Спиртийн дасал болгох чадвар – энэ нь юуны түрүүнд усгүйжилтийн өсөн нэмэгдэх үйл явцад эндорфин чөлөөлөгдсөний үр дагавар байдаг. Иймээс спиртийн нөлөөгөөр үүссэн сэтгэл хямралын үед эмэгтэйчүүдийн бие махбодод эндорфин ялгарч, идэвхиждэг ба тэд эрэгтэйчүүдээс илүү хурдан спиртэнд дасал болдог. Магадгүй, ийм учраас эмэгтэйчүүд 2-3 жилийн дотор архинд ордог байхад эрэгтэйчүүдэд 7 жил шаардлагатай байдаг байна.

РЕНИН-АНГИОТЕНЗИН (РА)

РА нь бие махбодыг давсны хэрэглээнд дасал болгож, түүнийг эсийн гаднах хэсгийн ханасан усанд хуримтлагдахыг шахаж, усыг хуваарилах болон тогтоон барих асуудлыг хариуцдаг. Мөн биеийн чухал хэсгүүдэд цус хүргэх захын зарим цусны судаснуудыг хаах үүрэгтэй байдаг. Үүнээс гадна, шээсний хэмжээг ихэсгэх үүрэгтэй. РА биеийн ус хадгалах үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг бөөрөнд боловсрогддог. РА нь даралт бууруулах бэлдмэл үйлдвэрлэдэг эмийн үйлдвэрийн чухал түүхий эд юм. Бөөрөөр илүүдлийг нь хөөн гаргаж болох тогтолцоонд ус их өгөхийн оронд РА-ны хүчээр давсыг тогтоон барих химийн бодис хүмүүст санал болгодог.

ПРОЛАКТИН

Пролактин нь сүүний булчирхайн эсүүдийг эрчимжүүлж, сүү боловсруулахыг хариуцдаг. Бусад даавруудын хамт тэрээр үйл явцыг нөхөн үржихүйн эрхтэнүүдийг дэмжих үйл явцыг зохицуулж, ажиллагаатай байлгадаг. Сүү нь ус шүүрүүлдэг булчирхайн эдэд боловсордог ба энэ ус, сүү шүүрүүлэх чадварыг хөгжүүлэх нь чухал байдаг. Булчирхайны эсүүдийг идэвхижүүлж, шүүрүүлэх шинж чанарт нь дэмжлэг олгох хэрэгтэй. Хэрэв ийм эс бий болж, ажиллаж байгаа бол тэдний идэвхийг тогтоон барих хэрэгтэй. Сэтгэл хямралын үед усны хуваарилалтын тогтолцоо идэвхжиж, үр төлөө тэжээхийн тулд сүү ялгаруулах нь илүү болдог. Сэтгэл хямрал маш ихтэй үед пролактины сүү боловсруулалтыг эрчимжүүлэх чадвар хүрэлцэхгүй

болж, сүү ялгарахаа больдог. Энэ үйл явцад тэнцвэрийг барих механизм үйлчилдэг. Архаг усгүйжилтийн болон удаан хугацааны хөнгөн сэтгэл хямралын үед пролактины боловсруулалтын хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор сүүний булчирхайн эдэд байнгын тогтвортой үйлчлэл үзүүлдэг. Хэрэв хөх бүрэн хөгжсөн, сүү ялгаруулж байсан туршлагатай бол түүний үр дүнд нь булчирхайн эд томордог. Хэрэв хөх хөгжиж эхлээгүй байхад буюу түүний сүү ялгаруулж сурах цагаас хойш сэтгэл хямрал болох хүртэл их хугацаа өнгөрсөн бол сэтгэл хямралаар үүсгэгдсэн пролактины боловсруулалт ихсэж, аденоцистом үүсгэдэг. Сэтгэл хямрал болон усгүйжилттэй холбоотой пролактин боловсруулалт ихсэх нь эцэстээ хоргүй хавдрыг хортой болгон хувиргадаг. Энэ үед усгүйжилт болон уургийн алдагдал нь хавдрын эсрэг эсийн хамгаалах, хянах тогтолцоог дарангуйлахад хүргэдэг.

Их хэмжээний кортизон чөлөөлөгдсөний үр дүнд интерфероны ялгаруулалт буурч, дархлааны тогтолцоо дарангуйлагддаг. Олон эмэгтэйчүүдийн хөхний хавдар нь сэтгэл хямралаар үүсгэгдсэн архаг усгүйжилтийн үр дагавар гэдэг саналыг дэмжиж байна.

СЭТГЭЛ ГУТРАЛ БА АРХАГ ЯДАРГААНЫ ХАМ ШИНЖ

Тархи нь цахилгаан үүсгүүрийн шахуургаар ус өнгөрөхөд боловсруулагддаг их хэмжээний цахилгаан эрчим хүч ашигладаг талаар өмнө нь дурдсан. Усгүйжилтийн үед тархинд эрчим хүч боловсруулах түвшин багасдаг. АТФ-ын эрчим хүчний нөөц аажмаар багасдаг ба зарим хэсэгт бусдаас илүү байдаг. Үүний үр дүнд усан цахилгаан эрчим хүчнээс хамааралтай тархины олон үйл ажиллагаа гэмтдэг. Бид энэ ажиллах чадвараа алдахыг сэтгэл гутрал гэж нэрлэдэг. Энэ нь хүний бие махбодод хөдөлгүүрийн хурдасгууртай бараг адил байдаг байна. Маш их хурдтайгаар онгоц, машин хөөх гэж түлш шатаах хурдасгуурийн систем адил хурдан ба үр дүнгүй байдаг. Кофеин нь бие махбодоос АТФ –ыг эрчимтэй хэрэглэхийг шаарддаг. Кофеин агуулдаг кофе, цай, бусад ундаанууд нь тархийг АТФ-ын энергийг илүү зарцуулахад хүргэдэг. Тархи эцсийн мөчид ашиглах бага зэргийн эрчим хүчийг нөөцөндөө үргэлж хадгалж байдаг ба түүний холын зайн гүйлтийн замын сүүлчийн км -т мэдэрдэг. Үүний зэрэгцээ кофеин нь бие махбодыг усгүйжүүлдэг. Нэг аяга цай, кофе, стакан согтууруулах ундаа нь түүнд агуулагдах



шингэнээс илүү их хэмжээний шингэнийг биеэс гадагшлуулахад нөлөөлдөг. Халуун кофе, цай уусны дараа биеийн хэмийг бууруулах оролдлого нь бүр их усыг хөлс хэлбэрээр ялгаруулдаг. Цай уух дуртай хүмүүс байнга ам нь цангаж байдаг ба тэд түүнийг үргэлжүүлэн уусаар байдаг. АТФ-ын бага түвшин нь ердийн нөхцөлд эрчим хүчний түвшин тогтвортой, удаан хугацаагаар багассаныг илэрхийлдэг. Аккумуляторын цэнэг дуусч буйг илэрхийлэх энэ дохио нь хамгаалалтын тогтолцоог өдөөж, эс дэх АТФ-ын нөөцийг хэтрүүлэн зарцуулахгүй болгодог. Эс бүрт ядрах өөрийн хязгаарлагчтай байдаг. Түүний ачаар эрчим хүч шатаахад ядарсан эсэд өмнөхөөс илүү хүчтэй эрчимжүүлэгч хэрэгтэй болдог. Үүний үр дүнд тархи АТФ-ын эрчим хүчний хадгалалтанд хүрэх боломжоо хасуулж, үр дүн багатай дэглэмд үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай болдог. АТФ-ын хадгалалтаас гарах эрчим хүчийг зарцуулах болон зарцуулагдсан эрчим хүчийг нөхөн төлжүүлэх хоёрын хоорондох хугацааны талаар мартаж болохгүй. Яагаад тархи хэсэг хугацаанд үр дүн багатай ажилладаг болохыг энэ хугацаа тайлбарладаг. Кофеин болон бусад химийн эрчимжүүлэгчид нь АТФ-ын зарцуулалтын үзүүлэлт дохио бүртгэх түвшинг бууруулдаг. Эцэстээ энэ эрчимжүүлэгчид нь АТФ-ыг хянах тогтолцооны хязгаарлалтыг давж чаддаггүй ба, учир нь энэ үед гаднах ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй хэрэгтэй АТФ бараг үлдээгүй байдаг. Ийм үед эс амьдрахын тулд өөрийн ихэнх үйл ажиллагаануудаа зогсоохоос өөр аргагүйд хүрдэг. Бие махбод оюуны болон биеийн хөдөлмөрийн үед тархины эрчим хүчийг ашиглах чадвараа илүү ихээр алдахад хүн идэвхигүй болдог. Сэтгэл гутрал шиг эхэлсэн зүйл ядаргаанд хувирдаг. Харин үүн дээр усгүйжилт нэмэгдэхэд төрөл бүрийн өвчний шинж тэмдэг, хүчин зүйлүүдийн нэгдэл болдог ба үүнийг архаг ядаргааны хам шинж гэж нэрлэдэг. Энэ нэр томъёо нь харьцуулж болмооргүй өвчин, шинж тэмдгүүдийн нэгдлийг илэрхийлдэг. Дэлхийн янз бүрийн орнуудад энэ нэгдлийг “виурсийн халдвараар өвчилсний дараах “ядаргааны хам шинж”, нейромиастения, миалгический нейроэнцефаломиелит гэж янз бүрээр хэлдэг байна. Урьд өмнөх буруу ойлголтын улмаас архаг ядаргааны хам шинжийг Эпштейн-Баррын вирусээр үүсгэгддэг гэж үздэг байсан. Сэтгэл хямрал, архаг ядаргааны хам шинж хоёр хоорондоо шууд хамааралтай. Үүнийг вирусын өвчин гэж үздэг хүмүүст миний бичсэн “Багтраа, харшил, арьсны сүрьеэгийн анхны шинж тэмдэг” гэсэн номны арьсны сүрьеэгийн хэсгийг уншихыг зөвлөж байна. Түүн дээр усгүйжилт нь зарим эсийн

ДНХ-ийг буталж жижиг хэсэгт хуваадаг ба үүнийг вирус хэмээн андуурдаг байсан.

Хүний бие махбод нь эдийг шинээр бий болгох, бүрэлдсэн бүтцийг эвдэж, түүнийг дахин боловсруулалтын түүхий эд болгон ашиглах чадвартай химийн тогтолцооны нэгдэл гэдгийг мартаж болохгүй. Тархинаас бусад бие махбодын нэг ч хэсэг түүн шиг халдашгүй байдаггүй ба бүр булчингийн эд хүртэл аминхүчлийн нөөцийг дүүргэхийн тулд задардаг. Энэ нь байнгын сэтгэл хямрал болон амьдралын буруу хэв маягийн үед явагддаг. Сэтгэл хямралын үед дэх санаа зоволт, эсвэл вирусын халдвартай тэмцсэнээс үүссэн эсэх нь хамаагүй байдаг. Усгүйжилт, сэтгэл хямрал болон биеийн тамирын дасгал хөдөлгөөнгүйгээр хоолны дэглэм сахих зэрэг нь миний үзэж байгаагаар архаг ядаргааны үндэс болдог. Ялангуяа кофе, спирт зэрэг сэргээх ундааны тусламжтай бие махбодын усны дутагдлыг арилгахыг оролдох нь үүнд нөлөөлдөг. Бие махбодын нэг чухал хэрэгцээтэй зүйл нь давс байдаг. Усгүйжилтийн үе дэх давсгүй хоолны дэглэм нь бие махбод дах давсны нөөцийг багасгадаг. Давс нь булчингийн болон мэдрэлийн үйл ажиллагаанд зайлшгүй чухал хэрэгтэй бүтээгдэхүүн. Халуун уур амьсгалтай оронд их хөлрөх нь давсны дутагдалд оруулдаг. Давсны дутагдлын хамгийн түгээмэл тохиолддог шинж тэмдэг нь ямар нэг үйл ажиллагаа гүйцэтгэхэд эрчим хүч хүрэлцдэггүй явдал юм. Өөр нэг шинж тэмдэг нь булчингийн өвдөлт болон таталт байдаг. Архаг ядаргааны шинж тэмдэгтэй хүмүүс нь усны хэрэглээгээ нэгэн зэрэг давсны хэрэглээгээтэйгээ нэмэгдүүлэх хэрэгтэй ба энэ үед кофеин агуулсан сэргээх ундаанаас бүрэн татгалзах шаардлагатай. Тэдэнд АТФ-ын нөөцийг сэргээх, түүнийг мэдрэлийн ширхэгүүдэд хүргэх тогтолцооны бүрэн амрахад хэсэг хугацаа өгөх хэрэгтэй.

ХУУРАЙШИЛТ БА НҮД ХОРСОХ

Нүдний хэвийн үйл ажиллагаанд нулимс боловсруулах нь зайлшгүй хэрэгтэй байдаг. Зарим хүмүүст нь энэ үйл ажиллагаа нь сайн хөгжөөгүй байдаг ба тэдэнд нүд хорсох мэдрэмж төрдөг. Нүдийг байнга цавчих нь нүдний булчирхайн цусан хамгамжийг сайжруулдаг. Хэрэв энэ нь тус болохгүй бол ууршилтаар ус алдахгүйн тулд нүдийг аних шаардлагатай болдог. Зарим хүмүүс над шиг нүүрний мэдрэлийн үрэвслээр өвчилж нүүрний булчингийн мэдээ алдалтаар шаналахад энэ нь ихэнхдээ нулимс үүсэхэд нөлөөлдөг. Мэдээгүй болсон талын нүд нь булчин өөрийн ажиллах



чадвараа байнга сэргээж байхад ч нөгөө нүднээсээ илүү хуурайшдаг. Өөрийн туршлагаас хэлэхэд нүдээ нухаад ч нулимс гаргаж, чийглэж болохгүй байхад 2 аяга ус ууснаар энэ бүх таагүй мэдрэмжээс хурдан салдаг. Нүдний хорсолт болон өвдөлт хэдэн минутын дараа алга болдог. Нулимсаа албаар гаргах, ус оруулж нүдээ байнга угаах нь бас тус болдог.

ЦУСАН ДАХ ХОЛЕСТЕРИНЫ ӨНДӨР АГУУЛАМЖ

Холестерин нэмэгдэх нь зүрх болон тархины өвчин үүсгэх анхны шинж тэмдэг гэдгийг өнөөдөр хүн бүр мэддэг болсон. 1987 онд Грект болсон хорт хавдар судлалын олон улсын эрдэм шинжилгээний бага хурал дээр би архаг усгүйжилтийн шууд нөлөөгөөр бие махбод дах холестерин боловсруулалт нэмэгддэг гэсэн эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн юм. Хүрээлэн буй орчны нөхцөл таагүй байхад эс бүрийн генийн бүтэц нь эсэд тусдаа бие даан ажиллах боломж олгодог гэж үзье. Хүний бие махбодын эс бактеритай адил хүрээлэн буй орчинд өөрийн бүрхүүлийн бүтэцээ өөрчилж дасан зохицох чадвартай байдаг. Ийм маягаар дотогш болон гадагш хяналтгүй шүүгдэх усыг зогсоохын тулд эсийн бүрхүүл дэх холестерин агууламжийг өөрчилдөг. Хэвийн нөхцөлд ус нь эсэд тогтвортой, удаан шингэж нэвчих ёстой. Үүнээс гадна, эсэд илүүдэл уснаас салах механизм байдаг. Гэвч хүрээлэн буй орчин нь хэт хуурай болж доторх усыг тогтоон барих хэрэгтэй үед эс бүрхүүлээ битүүмжилдэг буюу хаадаг. Бүрхүүлийн бүтэц дэх холестерин нөөц нь хаалтын үүрэг гүйцэтгэж, бүрхүүл дэх ус нэвчих нүхүүдийг бөглөдөг. Хэвийн нөхцөлд хоол хүнс хүлээж авахад ходоод гэдсэнд ус, фермент орж байх ёстой. Ферментүүд нь хоолны хэсгийг жижиглэж задалдаг ба уургийн бүтцийг бүрдүүлэх аминхүчлүүдийн нэгдлүүдийн олон тооны цэг бүрт нэг молекул усыг нэвтрүүлдэг. Энэ үйл ажиллагааг гүйцэтгэхийн тулд чөлөөт ус ашигладаг. Үүний үр дүнд бие махбодод ус багасаж, цусны эргэлтийн систем болон лимфын тогтолцоонд авчрах хэрэгтэй уусдаг хатуу материалууд ихэсдэг. Хоол боловсруулах үйл явцын үр дүнд ходоодноос гарч элгэнд очих цусны өтгөрөлт нэмэгддэг. Тэнцвэржсэн цус зүрхэнд очсоны дараа элгэнд хоолны хэсгийг хураадаг. Дараа нь тийшээ лимф юүлэгддэг. Эхний ээлжинд цусны эргэлтийн тогтолцоо нь энэ өтгөрсөн цусыг уушигны эд рүү явуулдаг. Тэнд эргэлдэх цус амьсгалын уур хэлбэрээр усаа ямар нэгэн хэмжээгээр алддаг

байна. Дараа нь энэ өтгөрсөн цус даралтын нөлөөгөөр гадагшилдаг. Тэрээр зүрх тэжээдэг артериар, дараа нь тархины артериар өнгөрч, сүүлд нь гол артери болох гол судас руу чиглэдэг. Энэ өтгөрсөн цус тархины төвд хүрч, тархинд бие махбод усаар дутагдаж буйг мэдээлдэг. Цангаж буй тухай түгшүүрийн дохио өгөгдсөнөөр хүн ус уух хэрэгтэйг мэдэрдэг. Ус уусны дараа өтгөрсөн цус нь элэгний эс ба артерийн доторх бүрхүүлтэй харилцах хүртэл багагүй хугацаа өнгөрдөг. Энэ хооронд өтгөрсөн цустай харилцдаг эсүүд болох элэгний болон артерийн доторх бүрхүүлийн эсүүдэд холестеринийг дайчлах команд өгөгддөг. Яваандаа, судасны дотор хананд холестеринийг боловсруулж хуримтлуулах физиологийн загвар бий болдог. Холестерин боловсруулах чадваргүй эс өөрийгөө хамгаалах ганц арга бол эргэж буй цуснаас холестерин авч өөрийн бүрхүүлд хуримтлуулах юм. Холестерин түвшин нэмэгдэх нь -биеийн эс цусны хүчтэй осмосын үйлчлэлээс хамгаалах механизм ажиллуулсны шинж тэмдэг байдаг. Өтгөрсөн цус мембранаар дамжуулан өөртөө зайлшгүй хэрэгтэй усыг эсээс авахыг хичээдэг. Холестерин нь эсийн бүрхүүл дэх нүхийг бөглөж, түүний архитектурыг хөндөлгүй хамгаалахад тусалж, усны хэт их алдалтыг зогсоодог байгалийн ус нэвтэрдэггүй нэг төрлийн шавар юм. Архаг усгүйжилтийн үед элэгний эс нэмэлт холестерин боловсруулж, түүнийг холестеринээ боловсруулах чадваргүй бусад эсэд ашиглуулахын тулд цусны эргэлтийн тогтолцоонд оруулдаг. Үүнээс гадна, хэвийн усжсан эсэд ус хоёр чиглэлээр чөлөөтэй нэвчдэг байхад нэмэлт холестерин нь эсийн ханыг ус нэвтрэхгүй болгодог. Элэг болон артерийн доторх эсээр илүүдэл холестерин хуримтлуулахыг арилгахын тулд та хоол идэхээс 30 минутын өмнө хүрэлцээтэй усыг тогтмол уух ёстой. Үүний ачаар хоолны дараа өтгөрсөн цустай дайралдахын өмнө эсүүд усаар ханаж авдаг. Үүнээс гадна, энэ ус нь хоол шингээх ба амьсгалах үйл ажиллагааг хангадаг. Хэсэг хугацааны турш өдөр тутмын усны хэрэглээгээ тогтмолжуулахад эс аажмаар усаар бүрэн ханаж, холестериноос хамгаалах хэрэгцээ багасан, түүний боловсруулалт буурдаг. Энэ мэдээллийн үндсэн дээрээс холестерин хэвийн түвшин нь одоогийн аюулгүй гэж байгаа хэмжээнээс бага байх боломжтой байна. Цусны эргэлтийн тогтолцоон дах холестерин хэмжээг үр дүнтэй бууруулах нь бий болсон хуримтлалыг арилгахад тус болдог гэдэг нь одоо бол тодорхой болсон зүйл. Тархины судасны бичлэгээр гол судсанд нь хэсэгчлэн бөглөрөл үүссэн 40 гаруй насны нэг эрэгтэйд би зөвлөгөө өгсөн



юм. Бөглөрөл нь маш их болсны улмаас түүний цээж өвдөж байсан. Би түүнд тогтсон эмчилгээ хийлгэглээ титэм судасны цэвэрлэгээ хийлгэхгүй байхыг зөвлөсөн. Тэрээр өдрийн усны хэрэглээгээ тогтмолжуулахыг зөвшөөрч, хоол идэхээс 30 минутын 2 аяга (0,5л) ус ууж эхэлсэн. Би мөн түүнд өглөө, оройдоо (эхлээд 20-30 минут, аажмаар ихэсгэж 1 цаг) алхаж байхыг зөвлөсөн. Би түүнд өөх шатаах ферментүүд алхсанаас 1 цагийн дараа идэвхждэг ба 12 цагийн турш идэвхитэй байдаг талаар судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээс тайлбарлаж өгсөн. Иймээс өдөрт 2 удаа явган явахад та өөх шатаах ферментийг идэвхжүүлж, түүний үйл ажиллагааны хуримтлуулсан үр дүнд хүрдэг. Энэ хүн 3 сарын дараа Хьюстон дах нэгэн нэртэй төв эмнэлэгт судасны цэвэрлэгээ хийлгэх эсэхээ үзүүлэхээр очсон юм. Дахин хийсэн тархины судасны бичлэгээр ямар ч бөглөрөлийн шинж тэмдэг байхгүй байгааг илрүүлээгүйгээс хагалгаа хийлгэх хэрэггүй болсон.

ТИТЭМ СУДАСНЫ ӨВЧИН

Холестерины боловсруулалт ба түүний титэм судсан дах хуримтлалын талаар өмнөх бүлэгт дурдсан билээ. Үүн дээр нэмээд байх нэг юм алга. Зүрхний өвчний өөр нэг үндсэн шалтгаан нь удаан хугацааны турш даралт ихсэх, өтгөрсөн цусны эргэлдэх үйлчлэл гэдгийг бид анхааралдаа авах юм бол нэг мэдээллийн тусламжтайгаар титэм судасны өвчин, цус харвалтын шалтгааныг тайлбарлаж болно. Үнэндээ, усгүйжилтийн үед усаар хангах тогтолцоо нэн чухал эсүүдийг усжуулж эхлэх хүртэл бие махбодын бүх эсүүд янз бүрийн түвшинд нэг ижил асуудалтай тулгардаг. Зүрх нь усгүйжилттэй холбоотой асуудлын гадна үлддэггүй. Тэрээр ажиллах чадвараа алдсаны улмаас доголдож эхэлдэг. Ихэнхдээ үйл явц агшилтаас эхэлж, дараа нь бага артерийн түгжрэл бий болдог. Эхний агшилт нь өвдөлт өгдөг. Яг энэ үед өвчтөнд нь шууд ус өгвөл агшилт нь зогсож, артерийн байнгын түгжрэлээс зайлсхийж болдог. Ямар ч үед өвчтөнд ус хурдан өгөх нь эм ууснаас хамаагүй дээр байдаг. Ингэснээр ядаж гэмтлийн хэмжээг багасгадаг. Үүнээс гадна, цусанд холестерин их байх нь ясны нягтралаа алдсаны шинж тэмдэг. Дэлгэрэнгүй мэдээллийг “Цусан дах холестерин өндөр түвшин” ба “Ясны сийрэгжилт” гэсэн хэсгүүдээс олж унших боломжтой.

Үргэлжлэл
дараагийн
дугаарт



ЧИМЭЭГҮЙ ТАХАЛТАЙ ӨДӨР БҮР ТЭМЦ, ТЭГВЭЛ ЧИ ЯЛНА

“Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөр” жил бүрийн арваннэгдүгээр сарын 14-нд тохидог. XIX зууны сүүлчээр “Diabetes mellitus” буюу чихрийн шижин өвчин дэлхий нийтийг айлгах болж. Хэт таргалалтын учир шалтгаан нь эл өвчинтэй холбоотой байна. Дэлхий дээр эл өвчнөөс болж найман секунд тутамд нэг хүн хорвоог орхиж байгаа гэсэн тоон мэдээлэл байна. Өдгөө тус өвчний тархалт дэлхийн хэмжээнд өсөж, өвчлөл нас баралтаараа зүрх судас, хорт хавдрын дараа орж байгаа гэсэн түгшүүртэй мэдээг өчигдөр сонслоо.

ДЭМБ-ийн статистикийн мэдээнээс үзэхэд чихрийн шижин өвчний тархалт 15 жил тутамд хоёр дахин нэмэгдсэн байна. 2010 оны байдлаар цэнхэр гариг дээр 285 сая хүн ийм төрлийн өвчнөөр өвчлөөд байгаа бол 2030 он гэхэд 436 саяд хүрэх магадлалтайг Олон улсын диабетийн холбооноос мэдэгдсэн ажээ.

Дэлхий нийт уг өвчлөлийн хурдыг сааруулж, урьдчилан сэргийлэхийн тулд зохистой хооллолт, хөдөлгөөнийг илүүд үзэх болжээ. Их Британи улс чихрийн шижинтэй иргэддээ цусан дахь сахар хэмжих аппараттыг үнэгүй олгож, зөв хооллолт, хөдөлгөөнтэй байдлыг эрэлхийлэх болсон байна. Харин монголчууд чихрийн шижинтэй хэрхэн тэмцэж байгаа билээ.

Өвдөхгүйн тулд давсны хэрэглээгээ багасгахыг эмч зөвлөж байна

“Цусан дахь сахарын хэмжээг ихэсгэдэг бодисын солилцооны өвчнийг чихрийн шижин гэнэ” хэмээн Диабетийн төвөөс гаргасан эмхэтгэлд тэмдэглэжээ. ЭМЯ, Монголын мянганы сорилтын сангийн Эрүүл мэндийн төслөөс “Зохистой



хооллолт, идэвхтэй хөдөлгөөн” олон нийтийн кампанит ажлын хүрээнд “Амьдралын зөв хэвшилд алхам алхмаар” зөвлөмжийг гаргажээ.

Үүнд тэмдэглэснээр насанд хүрсэн хүн бүр хоногт 25 грамм эслэг бүтээгдэхүүн хэрэглэвэл зохимжтой хэмээн үзжээ. Эслэг бүтээгдэхүүнд хоёрдугаар гурил, хивэг зэрэг аль болох химийн найрлага төдийлэн ороогүй зүйл багтах нь. Мөн төрөл бүрийн жимс, хүнсний ногоо нь зохистой хооллолтын суурь бүтээгдэхүүн болохыг онцолсон байна.

Өдөрт дор хаяж таван удаа жимс, ногоо идэх хэрэгтэй болохыг ч зөвлөжээ. Хэдий бид “хүнд хоол” буюу махан хоолыг түлхүү хэрэглэдэг ч эрүүл хооллолтод дадаж хэвших шаардлага тулгарч байна.

Хар чавга, алим, лийр, өргөст хэмх, лууван, үзэм зэргийг хоол хүнсэндээ хэрэглэж байхыг ч эмч зөвлөж байна лээ.

Чихрийн шижин өвчнөөс урьдчилсан сэргийлэхийн тулд доорх зөвлөгөөг хүргэе.

1. Идэвхтэй хөдөлгөөнтэй байх, өдөр бүр хамгийн багадаа 30 минут алхаж, гүйх. Спортоор тогтмол хичээллэж байх.
2. Хоолондоо давс бага хэрэглэж цайгаа давсгүй уух
3. Архи, тамхины хэрэглээг хязгаарлах
4. Хоолондоо мал, амьтны гаралтай өөх, тосыг бага хэрэглэж хэвших
5. Төмснөөс бусад ногоог хоолондоо түлхүү хэрэглэх
6. Биеийн жин хэвийн эсэхээ шалгаж байх

Яагаад чихрийн шижингээр өвчилдөг вэ?

Чихэр, сахар их идэж хэрэглээгүй атал яагаад чихрийн шижин өвчинтэй болдог билээ хэмээн ихэнх иргэд гайхширдаг. Гэтэл уг өвчин нь чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн их хэрэглэхээс илүүтэй, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй болохыг эмч нар хэлж байна. Зохисгүй хооллолт, сэтгэл гутрал, таргалалт, удамшил, тамхи татах, архи хэтрүүлэн хэрэглэх, хөдөлгөөний хомсдол нь чихрийн өвчинд өртөх суурь шалтгаан болдог ажээ. Чихрийн шижин өвчний талаар “Ногоон нүдэн лам”-ын зохиогч Ц.Оюунгэрэл “Гэртээ болсон яриа” номондоо дэлгэрэнгүй өгүүлсэн байна билээ.

Хэрэв Та өвчилсөн бол дараах зөвлөгөөг анхаарна уу

“Нийгмийн бухимдал, хотжилт, ажлын стресс, хэт суугаа ажил эрхлэлт, ажилгүйдэл, хүнс тэжээл дэх байгалийн гаралтай хүнсний хэрэглээ багасаж байгаа нь мөн л дээрх өвчний тархалт дэгдэхэд нөлөөлж байна” хэмээн Улсын клиникийн төв эмнэлэгийн Дотоод шүүрэл булчирхайн эмч Ц.Бодьцэцэг хэлсэн юм. Тэрбээр уламжлалт хооллолтын соёл алдагдаж байгаа нь сахарын өвчлөл нэмэгдэх шалтгаан болж байгааг санууллаа.

Бид өвдөж, ёолох үедээ л эмнэлэг, эмч хоёрыг санадаг. Унаж, сөхөртлөө ажиллаж, бодгаль биеэ төмөр мэт бодох нь энүүхэнд. Хожим нь эрүүл мэнд хэмээх том хөрөнгөө алдсан байх нь харамсаад ч барамгүй. Тиймээс өвдөхөөсөө өмнө эмнэлэг, эмч хоёртой “найз” баймаар санагдлаа.

Чихрийн шижингээр өвчилсөн монгол хүний тоо өдгөө 20 дахин нэмэгдсэн байна. 1999 онд үндэсний хэмжээний тархалтын судалгаагаар хүн амын гурван хувь нь ийм төрлийн өвчтэй байсан бол 2009 оны судалгаагаар 6.5 хувьд хүрээд байгаа аж. Арван жилийн дотор уг өвчлөл эрүүл мэндийн тулгамдсан асуудал болсныг харуулах том тоо байгаа биз.

Сүүлийн жилүүдэд эдийн засаг өсөж, иргэдийн орлого нэмэгдэж, цалин тэтгэвэр өссөн хэдий ч өвчлөл буураагүй 20 дахин нэмэгдсэн байгаа нь анхаарал татлаа. Манай улсын хувьд өнгөрсөн дөрвөн жилд “Чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх” уриатай ажилласан байдаг.

Олсон хэдэн төгрөгийнхөө хэчнээн хувийг нь бид эрүүл байхад зарцуулж байгаа билээ гэж бодоход хүрлээ. Хамрын ханиад хүрэхэд эм тан сурагласан болоод хагас дутуу эдгээх нь монгол зан байж мэдэх. Үнэт биеэ үнэгүй үрэх, үл хайрлах нь даан ч бидний дутагдал гэмээр. Өвдөхгүй л бол эрүүл гэсэн онош өөртөө тавьдаг. Идэх, идэхгүй хоол хүнс хэрэглэнэ. Болж өгвөл эмнэлгээс “зугатна”.

Эмнэлэгийн үйлчилгээг муулж, чичлэхээсээ илүүтэй иргэд өөрсдийнхөө эрүүл мэнддээ анхаарах нь чухал.

Сэтгүүлч: Б.Баяртогтох